



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Аймгийн Боловсрол, соёлын салбарын үйл ажиллагаа,
төсөв санхүүгийн үр дүн



2016 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймгийн аудитын газар Тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо Аудитын менежер Б.Сарантуяа Ахлах аудитор Д.Оюунбат Ахлах аудитор Ц.Батсайхан Аудитор Г.Наранбаяр Аудитор Л.Отгонпүрэв 2016 оны 11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 БҮЛЭГ1: Боловсрол, соёлын салбарын төсвийг үнэн, зөв төлөвлөж, батлуулдаггүй, төсвийн хуваарилалтад ил тод, тэгш хуваарилалтын зарчмыг баримтлаагүйгээс салбарын байгууллагуудын төсөвт жилд 7-8 удаа өөрчлөлт орсон боловч эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй байна, 1.1 Аймгийн Боловсролын салбарын батлагдсан төсөв 2014-2016 онуудад жил бүр 2.8-8.9 хувиар тус тус өссөн байна. 1.1.1 Баянтал сумын 4 дүгээр сургуулиас бусад ЕБС-ууд стандартын дагуу ашиглавал зохих хүчин чадлаа дунджаар 144.2 хувь буюу 595 хүүхдээр хэтрүүлсэн байгаа нь тус аймагт шинээр 1 ЕБС-ийг барьж, байгуулах шаардлагатай байгааг харуулж байна. 1.1.2 2014-2016 оны хичээлийн жилүүдэд СӨББ-уудад хамрагдах хүүхдийн тоог 250 хүүхдээр илүү тооцож, төсвөө батлуулсан байна. 1.2 ЕБС, СӨББ-уудын 2014-2016 оны зарим хувьсах зардлын батлагдсан төсөв сургалтын болон үйл ажиллагааны стандарт шаардлага хангах хэмжээнд батлагдаагүй байна. 1.2.1 2014-2016 онуудад ЕБС-уудад суралцагчийн тоо жил бүр өссөн боловч хувьсах зардлын төсөв буурч батлагдсан байна. 1.2.2 2014-2016 онд шинээр барьж буй Канад цэцэрлэг, 1 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтад ороогүй байхад үйл ажиллагааны төсвийг нь батлуулсан байна. 1.3 Бараа үйлчилгээний бусад зардлын батлагдсан төсөв ЕБС болон СӨББ-уудын хэвийн үйл ажиллагааг хангахад хүрэлцэхгүй байна. 1.4 2014-2016 онуудад аймгийн Боловсрол, соёлын салбарын хэмжээнд тогтмол зардлыг илүү, дутуу төлөвлөж, батлуулсан байна. 1.4.1 2014-2016 онд ЕБС-уудын тогтмол зардлын төсөв зарим сургуульд илүү, зарим сургуульд дутуу батлагдаж ирсэн байна. 1.4.2 2015 онд СӨББ-уудын төсвийг 6,593.3-34,338.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. 1.5 БСУШЯ-ны Төсвийн ерөнхийлөн захирагчийн хасаж тодотгосон төсвийг аймгийн ИТХ-ын төсвийн тодотголоор нэмэгдүүлэн баталж, хуваарилсан байна. 1.6 Ашиглалтанд ороогүй Канад цэцэрлэгт жил бүр төсөв батлуулан авч, ЕБС болон СӨББ-уудын батлагдсан төсөв дээр нэмж хуваарилаж байгаа нь батлагдсан төсвийг хэтрүүлэх, зориулалт бусаар зарцуулах, төсвийн үр өгөөжийг бууруулах зэрэг сөрөг үр дагаварыг бий болгож байна. 1.7 Аймгийн ЕБС-ууд 2015-2016 оны хичээлийн жилд батлагдсан орон тоог 10 орон тоогоор хэтрүүлэн ажиллаж 139,992.2 мянган төгрөгийн цалингийн өр үүсгэсэн байна. БҮЛЭГ 2: 2015 онд ЕБС болон СӨББ-уудын батлагдсан төсвийн санхүүжилтийг нийт 167,897.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.
--	---

	2.1 2014-2016 онд зарим Боловсрол, соёлын байгууллагуудад батлагдсан төсвийн санхүүжилтийг 233,101.8 мянган төгрөгөөр илүү, 101,125.9-108,299.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна. 2.1.1 ЕБС-уудад 2015 онд батлагдсан төсвийг 83,987.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна. 2.1.2 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилд олгосон төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого, төсөл хөтөлбөрийн хүрээнд олгосон нэмэлт санхүүжилтуудыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна. 2.2.1 Аймгийн БСГ-аас СӨББ-уудын батлагдсан төсвийг 2014 онд 233,101.8 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 17,723.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2015 онд 83,910.0 мянган төгрөгөөр бууруулан хуваарилсан байна. 2.2.2 СӨББ-уудад 2014 онд 1,343,079.2 мянга, 2015 онд 1,458,786.0 мянга, 2016 оны эхний хагас жилд 854,737.1 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгосныг үнэн, зөв бүртгэж, тайлагнасан байна. 2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлсэн орлогыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна. 2.3.1 Аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын батлагдсан төсвийн санхүүжилтийг 2015 онд 18,401.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна. 2.3.2 Соёл, урлагийн зарим байгууллагууд 2015-2016 оны үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нийт 21,028.9 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. 2.3.3 Соёл, урлагийн байгууллагууд 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилд олгосон төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого, төсөл хөтөлбөрийн хүрээнд олгосон нэмэлт орлогуудыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна. БҮЛЭГ 3: Боловсрол, соёлын салбарын хэмжээнд батлагдсан төсвийг 2014-2016 онд 147,920.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. 3.1.1 2015 оноос ЕБС-уудад хэрэгжүүлж буй “Цөм” хөтөлбөртөй холбоотой 8 багш батлагдсан орон тооноос илүү ажиллуулсанаас 61,869.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. 3.1.2 Аймгийн ЕБС-уудын анги дүүргэлт 2014-2015 онд 76.2 хувь байсан бол 2015-2016 оны хичээлийн жилд 78.4 хувь байна. 3.1.3 Аймгийн ЕБС-уудын хэмжээнд тэтгэвэр тогтоолгосон боловч ажиллаж буй 9 багш, ажилтан байна. 3.1.4 ЕБС-уудын үйлчлэгч нарын ажлын хэмжээ, цалин хөлс салбарын хэмжээнд харилцан адилгүй байна. 3.1.5 ЕБС-ууд 2015 оны батлагдсан төсвөөс 147,920.6 мянга, олгосон санхүүжилтээс 232,007.1 мянган төгрөгийн зардлыг илүү зарцуулж, нийт 232,007.1 мянган төгрөгийн, өглөг үүсгэсэн байна. 3.1.6 Нэмэлт санхүүжилтийн дансдад төвлөрүүлсэн 55,619.6 мянган төгрөгийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан байна. 3.1.7 БСШУЯ-аас ЕБС-уудад хэрэгжүүлж буй “Цөм” хөтөлбөр, “Лаборатори” сургуулийн нэмэгдлүүдтэй холбоотой батлагдаагүй цалин, нэмэгдэл урамшууллыг олгосноос цалингийн зардал хэтэрсэн байна.
--	---

	3.1.8 2014-2016 онуудад хүчингүй болсон журмыг үндэслэн эд хариуцагч нарт 2,196.1 мянган төгрөгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг харгалзахгүй хавтгайруулан олгосон байна. 3.1.9 ЕБС-ийн хувьсах зардал тооцдог норм, норматив нь бодит хэрэгцээ шаардлагад нийцээгүй, мөн хүүхдийн үдийн цай хөтөлбөр болон дотуур байрны хоолны материалыг бэлтгэхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөж ажиллаагүй байна. 3.1.10 2014-2016 онд ЕБС-уудын суралцагчдын тоо 58-256-аар нэмэгдсэн боловч хувьсах зардлын зарцуулалт 5,925.7-19,729.5 мянган төгрөгөөр буурсан байна. 3.1.11 ЕБС-ийн тогтмол зардлын төсвийг бодит тоон мэдээлэл, өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэн батлуулж, хуваарилахгүй байгаа нь төсөв хэтрэх гол шалтгаан болжээ. 3.1.12 ЕБС-ууд 2014-2016 оны эхний хагас жилийн байдлаарх өглөгийг үнэн зөв бүртгэж, тайлагнасан, Баянтал сумын 4 дүгээр сургууль 16,012.8 мянган төгрөгийн авлагыг бүртгэл тайланд тусгаагүй байна. 3.2.1 2015-2016 оны хичээлийн жилд аймгийн СӨББ-ын байгууллагуудын батлагдсан орон тооноос 6 багш илүү ажиллуулж, 44,885.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. 3.2.2 Зарим цэцэрлэгүүд 2014-2015 оны үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосноос нийт 14,720.7 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна. 3.2.3 БСГ-аас цэцэрлэгүүдийг нэгдсэн удирдамжаар хангаж ажиллаагүйгээс багш, ажиллагсад олгож буй илүү цагийн хөлсийг цэцэрлэг бүр өөр өөрийн үзэмжээр олгож байна. 3.2.4 СӨББ-ууд 2014-2015, 2016 оны эхний хагас жилийн байдлаарх хувьсах зардлын батлагдсан төсвийг хэмнэж ажилласан байна. 3.2.5 СӨББ-ууд 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар тогтмол зардлын батлагдсан төсвийг хэмнэж ажилласан байна. 3.2.6 СӨББ-уудын халаалтын зардлыг 2015 онд 12,363.7 мянга, 2016 оны эхний хагас жилд 6,322.6 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна. 3.2.7 СӨББ-ууд 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар гэрэл, цахилгаан, цэвэр бохир усны зардлыг тус тус хэмнэж ажилласан байна. 3.2.8 СӨББ-ууд авлага, өглөгийг баталгаажуулан үнэн зөв бүртгэж, тайлагнасан боловч санхүүжилтийг нь бодитой хуваарилаагүйгээс их хэмжээний өртэй гарсан байна. 3.3.1. 2014-2016 онуудад зарим сумдын Соёлын төв батлагдсан орон тооноос илүү ажилтан ажиллуулсан, мөн батлагдсан ажлын байранд мэргэжлийн хүн авч ажиллуулаагүй байна. 3.3.2. 2014-2015 онд Соёл, урлагийн байгууллагууд батлагдсан төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны болон нэмэлт орлогоо бүрэн бүртгэж, тайлагнасан байна. 3.3.3. 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилд батлагдсан төсвөө 4,281.6-43,595.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.
--	---

3.3.4. Соёл, урлагийн зарим байгууллагын санхүүгийн сахилга бат сул байгаагаас цалин, шагнал урамшуулалтай холбоотой 86,108.1 мянган төгрөгийн зөрчил гаргасан байна.

3.3.5. Соёлын байгууллагууд авлага, өглөгийг баталгаажуулан үнэн зөв бүртгэж тайлагнасан байна.

БҮЛЭГ 4: Боловсрол, соёлын газар нь үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлтийг хуулийн дагуу дүгнэж, урамшууллыг зөв тооцож олгоогүй байна.

4.1.1 ЕБС-уудын удирдлага үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулсан байна.

4.1.2 ЕБС-уудад зарим мэргэжлийн багш дутагдалтай байна.

4.2.1 Сүмбэр сумын 2, 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч солигдсоноос шалтгаалан 2015 оны үр дүнгийн гэрээг жилийн эцэст дүгнүүлээгүй байна.

4.2.2 2014-2016 онд аймгийн СӨББ-ууд мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан байна

4.2.3 СӨББ-ууд ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж 1 хувийг ажилтны хувийн хэрэгт хадгалсан байна.

4.2.4 СӨББ-уудын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дотоод журам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг зэрэг бодлогын баримт бичгүүд нь НББОУС болон түүнд нийцүүлэн гаргасан үндэсний стандарт, холбогдох хууль журамд нийцэхгүй байна.

4.3

4.3.1 БСГ-ын удирдлага нь 2014 онд ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулаагүй байна.

4.3.2 Аймгийн Соёл, урлагийнн байгууллагуудын нийт ажилтны 25.6 хувь нь бүрэн дунд буюу курс төгссөн, ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг хангаагүй мэргэжлийн бус ажилчид байна.

БҮЛЭГ 5: Боловсрол, соёлын салбарын дотоод хяналт, шалгалт хангалтгүй байна.

5.1. 2014-2016 онуудад аймгийн БСГ-аас Боловсрол, соёлын салбарын байгууллагуудад хэрэгжүүлж байгаа дотоод хяналт, шалгалт хангалтгүй байна.

5.2. Соёл, урлагийн байгууллагууд аймгийн Аудитын газраас болон Санхүүгийн хяналт, аудитын албаны хийсэн шалгалтын мөрөөр хийх ажил, илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Дүгнэлт.....

Зөвлөмж.....

Холбогдох байгууллагын санал:.....

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Саналд өгсөн тайлбар

Хавсралтууд

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт: Аймгийн Боловсрол, соёлын салбарын үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ: Аудитад аймгийн Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, бүтэц, орон тоо, боловсон хүчний судалгаа, 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн статистик мэдээ, үр дүнгийн гэрээ, гэрээний дүгнэлт, үнэлгээний хуудас, төсвийн төлөвлөлт, төсвийн хуваарь, санхүүгийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад материалуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй: Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, харьцуулан шинжлэх, түүвэрчлэн шалгах зэрэг сорил, горимуудыг хэрэгжүүлэн эрсдэлийг илрүүлж, үнэлэх зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Үндсэн мэдээлэл:

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёлын газар нь тус аймгийн нутаг дэвсгэр дээрх хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, соёлын байгууллагуудад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, Боловсрол, соёлын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийг дээшлүүлэх, тэднийг мэргэжлийн онол арга зүйн мэдээллээр хангах, иргэдийг албан ба албан бус арга замаар боловсрол эзэмшихэд нь туслан дэмжих үйл ажиллагаа эрхлэн явуулах чиг үүрэгтэй ажиллаж байна.

2015 онд Ерөнхий боловсролын сургуулиудад улсын төсвөөс нийт 3,553,440.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан боловч улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан 107,930.2 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Жилийн эцсийн байдлаар Ерөнхий боловсролын сургуулиуд нийт 257,470.6 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна. Өглөгийн 139,992.2 мянган төгрөгийг цалингийн, 117,478.4 мянган төгрөгийг түлш, халаалтын өглөг эзэлж байна.

Сургуулийн өмнөх боловсролд улсын төсвөөс нийт 1,656,705.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцсийн байдлаар 3,421.1 мянган төгрөгийн цалингийн өглөгтэй гарсан байна.

Соёлын салбарт нийт 854,099.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцсийн байдлаар 23,587.5 мянган төгрөгийн түлш, халаалтын өглөгтэй байна.

2015-2016 оны хичээлийн жилд бага боловсролд 59 бүлэг 1667 суралцагч, суурь боловсролд 32 бүлэг 836 суралцагч, бүрэн дунд боловсролд 30 бүлэг 798 суралцагч, Ерөнхий боловсролын нийт 5 сургуулийн 121 бүлэгт 3309 суралцагч суралцаж байна.

2015-2016 оны хичээлийн жилд улсын 5 цэцэрлэг, хувийн 4 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж байна. Яслийн 2 бүлэгт 25, 12 бага бүлэгт 416, дунд 7 бүлэгт 293, ахлах 8 бүлэгт 309, бэлтгэл 9 бүлэгт 325, холимог 4 бүлэгт 41 хүүхэд нийт сургуулийн өмнөх боловсролд 42 бүлэгт 1808 хүүхэд хамрагдаж байна. Үүнээс 40.2%-ийг шинээр элссэн хүүхэд эзэлж байна.

2015-2016 оны хичээлийн жилийн байдлаар бага суурь боловсролын хамран сургалт 100 хувь, цэцэрлэгийн хамран сургалт 83,5 хувь, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 93,9 хувьд хүрч өмнөх оны түвшингээс сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 1,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Ерөнхий боловсролын сургуульд 179 багш, СӨБ-д 43 багш ажиллаж байна. Үүнд: 2015-2016 оны хичээлийн жилд бага ангийн 59, дунд ангийн 77, ахлах ангийн 43, нийт үндсэн 179 багш ажиллаж байна. Нийт багш нарын 11.1% нь тэргүүлэх, 32.4% нь заах аргач зэрэгтэй байна.

2015-2016 оны хичээлийн жилд цэцэрлэгийн үндсэн багш 46, үүнээс бүлгийн 41, дуу хөгжмийн 5 багш ажиллаж байна. Мөн туслах багш 41, эрхлэгч 9, арга зүйч 1, нягтлан бодогч 5, нярав 5, эмч 2, тогооч 16, сантехникч 1, үйлчлэгч 9, манаач 16, бусад 8 ажилтан ажиллаж байна. Үндсэн багшийн 78.2% нь төрийн өмчит цэцэрлэгт байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд соёл, урлагийн 5 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Соёл, урлагийн салбарт нийт 84 ажилтан, албан хаагч, уран бүтээлчид ажиллаж байна. Боржигин чуулга 21,542 иргэдэд, Номын сан 14,660 иргэдэд, Музей 1,521 иргэдэд, Баянтал сумын соёлын төв 6,299 иргэдэд, Шивээговь сумын соёлын төв 4,906 иргэдэд тус тус соёл, урлагийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Орон нутгийн онцлог, нөөц боломжид суурилан Монгол Улсын Засгийн Газрын “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Говьсүмбэр аймгийн “Боловсролыг дэмжих” болон “Соёл, урлагийг хөгжүүлэх”, “Авьяас”, “Ном” дэд хөтөлбөрүүд болон “Чанарын шинэчлэл хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-аар батлуулан 2016 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Бүлэг 1.

Боловсрол, соёлын салбарын төсвийг үнэн, зөв төлөвлөж, батлуулдаггүй, төсвийн хуваарилалтад ил тод, тэгш хуваарилалтын зарчмыг баримтлаагүйгээс салбарын байгууллагуудын төсөвт жилд 7-8 удаа өөрчлөлт орсон боловч эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй байна,

1.1 Аймгийн Боловсролын салбарын батлагдсан төсөв 2014-2016 онуудад жил бүр 2.8-8.9 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль 5, төрийн өмчийн цэцэрлэг 5, хувийн хэвшлийн цэцэрлэг 4, нийт 14 байгууллага сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Боловсрол, соёлын салбарт 2014 онд 4,947,950.5 мянга, 2015 онд 5,086,981.1 мянга, 2016 онд 5,539,889.1 мянган төгрөгийн төсөв тус тус батлагдсан байна. Үүнээс: ЕБС-д 2014 онд нийт төсвийн 72.8 хувь буюу 3,604,078.2 мянга, 2015 онд 70.0 хувь буюу 3,555,440.1 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 68.2 хувь буюу 3,779,005.3 мянган төгрөг батлагдсан бол СӨББ-уудад 2014 онд нийт төсвийн 27.2 хувь буюу 1,343,872.3 мянга, 2015 онд 30.0 хувь буюу 1,531,541.0 мянга, 2016 онд 31.8 хувь буюу 1,760,883.8 мянган төгрөгийн төсөв тус тус батлагдсан байна.

Боловсролын салбарын 2014-2016 онуудад батлагдсан төсвийн судалгааг хүснэгтээр харуулбал:

		/мян.төг/				
№		2014 он	2015 он	2016 он	Зөрүү /2015/	Зөрүү /2016/
1	ЕБС	3,604,078.2	3,555,440.1	3,779,005.3	-48,638.1	223,565.2
2	СӨББ	1,343,872.3	1,531,541.0	1,760,883.8	187,668.7	229,342.8
дүн		4,947,950.5	5,086,981.1	5,539,889.1	139,030.6	452,908.0

Хүснэгтээс харахад: Боловсрол, соёлын салбарын батлагдсан төсөв 2015 онд өмнөх оныхоос 2.8 хувиар буюу 139,030.6 мянга, 2016 онд мөн үеийн батлагдсан төсвөөс 8.9 хувиар буюу 452,908.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

СӨББ-уудын батлагдсан төсөв 2014 онд нийт төсвийн 27.2 хувь, 2015 онд 30.0 хувь, 2016 онд 38.1 хувийг тус тус эзэлж байгаа ба жил бүр нийт төсөвт эзлэх хувь нь өссөн харагдаж байна.

СӨББ-уудын батлагдсан төсөв өссөн нь 1 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтанд орж, шинээр 4 бүлэг нэмж, 100 хүүхэд авсан, мөн өргөтгөлийн барилгын ашиглалтын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

1.1.1 Баянтал сумын 4 дүгээр сургуулиас бусад ЕБС-ууд стандартын дагуу ашиглавал зохих хүчин чадлаа дунджаар 144.2 хувь буюу 595 хүүхдээр хэтрүүлсэн байгаа нь тус аймагт шинээр 1 ЕБС-ийг барьж, байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн байрны хүчин чадлыг тооцохдоо тухайн хичээлийн жилийн суралцах суралцагчдын тоо мэдээ, хичээлийн байрны хүчин чадал, бүлгийн тоо, анги дүүргэлтийн норм, нормативыг үндэслэн тооцож байна. Аймгийн хэмжээнд ЕБС-уудад 2014 онд 3042 сурагч, 2015 онд 3298 сурагч, 2016 онд 3,356 сурагч тус тус хамрагдан суралцсан байна.

ЕБС-уудын хичээлийн байрны 2014-2016 оны хүчин чадал, ашиглалтын харьцуулалтыг хүснэгтээр харуулбал:

д/д	Огноо	Хичээлийн байрны хүчин чадал	Суралцагчдын тоо	Хүчин чадал ашиглалтын хувиар	Хүүхдийн тоо илүү/+/,-/-
1-р сургууль					
1	2014	640	941	147.0	301
	2015	640	1046	163.4	406
	2016	640	1047	163.6	407
2-р сургууль					
2	2014	320	645	201.6	325
	2015	320	629	196.6	309
	2016	320	629	196.6	309
3-р сургууль					
3	2014	320	535	167.2	215
	2015	320	595	185.9	275
	2016	320	627	195.9	307
4-р сургууль					
4	2014	320	110	34.4	-210
	2015	320	127	39.7	-193
	2016	320	139	43.4	-181
5-р сургууль					
5	2014	640	811	126.7	171
	2015	640	901	140.8	261
	2016	640	914	142.8	274
Нэгтгэл					
Он	2014	448	608	135.7	160
	2015	448	660	147.3	212
	2016	448	671	149.8	223
Дундаж дүн		448	646	144.2	595

Дээрх хүснэгтээс харахад: Баянтал сумын сургууль ашиглавал зохих хүчин чадлынхаа зөвхөн 34.4-43.4 хувийг ашиглаж, 181-210 хүүхэд дутуу элсүүлэн суралцуулсан бол бусад ЕБС-ууд хүчин чадлаа хэтрүүлэн ажилласан бөгөөд хүчин чадлын ашиглалт 2014 онд 135.7 хувь буюу 160, 2015 онд 147,3 хувь буюу 212, 2016 онд 149.8 хувь буюу 223, нийт 595 суралцагчийг илүү элсүүлэн суралцуулсан байна.

Энэ нь цаашид тус аймагт 640 хүүхдийн хүчин чадалтай 1 сургууль шинээр байгуулах шаардлага бий болж байгааг харуулж байна.

2014-2016 онуудад аймгийн ЕБС-ууд багш, ажиллагсдын батлагдсан орон тоог 9-10-аар хэтрүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 236 дугаар тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн багшийн хэрэгцээг тодорхойлж байна.

Аймгийн ЕБС-уудад БСШУС-ын баталсан норм, нормативын дагуу 2014 онд нийт 271 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 271, 2015 онд 269 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 279, 2016 онд 270 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 279 орон тоогоор ажиллаж, батлагдсан орон тооноос 9-10-аар хэтрүүлэн ажилласан байна.

2014-2016 оны хичээлийн жилүүдэд Ерөнхий боловсролын сургуулиудад ажиллавал зохих, батлагдсан орон тоо, ажиллаж буй багш, ажиллагсдын орон тооны судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	2014 оны хичээлийн жил			2015 оны хичээлийн жил			2016 оны хичээлийн жил		
		Ажиллавал зохих	Батлагдсан орон тоо	Ажилласан орон тоо	Ажиллавал зохих	Батлагдсан орон тоо	Ажилласан орон тоо	Ажиллавал зохих	Батлагдсан орон тоо	Ажилласан орон тоо
1	1-р сургууль	71	71	71	73	71	74	74	71	74
2	2-р сургууль	64	56	56	68	55	57	67	56	57
3	3-р сургууль	58	53	53	60	53	53	62	52	52
4	4-р сургууль	25	24	24	25	25	26	26	25	26
5	5-р сургууль	72	67	67	72	66	69	74	66	70
ЕБС-ийн нийт дүн		290	271	271	298	269	279	303	270	279

Дээрх хүснэгтээс харахад: ЕБС-ууд БСШУЯ-ны баталсан норм, норматив, өөрсдийн хэрэгцээ шаардлагад үндэслэн тооцоолсон орон тооноос 2014 онд 19, 2015 онд 29, 2016 онд 33-аар тус тус дутуу батлан ирүүлсэн байна.

Тухайлбал: 2014-2016 онд:

- Сүмбэр сумын 1 дүгээр сургууль цөм хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотой сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 3 багшийн орон тоо зайлшгүй шаардлагатай байсан боловч батлагдаагүй,
- Сүмбэр сумын 2 дугаар сургууль 8-13,
- Шивээговь сумын 3 дугаар сургууль 5-10,
- Баянтал сумын 4 дүгээр сургууль 1,
- Сүмбэр сумын 5 дугаар сургууль 5-8 орон тоогоор тус тус батлагдаж ирээгүй байна.

1.1.2 2014-2016 оны хичээлийн жилүүдэд СӨББ-уудад хамрагдах хүүхдийн тоог 250 хүүхдээр илүү тооцож, төсвөө батлуулсан байна.

СӨБ-ын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, ном, гарын авлага болон хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн тоглоомоор хангах зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэсний дагуу СӨББ-уудад хамрагдах хүүхдийн тоог зөвхөн статистик мэдээнд тусгагдсан хүүхдийн тоогоор тооцож, төсвийг нь батлуулсан байна.

2014-2016 оны хичээлийн жилүүдэд СӨББ-уудад хамрагдаж буй хүүхдийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Утга	2014-2015 оны хичээлийн жил			2015 -2016 оны хичээлийн жил /			2014-2015 оны хичээлийн жилийн харьцуулалт /
	Статистик мэдээгээрх хүүхдийн тоо	Өдрийн анги	Хувилбарт сургалт	Бодит хүүхдийн тоо	Өдрийн анги	Хувилбарт сургалт	Зөрүү /+илүү, -дутуу/
СӨБ	1516	1262	254	1266	1168	98	-250

Хүснэгтээс харахад: СӨБ-ын байгууллагуудын хүүхдийн тоог 16.4 хувиар буюу 250 хүүхдээр илүү төлөвлөж батлуулсан байна. Тухайлбал: Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл, Канад цэцэрлэгийн барилгуудыг ашиглалтанд орно гэж тооцон тус бүр 100, 100, нийт 200, хувийн хэвшлийн Ануухай цэцэрлэгийн хүүхдийн тоог 50 хүүхдээр тус тус нэмэгдүүлэн тооцсон байна.

Аймгийн СӨББ-уудад БСШУС-ын баталсан норм, нормативын дагуу 2014 онд нийт 114 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 104, 2015 онд 123 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 119, 2016 онд 127 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 119 орон тоогоор тус тус ажиллаж, батлагдсан орон тооноос 4-10-аар дутуу ажилласан байна.

Энэ нь жил бүр Канад цэцэрлэгийг ажиллаж байгаагаар тооцож, орон тоо, төсвийг нь батлуулан авсан боловч уг цэцэрлэг ашиглалтад орж ажиллаагүй учраас дутуу орон тоогоор ажилласан харагдаж байна.

2014-2016 оны хичээлийн жилд СӨББ-уудын төлөвлөсөн, батлагдсан, ажилласан орон тооны судалгааг хүснэгтээр харуулбал:

Д/д	Цэцэрлэгийн нэр	2014 он			2015 он			2016 он		
		Төлөвлөсөн орон тоо	Батлагдсан орон тоо	Ажилласан	Төлөвлөсөн орон тоо	Батлагдсан орон тоо	Ажилласан	Төлөвлөсөн орон тоо	Батлагдсан орон тоо	Ажилласан
1	1-р цэцэрлэг	20	20	20	34	31	31	34	31	31
2	2-р цэцэрлэг	27	23	22	23	23	22	25	23	22
3	3-р цэцэрлэг	36	32	32	32	30	30	34	30	30
4	4-р цэцэрлэг	14	10	10	11	10	12	11	10	12
5	5-р цэцэрлэг	21	20	20	20	20	24	24	24	24
6	Канад цэцэрлэг	9	9	-	9	9	-	9	9	-
СӨБ цэцэрлэгийн нийт дүн		127	114	104	129	123	119	137	127	119

Хүснэгтээс харахад: СӨББ-уудын орон тоог БСШУЯ-ны баталсан норм, норматив, байгууллагын хэрэгцээ шаардлагад үндэслэн тооцоолсон орон тооноос 2014 онд 13, 2015 онд 6, 2016 онд 10-аар тус тус дутуу батлан ирүүлсэн байна. Тухайлбал: 2014-2016 онуудад:

- Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг 3
- Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэг 2-4
- Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг 2-4
- Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг 1-4
- Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 1 орон тоо тус тус батлагдаж ирээгүй байна.

1.2. ЕБС, СӨББ-уудын 2014-2016 оны зарим хувьсах зардлын батлагдсан төсөв сургалтын болон үйл ажиллагааны стандарт шаардлага хангах хэмжээнд батлагдаагүй байна.

Аймгийн ЕБС, СӨББ-уудын хувьсах зардлыг БСШУС болон Сангийн сайдын хамтарсан 2007 оны 306/237 дугаар тушаалаар баталсан итгэлцүүрийг үндэслэн ЕБС-ийн 1 сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тогтоосон байна.


Мөн Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т “Сургуулийн өмнөх болон бага дунд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг сурагцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасан байна.

Гэтэл Засгийн газар 2012 оноос хойш ЕБС, СӨББ-уудын хувьсах зардлын нормативыг шинэчлэн тогтоогоогүйгээс аймгийн ЕБС, СӨББ-уудын төсвийн төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж, батлуулсан байна. Энэ нь боловсролын байгууллагуудын сургалтын болон үйл ажиллагааны стандарт, хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

1.2.1 2014-2016 онуудад ЕБС-уудад суралцагчийн тоо жил бүр өссөн боловч хувьсах зардлын төсөв буурч батлагдсан байна.

2014-2015 оны хичээлийн жилд 3,042 хүүхэд байсан бол 2015-2016 оны хичээлийн жилд өмнөх оноос 3,298 хүүхэдтэй болж 256-аар, 2016-2017 оны хичээлийн жилд 3,356 хүүхэдтэй болж 58-аар тус тус нэмэгдсэн боловч хувьсах зардал жилээс жилд буурсан байна. Тухайлбал: 2014 онд хувьсах зардлын төсөв 54,778.2 мянга, 2015 онд 39,960.2 мянга, 2016 онд 29,972.2 мянган төгрөгөөр буюу 2015 онд өмнөх оныхоос 27.0 хувиар, 2016 онд өмнөх оныхоос 25.0 хувиар тус тус буурч батлагдсан байна.

ЕБС-уудын 2014-2016 оны суралцагчдын тоо, хувьсах зардлын батлагдсан төсвийн судалгааг графикаар харуулбал:



Графикаас харахад: 2014-2016 онд зарим сургуулийн суралцагчийн тоо нэмэгдсэн, зарим нь буурч, зарим нь өөрчлөгдөөгүй боловч ихэнх сургуулийн хувьсах зардлын төсөв буурч батлагдсан байна. Тухайлбал:

- 1-р сургуулийн хүүхдийн тоо 2015 онд өмнөх оныхоос 105-аар нэмэгдсэн боловч хувьсах зардлын төсөв 5,806.7 мянган төгрөгөөр буурсан бол 2016 онд хүүхдийн тоо өмнөх оныхоос 1-ээр, хувьсах зардлын төсөв 3,142.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн,

- 2-р сургуулийн хүүхдийн тоо 2015 онд 16-аар, хувьсах зардлын төсөв 5,854.1 мянган төгрөгөөр тус тус буурсан, гэтэл 2016 онд хүүхдийн тоо өмнөх оноос өөрчлөгдөөгүй боловч хувьсах зардлын төсөв 2,155.9 мянган төгрөгөөр буурсан,
- 3-р сургуулийн хүүхдийн тоо 2015 онд өмнөх оныхоос 60-аар, хувьсах зардлын төсөв 465.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол 2016 онд хүүхдийн тоо 32-оор нэмэгдсэн боловч 6,020.0 мянган төгрөгөөр буурсан,
- 4-р сургуулийн хүүхдийн тоо 2015 онд 17-оор нэмэгдсэн боловч хувьсах зардлын төсөв 1,700.9 мянга, 2016 онд хүүхдийн тоо 12-оор нэмэгдсэн боловч 434.0 мянган төгрөгөөр тус тус буурсан,
- 5-р сургуулийн хүүхдийн тоо 2015 онд өмнөх оныхоос 90-ээр, хувьсах зардлын төсөв 1,907.6 мянга, 2016 онд хүүхдийн тоо 13-аар нэмэгдсэн боловч хувьсах зардлын төсөв 4,515.2 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Боловсрол, соёлын салбарын төсвийн төлөвлөлтийг хүүхдийн тоонд үндэслэн хувьсах зардлаар тооцож байгаа нь суралцагч олонтой сургууль, цэцэрлэгүүдэд ашигтай боловч, цөөхөн суралцагчтай Баянтал сумын 4-р сургуульд хүүхдийн тоонд үндэслэн хувьсах зардлын нормативаар төсвийг төлөвлөхөд үйл ажиллагаагаа хэвийн явуулах хэмжээний төсөв батлагдахгүй байна.

1.2.2 2014-2016 онуудад шинээр барьж буй Канад цэцэрлэг, 1 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтад ороогүй байхад үйл ажиллагааны төсвийг нь батлуулсан байна.

2015 онд 1 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтад ороогүй боловч бүлгийн тоог 4, хүүхдийн тоог 100-аар, Канад цэцэрлэгт 4 бүлэгт 100 хүүхэд хамрагдахаар, мөн хувийн хэвшлийн Ануухай цэцэрлэгт хүүхдийн тоог үндэслэн хувьсах зардлаар санхүүжилт олгож байгаагаас шалтгаалан бүлгийн тоо болон хүүхдийн тоогоо тус тус өсгөн төлөвлөж, батлуулсан байна. Тухайлбал: 1-р цэцэрлэг шинэ байр ашиглалтад ороогүй байхад бүлгийн тоог 4, хүүхдийн тоог 100-аар нэмэгдүүлэн төлөвлөж, санхүүжилтийг батлуулсан байна.

СӨББ-ууд 2014 онд хүүхдийн тоо 1023-аар батлагдсан бол 2015 онд 1147 болж өмнөх оноос 124-өөр нэмэгдсэн, 2016 онд 1208 болж өмнөх оноос 61-ээр тус тус нэмэгдсэн байна. Харин хувьсах зардлын төсөв 2014-2015 онд жилээс жилд нэмэгдсэн бол, 2016 онд өмнөх оноос буурч батлагдсан байна. Тухайлбал: 2014 онд хувьсах зардлын төсөв 295,982.0 мянга, 2015 онд 330,415.6 мянга, 2016 онд 319,695.0 мянган төгрөгөөр буюу 2016 онд өмнөх оныхоос 3.2 хувиар буурч батлагдсан байна.

2014-2016 оны СӨББ-уудад төлөвлөсөн болон батлагдсан хүүхдийн тоо, хувьсах зардлын батлагдсан төсвийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Байгууллагын нэр	2014 он			2015 он			2016 он		
		Төлөвлөсөн хүүхдийн тоо	Батлагдсан хүүхдийн тоо	Батлагдсан төсөв	Төлөвлөсөн хүүхдийн тоо	Батлагдсан хүүхдийн тоо	Батлагдсан төсөв	Төлөвлөсөн хүүхдийн тоо	Батлагдсан хүүхдийн тоо	Батлагдсан төсөв
1	1-р цэцэрлэг	143	141	42,546.8	250	190	66,306.1	280	280	71,670.0
2	2-р цэцэрлэг	215	226	68,567.3	200	226	70,304.4	215	215	73,236.2

3	3-р цэцэрлэг	292	295	82,422.2	300	295	87,340.1	292	292	72,065.5
4	4-р цэцэрлэг	75	76	27,768.7	75	76	33,452.7	75	106	26,719.8
5	5-р цэцэрлэг	215	210	74,677.0	210	210	63,160.4	215	215	63,444.5
6	Канад цэцэрлэг	125	75		100	100	9,851.9	125	100	12,559.0
7	Ануухай				50	50	-	-		
	Дүн	1065	1023	295,982.0	1185	1147	330,415.6	1202	1208	319,695.0

Хүснэгтээс харахад: 2014-2016 онд СӨББ-уудын хүүхдийн тоо жил бүр нэмэгдсэн байна. Харин хувьсах зардлын батлагдсан төсөв 2014-2015 онд нэмэгдэж, 2016 онд өмнөх оноос 10,720.6 мянган төгрөгөөр буурч батлагдсан байна. Тухайлбал:

- 1-р цэцэрлэгийн хүүхдийн тоо өмнөх оныхоос 2015 онд 49-өөр, 2016 онд 90-ээр нэмэгдсэн бол хувьсах зардлын батлагдсан төсөв 2015 онд өмнөх оныхоос 23,759.3 мянга, 2016 онд 5,363.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн,
- 2-р цэцэрлэгийн хүүхдийн тоо 2015 онд өмнөх оноос өөрчлөгдөөгүй боловч хувьсах зардлын төсөв 1,737.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн, 2016 онд хүүхдийн тоо өмнөх оноос 11-ээр буурсан байтал хувьсах зардлын төсөв 2,931.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн,
- 3-р цэцэрлэгийн хүүхдийн тоо 2015 онд өмнөх оноос өөрчлөгдөөгүй боловч хувьсах зардлын төсөв 4,917.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол 2016 онд хүүхдийн тоо 3-аар, хувьсах зардлын төсөв 15,274.6 мянган төгрөгөөр буурсан,
- 4-р цэцэрлэгийн хүүхдийн тоо 2015 онд өмнөх оноос өөрчлөгдөөгүй боловч хувьсах зардлын төсөв 5,684.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, 2016 онд хүүхдийн тоо 30-аар нэмэгдсэн боловч 6,732.9 мянган төгрөгөөр буурсан,
- 5-р цэцэрлэгийн хүүхдийн тоо 2015 онд өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй боловч хувьсах зардлын төсөв 11,516.6 мянган төгрөгөөр буурсан, 2016 онд хүүхдийн тоо 5-аар хувьсах зардлын төсөв 284.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

1.3 Бараа үйлчилгээний бусад зардлын батлагдсан төсөв ЕБС болон СӨББ-уудын хэвийн үйл ажиллагааг хангахад хүрэлцэхгүй байна.

ЕБС болон СӨББ-уудад бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг хувьсах зардлаар тооцож баталсан байна. Гэтэл уг батлагдсан төсөв нь сургууль, цэцэрлэгийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад хүрэлцэхгүй байна. Тухайлбал: 2015 онд хүүхдийн 5 цэцэрлэгт нийт 15,884.5 мянган төгрөгийн хичээл практикийн зардлын төсөв батлагдсан бөгөөд үүнийг дээрх 5 цэцэрлэгт хуваахад нэг цэцэрлэгийн нэг сарын хичээл практикийн зардалд дунджаар 264.7 мянган төгрөг ногдож байна. Энэ нь цэцэрлэгүүдийн сургалтын стандартын шаардлага хангахгүй байгаагаас багш нар өөрсдийн хувийн зардлаараа сургалтын материал бэлтгэх, эцэг эхчүүдээс мөнгө гаргах, танил талаа гуйх зэрэг сөрөг үр дагаварыг бий болгож байна.

Мөн ЕБС, СӨББ-уудад 2014-2016 онуудад цэвэрлэгээний материалын төсөв батлагдаагүйгээс уг зардлыг нормын хувцас, зөөлөн эдлэлийн батлагдсан төсвөөс шилжүүлэн зарцуулж байна. Энэ нь сургууль, цэцэрлэгт хамрагдан суралцаж буй хүүхдийг эрүүл, аюулгүй, цэвэр орчинд сургах стандарт шаардлагыг хангахгүй байгаа, мөн мэргэжлийн хяналтын байгууллагаас стандартын шаардлага хангаж ажиллаагүй гэж торгох, албан шаардлага өгөх зэргээр олон эрсдэлийг бий болгож байна. Тухайлбал: 5 сургуульд 2014 онд 1,079.6 мянга, 2015 онд 384.5 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 579.5 мянган төгрөгийн нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлын төсөв тус тус батлагдсан байна. Уг төсвийг сараар тооцвол нэг сард дунджаар

48.3 мянган төгрөг ногдож байгаа ба энэ нь тухайн сарын цэвэрлэгээний материал авахад хүрэлцэхгүй байна.

Иймд Боловсролын салбарын төсвийн төлөвлөлтийг хийхдээ зөвхөн цалин, НДШ-ийг хувьсах зардлаар тооцож, бусад зардлыг газар, нутгийн байршил, онцлог нөхцлийг харгалзан төлөвлөн, батлуулж, хуваарилдаг байх тухай хүсэлтийг дээд шатны буюу Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд хүргүүлж, шийдвэрлүүлэх тухай зөвлөмжийг аймгийн БСГ-т өгөхөөр шийдвэрлэв.

1.4. 2014-2016 онуудад аймгийн Боловсрол, соёлын салбарын хэмжээнд тогтмол зардлыг илүү, дутуу төлөвлөж, батлуулсан байна.

Аймгийн боловсролын байгууллагуудын хэмжээнд 2014 онд 627,390.8 мянга, 2015 онд 721,315.3 мянга, 2016 онд 945,561.5 мянган төгрөгийн тогтмол зардал тус тус батлагдсан байна. Тухайлбал: ЕБС-уудад 2014 онд 494,459.8 мянга, 2015 онд 517,854.1 мянга, 2016 онд 736,855.1 мянга, СӨБ-ын байгууллагуудад 2014 онд 132,931.0 мянга, 2015 онд 203,461.2 мянга, 2016 онд 208,706.4 мянган төгрөгийн тогтмол зардал тус тус батлагдсан байна.

2014-2016 онд зарим ЕБС-ууд тогтмол зардлын төсвийн санал боловсруулахдаа өмнөх оны гүйцэтгэл, тухайн тайлант онд мөрдөгдөж буй тогтмол зардлын үнэ тариф, мөн халаалтын талбайн хэмжээ зэргийг өсгөн төлөвлөсөн байна. Тухайлбал: 2015 онд өмнөх оныхоос ЕБ-ын 2 дугаар сургууль 11,906.8 мянга, 4 дүгээр сургууль 3,695.6 мянга, 5 дугаар сургууль 41,762.5 мянга, 2016 онд өмнөх оныхоос 1-р сургууль 31,220.1 мянга, 2-р сургууль 13,916.8 мянга, 3-р сургууль 46,173.3 мянга, 4-р сургууль 41,067.4 мянга, 5-р сургууль 56,588.0 мянган төгрөгөөр өсгөн төлөвлөсөн байна.

1.4.1 2014-2016 онд ЕБС-уудын тогтмол зардлын төсөв зарим сургуульд илүү, зарим сургуульд дутуу батлагдаж ирсэн байна.

ЕБС-уудын тогтмол зардлын төсөв байгууллагын төсвийн төслийн саналаас 2014 онд 21,605.6 мянган төгрөгөөр илүү, 2015 онд 7,208.6 мянган төгрөгөөр дутуу, 2016 онд 22,826.8 мянган төгрөгөөр илүү батлагдаж ирсэн байна.

Аймгийн ЕБС-уудын 2014-2016 онуудын тогтмол зардлын боловсруулсан төсвийн төслийн саналыг батлагдсан төсөвтэй харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Байгууллагын нэр	2014 он			2015 он			2016 он		
		БСГ-ын төсвийн төсөв	Батлагдсан төсөв	Зөрүү	БСГ-ын төсвийн төсөв	Батлагдсан төсөв	Зөрүү	БСГ-ын төсвийн төсөв	Батлагдсан төсөв	Зөрүү
1	1-р сургууль	86,752.7	78,361.8	8,390.9	85,232.8	101,024.7	-15,791.9	116,452.9	126,802.3	-10,349.4
2	2-р сургууль	122,000.0	117,968.1	4,031.9	133,906.8	110,387.2	23,519.6	147,823.6	118,856.7	28,966.9
3	3-р сургууль	79,800.0	79,793.3	6.7	76,163.4	81,140.5	-4,977.1	122,336.7	161,959.4	-39,622.7
4	4-р сургууль	83,000.0	82,819.6	180.4	86,695.6	85,497.6	-1,198.0	127,763.0	167,124.4	-39,361.4

5	5-р сургууль	101,301.6	135,517.0	-34,215.4	143,064.1	139,804.1	3,260.0	199,652.1	162,112.3	37,539.8
	ЕБС-ийн нийт дүн	472,854.3	494,459.8	21,605.5	525,062.7	517,854.1	7,208.6	714,028.3	736,855.1	-22,826.8

Хүснэгтээс харахад: 2014-2016 онд зарим сургууль халаалтын зардлын төсвийн төслийн боловсруулахдаа хичээлийн байрны талбайн хэмжээ болон халаалтын үнийг харилцагч байгууллагатай хийсэн гэрээний дүнгээс өндрөөр тооцож төлөвлөсөн байна. Тухайлбал:

- 2014 онд Сүмбэр сумын 5 дугаар сургууль халаалтын талбайг нэмж төлөвлөснөөр 34,215.4 мянган төгрөгөөр илүү,
- 2015 онд 1 дүгээр сургууль 15,791.9 мянга, 3 дугаар сургууль 4,977.1 мянга, 4 дүгээр сургууль 1,198.0 мянган төгрөгөөр тус тус илүү,
- 2016 онд 1 дүгээр сургууль 10,349.4 мянга, 3 дугаар сургууль 39,622.7 мянга, 4 дүгээр сургууль 39,361.4 мянган төгрөгөөр тус тус илүү тооцож батлуулсан байна.

1.4.2. 2015 онд СӨББ-уудын төсвийг 6,593.3-34,338.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

2014-2016 онд зарим СӨББ-уудын тогтмол зардлын төсвийн саналыг өмнөх оны гүйцэтгэл, тухайн тайлант онд мөрдөгдөж буй тогтмол зардлын үнэ тариф, мөн халаалтын талбайн хэмжээ зэргийг өсгөн төлөвлөсөн байна. Тухайлбал: 2016 онд өмнөх оныхоос 1 дүгээр цэцэрлэг 37,380.4 мянга, 2 дугаар цэцэрлэг 22,766.1 мянга, 3 дугаар цэцэрлэг 33,322.1 мянга, 4 дүгээр цэцэрлэг 16,559.0 мянга, 5 дугаар цэцэрлэг 69,738.0 мянган төгрөгөөр тус тус өсгөн төлөвлөсөн байна.

Мөн цэцэрлэгүүдийн тогтмол зардлын төсвийн төслийн саналаас 2014 онд 18,874.5 мянган төгрөгөөр дутуу, 2015 онд 102,960.5 мянган төгрөгөөр илүү, 2016 онд 71,559.9 мянган төгрөгөөр дутуу батлагдаж ирсэн байна.

Аймгийн СӨББ-уудын 2014-2016 онуудын тогтмол зардлын боловсруулсан төсвийн төслийн саналыг батлагдсан төсөвтэй харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

		2014 он			2015 он			2016 он		
№	Байгууллагын нэр	БСГ-ын төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү	БСГ-ын төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү	БСГ-ын төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
1	1-р цэцэрлэг	50,580.3	53,869.9	-3,289.6	34,206.9	68,545.8	-34,338.9	71,587.3	67,337.8	4,249.5
2	2-р цэцэрлэг	28,106.6	24,586.0	3,520.6	18,315.3	38,247.8	-19,932.5	41,081.4	35,647.8	5,433.6
3	3-р цэцэрлэг	28,832.7	16,471.1	12,361.6	11,811.6	30,289.6	-18,478.0	45,133.7	29,389.7	15,744.0
4	4-р цэцэрлэг	15,451.6	13,155.4	2,296.2	9,216.9	15,810.2	-6,593.3	25,775.9	29,863.3	-4,087.4
5	5-р цэцэрлэг	28,834.3	24,848.6	3,985.7	26,950.0	50,567.8	-23,617.8	96,688.0	46,467.8	50,220.2
	СӨББ-ын нийт дүн	151,805.5	132,931.0	18,874.5	100,500.7	203,461.2	-102,960.5	280,266.3	208,706.4	71,559.9

Дээрх хүснэгтээс харахад: 2014 онд 1 дүгээр цэцэрлэгийн төсвийн төслийг 3,289.5 мянга, 2015 онд бүх цэцэрлэгүүдийн төсвийн төслийг 6,593.3-34,338.9 мянга,

2016 онд 4 дүгээр цэцэрлэгийн төсвийн төслийг 4,087.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

1.5. БСУШЯ-ны Төсвийн ерөнхийлөн захирагчийн хасаж тодотгосон төсвийг аймгийн ИТХ-ын төсвийн тодотголоор нэмэгдүүлэн баталж, хуваарилсан байна.

ЕБС, СӨББ-уудын төсвийг өмнөх оны гүйцэтгэл, үйлчлүүлэгч байгууллагатай хийсэн гэрээ, бодит тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж батлуулаагүй, батлагдсан төсийг ононвчтой хуваарилаагүйгээс шалтгаалан Боловсролын байгууллагуудын төсвийн хуваарьт жилд 7-8 удаа өөрчлөлт оруулсан боловч тухай бүр ТЕЗ-ийн шийдвэр гараагүй байна.

2015 онд ЕБС-уудын батлагдсан төсвөөс ТЕЗ төсвийн тодотголоор 73,995.0 мянган төгрөгийг хасаж тодотгосон байна.

Гэтэл ЕБС-уудад 2015 оны 12 дугаар сарын тодотголоор 70,066.0 мянган төгрөгөөр санхүүжилтийг нэмэгдүүлэн баталж хуваарилсан байна.

Аймгийн ЕБС, СӨББ-уудын 2014-2016 онуудын тогтмол зардлын батлагдсан төсөв, олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

		Тогтмол зардал 2014			Тогтмол зардал 2015		
№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Хувь	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Хувь
1	1 дүгээр сургууль	78,361.8	78,361.6	100	101,024.7	101,024.7	100
2	2 дугаар сургууль	117,968.1	117,968.1	100	110,387.2	110,387.2	100
3	3 дугаар сургууль	79,793.3	79,793.3	100	81,140.5	81,140.5	100
4	4 дүгээр сургууль	82,819.6	82,819.6	100	85,497.6	82,079.0	96
5	5 дугаар сургууль	135,517.0	111,028.9	81.9	139,804.1	139,804.1	100
Дүн		494,459.8	469,971.5	95.0	517,854.1	514,435.5	99.3


		Тогтмол зардал 2014			Тогтмол зардал 2015		
№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Хувь	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Хувь
1	1 дүгээр цэцэрлэг	53,869.9	18,504.8	0,34	68,545.8	67,134.0	0,98
2	2 дугаар цэцэрлэг	24,586.0	21,656.0	0,88	38,247.8	30,517.3	0,79
3	3 дугаар цэцэрлэг	16,471.1	16,955.1	1,03	30,289.6	25,558.6	0,84
4	4 дүгээр цэцэрлэг	13,155.4	11,448.5	0,87	15,810.2	27,107.1	1,71
5	5 дугаар цэцэрлэг	24,848.6	24,868.6	1,00	50,567.8	41,511.5	0,82
Дүн		132,931.0	93,433.0	0,70	203,461.2	191,828.5	0,94

Дээрх хүснэгтүүдээс харахад: ЕБС-уудын тогтмол зардлын батлагдсан төсвийг 2014 онд 24,488.3 мянга, 2015 онд 3,418.6 мянга, СӨББ-уудын тогтмол зардлын батлагдсан төсвийг 2014 онд 39,498.0 мянга, 2015 онд 11,632.7 мянган төгрөгөөр тус тус дутуу олгосон байна.

Батлагдсан төсвийг дутуу олгосон гол шалтгаан нь өмнөх оны төсвийг үндэслэлгүйгээр жил бүр өсгөн төлөвлөж, батлуулсан, мөн аймгийн БСГ-аас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, тогтмол зардлын төсвөөс бусад зардлуудад хуваарилж батлуулсантай тус тус холбоотой байна.

Аймгийн ЕБС-уудын 2015 оны тогтмол зардлын төсвийг өмнөх оны батлагдсан төсвөөс нийт дүнгээрээ 4.7 хувь буюу 23,394.3 мянга, СӨББ-уудын төсвийг өмнөх оноос 53.1 хувь буюу 70,530.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Аймгийн ЕБС, СӨББ-уудын 2014-2015 оны тогтмол зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг графикаар харуулбал:



БСШУЯ төсвийн тодотголоор аймгийн ЕБС-уудын батлагдсан төсвөөс нийт 73,995.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хасаж тодотгосон боловч аймгийн ИТХ-ын төсвийн тодотголоор Канад цэцэрлэгийн хэмнэгдсэн санхүүжилтээс ЕБС-уудад нийт 70,066.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмж хуваарилсан байна.

Мөн БСШЯ нь СӨББ-уудын 2015 оны батлагдсан төсвөөс 7 дугаар сард 36,406.7 мянган төгрөгийг хасаж, тодотгосон байна. Үүнд: Канад цэцэрлэгийн батлагдсан төсвөөс 25,588.4 мянга, хувийн цэцэрлэгүүдийн хичээл практикийн зардлаас 2,810.9 мянга, улсын цэцэрлэгүүдийн хичээл практик, хоолны зардлаас 8,007.5 мянган төгрөгийг тус тус хасаж тодотгосон байна.

Гэтэл 2015 оны 12 сард хийсэн аймгийн ИТХ-ын төсвийн тодотголоор Канад цэцэрлэгийн төсвөөс 38,728.4 мянган төгрөг, хувийн хэвшлийн Ануухай цэцэрлэгийн

төсвөөс 6,000.0 мянган төгрөг, нийт 44,728.4 мянган төгрөгийн санхүүжилтийг СӨББ-уудын батлагдсан төсөв дээр нэмэгдүүлэн баталж, хуваарилсан байна.

Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг, Канад болон хувийн хэвшлийн Ануухай цэцэрлэгүүдийн 2014-2015 онуудад батлагдсан төсвийн санхүүжилтийн хэмнэлтийг дахин хуваарилсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Байгууллагын нэр	Үндсэн цалин	НДШ	Нэг удаагийн буцалтгүй тусламж	Үдийн цай	Түлш халаалт
1	1-р сургууль	8,823.7	970.6	4,380.0	2,009.7	8,500.0
2	2-р сургууль	6,493.6	715.0			
3	3-р сургууль	8,000.0	880.0	2,500.0	1,515.6	
4	5-р сургууль	14,000.0	1,540.0		3,500.0	6,237.8
	Нийт дүн	37,317.3	4,105.6	6,880.0	7,025.3	14,737.8
1	2-р цэцэрлэг	15,000.0	4,364.2			
2	5-р цэцэрлэг	14,410.0	3,204.2	350.0		1,400.0
3	Буян цэцэрлэг			3,000.0		
4	Хонгорхон цэцэрлэг			3,000.0		
	Нийт дүн	29,410.0	7,568.4	6,350.0		1,400.0
	Бүгд	66,727.3	11,674.0	13,230.0	7,025.3	16,137.8

Дээрх хүснэгтээс харахад: Сүмбэр сумын 1-р цэцэрлэг болон Канад, хувийн хэвшлийн Ануухай цэцэрлэгийн хэмнэгдсэн төсвөөс Баянтал сумын 4 дүгээр сургууль, 4-р цэцэрлэг болон Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгүүдээс бусад сургууль цэцэрлэгт батлагдсан төсөв дээр нь нэмж нийт 70,066.0 мянган төгрөгийг ЕБС-иудад, нийт 44,728.4 мянган төгрөгийг цэцэрлэгүүдэд тус тус хуваарилсан байна.

Тухайлбал: 1 дүгээр сургуулийн цалин, НДШ, нэг удаагийн буцалтгүй тусламж, үдийн цай, түлш халаалтын зардалд нийт 24,683.3 мянга, 2 дугаар сургуулийн цалин, НДШ-н зардалд нийт 7,208.0 мянга, 3 дугаар сургуулийн цалин, НДШ, нэг удаагийн буцалтгүй тусламж, үдийн цай хөтөлбөрийн зардалд нийт 12,895.6 мянга, 5 дугаар сургуулийн сургуулийн цалин, НДШ, үдийн цай, түлш халаалтын зардалд нийт 25,277.8 мянга, мөн хувийн хэвшлийн Хонгорхон, Буян цэцэрлэгүүдийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмжид тус бүр 3,000.0 мянган төгрөгийг тус тус нэмж хуваарилсан байна.

1.6. Ашиглалтанд ороогүй Канад цэцэрлэгт жил бүр төсөв батлуулан авч, ЕБС болон СӨББ-уудын батлагдсан төсөв дээр нэмж хуваарилаж байгаа нь батлагдсан төсвийг хэтрүүлэх, зориулалт бусаар зарцуулах, төсвийн үр өгөөжийг бууруулах зэрэг сөрөг үр дагаварыг бий болгож байна.

Тус аймагт шинээр баригдаж буй 100 хүүхдийн Канад цэцэрлэгийн барилгын ажлын сонгон шалгаруулалт 2012 онд БСШУЯ-нд зохион байгуулагдаж, захиалагчаар нь БСШУЯ ажиллаж, УБ хотын “Хялганат нуга” ХХК-тай гэрээ байгуулан 2013 оны 05 дугаар сараас барилгын ажил эхлүүлсэн боловч одоог хүртэл ашиглалтад ороогүй байна.

Уг цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалтын ажлын сонгон шалгаруулалт БСШУЯ дээр зохион байгуулагдсан хэдий ч барилгын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудал бүрэн шийдэгдээгүй гэх шалтгаанаар барилгын ажил удааширч ашиглалтад оролгүй 3 жил болж байна. Орон нутгийн хувьд ямарч шийдвэр гаргах боломжгүй, зөвхөн БСШУЯ-нд уламжлах төдий байна.

Гэтэл тус цэцэрлэгийг ашиглалтад орсон гэж 2015-2016 онуудын үйл ажиллагааны төсвийг батлуулан 2 жилд нийт 180,370.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч бусад сургууль, төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүдэд батлагдсан төсөв дээр нь нэмж, дээд шатны байгууллагын төсвийн тодотголоор танагдаж, хасагдсан төсвийг нөхөж хуваарилан санхүүжүүлж ирсэн байна. Тухайлбал: Аудитын явцад БСГ-ын 2014 оны төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлангийн баримт олдоогүй учраас Канад цэцэрлэгт хэдэн төгрөг ирж, олгосон нь мэдэх боломжгүй байна. Харин тус цэцэрлэгт 2015 онд 61,518.4 мянган төгрөг батлуулж, 2 дугаар цэцэрлэгт цалин, НДШ-ийн зардалд 19,354.2 мянга, 5 дугаар цэцэрлэгт цалин, НДШ-д 17,614.2 мянга, нэг удаагийн буцалтгүй тусламжид 350.0 мянга, түлш халаалтын зардалд 1400.0 мянга нийт 19,364.2 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Санхүүжилтийн зөрүү 22,800.0 мянган төгрөгийн зарцуулалтын эрх нээгдээгүйгээс зарцуулагдаагүй буцаж, татагдсан байна. 2016 оны эхний хагас жилд 118,852.4 мянган төгрөг батлуулж, 2016 оны эхний хагас жилийн байдлаар төсвийн хуваарьт өөрчлөлт ороогүй тул Канад цэцэрлэгийн санхүүжилтийг зарцуулаагүй байна.

2014-2015 он, 2016 оны эхний хагас жилд Канад цэцэрлэгт батлагдсан төсөв, түүний зарцуулалтын судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

Д/д	Огноо	Батлагдсан төсөв	Зарцуулалт		
			Хуваарилсан байгууллага	Зориулалт	Дүн
1	2014		2014 оны төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан олдоогүй тул хэдэн төгрөгийн санхүүжилт ирж, яаж хуваарилсныг тодруулах боломжгүй байна.		
2	2015	61,518.4	1. 2-р цэцэрлэгт	-Цалин -15,000.0 -НДШ-д -4,354.2	19,354.2
			2. 5-р цэцэрлэг	-Цалин, НДШ-д -17,614.2 -Нэг удаагийн буцалтгүй тусламжид-350.0 - түлш халаалт-1,400.0	19,364.2
			Санхүүжилтийн эрх нь нээгдээгүйгээс зарцуулагдаагүй, буцаан төвлөрүүлсэн.		22,800.0
3	2016	118,852.4	2016 оны эхний хагас жилийн байдлаар төсвийн хуваарьт өөрчлөлт ороогүй, хуваарилалт хийгдээгүй байна.		

Хүснэгтээс харахад: Зөвхөн 2015 онд дээрх цэцэрлэгүүдийн батлагдсан төсөв дээр нэмж, нийт 38,718.4 мянган төгрөгийг дахин хуваарилсан байна. Харин БСГ-ын 2014 оны төсвийн хуваарь, гүйцэтгэлийн мэдээ, тайлан аудитын явцад олдоогүй тул тус оны мэдээллийг тодруулах боломжгүй байна.

Дээрх зөрчлүүд нь батлагдсан төсвийг хэтрүүлэх, зориулалтын бус зүйлд зарцуулах, төсвийн үргүй зардал гаргах, төсвийн үр өгөөжийг бууруулах гол шалтгаан болохоос гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Уг Канад цэцэрлэгт “Боловсролыг дэмжих олон улсын түншлэлийн Сургуулийн өмнөх боловсрол төсөл”-өөс 2014 онд нийт 53,569.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө болон бараа материалыг үнэ төлбөргүйгээр олгосныг тухайн үед БСГ-ийн дарга байсан Д.Пүрэвцэцэг, нягтлан бодогч Г.Ганцэцэг нар хүлээн авсан гэх боловч хүлээн авсан тухай холбогдох баримт материалыг БСГ-т үлдээгээгүй байна. Уг хөрөнгийг одоог хүртэл аль нэг байгууллагын хөрөнгөнд орлого авч бүртгэж, тайлагнаагүй, Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн болон иргэн Н.Эрдэнэбаатарын контенерт тус тус хадгалуулсан боловч 5 дугаар сургууль болон иргэн Н.Эрдэнэбаатарт хүлээлгэн өгсөн, хүлээлцүүлсэн ямар нэгэн баримт, материал байхгүй байна.

Харин иргэн Н.Эрдэнэбаатартай хөрөнгө хадгалуулах гэрээ байгуулж, уг гэрээний дагуу ажлын хөлсөнд улирал бүр 270.0 мянган төгрөгийг БСГ-ын цалингийн сангаас өгдөг боловч уг гэрээнд хичнээн төгрөгийн ямар, ямар хөрөнгө хадгалуулах тухай хөрөнгийн жагсаалт гарган хүлээлгэж өгөөгүй байна. Аудитын явцад уг хөрөнгөнд тулган баталгаажуулах тооллого хийхээр очиход хадгалж буй хөрөнгийн жагсаалт, баримт байхгүйгээс гадна тухайн хөрөнгө хадгалж буй айл нь контейнерын үүдэнд гэрээ хураасан байсан тул үзэх, тоолох боломжгүй байлаа.

Мөн тус Канад цэцэрлэгийн нэр дээр хүүхдийн оюун ухааны тоглоомууд ирсэн боловч уг тоглоомуудыг БСГ-аас хэн хүлээн авсан, хичнээн тоглоом байгаа талаар холбогдох баримт материал нь олдохгүй байгаагаас гадна уг тоглоомуудыг 5 дугаар сургуулийн агуулахад хадгалуулсан байна.

Гэтэл уг тоглоомуудыг аль нэг байгууллагын дансанд бүртгэж, эзэнжүүлээгүй, мөн хүлээлцсэн тухай холбогдох акт баримт байхгүй байлаа. Энэ нь БСГ-ын удирдлага, санхүү бүртгэлийн ажилтнууд болон бусад холбогдох ажил хариуцсан ажилтнуудын жлын хариуцлага сул, хөрөнгөнд бүргэлээр тавих хяналт байхгүй, мөн салбарын дотоод хяналт ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Иймд Канад цэцэрлэгийг ашиглалтанд ортол нэр дээр нь ирсэн дээрх хөрөнгүүдийн анхан шатны баримтуудыг тухайн үед ажил хариуцаж байсан, хүлээн авсан холбогдох албан тушаалтан, ажилтануудаас авч, БСГ-ын хөрөнгөнд түр бүртгэж, эзэнжүүлэн, хяналт тавьж ажиллах, хэрэв холбогдох баримт бичиг олдохгүй тохиолдолд БСШУЯ-ны төсөл хариуцсан холбогдох мэргэжилтнээс баримтыг нөхөн авах, мөн 2016 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор уг цэцэрлэгийн хөрөнгүүдийг тооллогод бүрэн хамруулж, бүрэн бүтэн байдлын тооцоог бодож, бүртгэл, тайланд тусгах тухай хугацаатай албан шаардлагуудыг тус тус аймгийн БСГ-ын удирдлагад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын явцад Канад цэцэрлэгийн зарим хөрөнгөнд хэсэгчилсэн тооллого хийж, байвал зохих 3,142.9 мянган төгрөгийн хөрөнгийг тооллогод хамруулахад 2,951.0 мянган төгрөгийг хөрөнгө тоологдож, 6 нэр төрлийн 191.9 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан тул холбогдох эздээр нь төлүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

1.7 Аймгийн ЕБС-ууд 2015-2016 оны хичээлийн жилд батлагдсан орон тоог 10 орон тоогоор хэтрүүлэн ажиллаж 139,992.2 мянган төгрөгийн цалингийн өр үүсгэсэн байна.

Сургуулиудын 2015 оны цалингийн төсвийг өмнөх оноос 79,839.2 мянган төгрөгөөр, байгууллагаас ирүүлсэн саналаас 351,076.3 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан, мөн батлагдсан орон тоог 10 орон тоогоор хэтрүүлэн ажилласнаас шалтгаалан 139,992.2 мянган төгрөгийн цалингийн өр үүссэн байна.

ЕБС-ийн 2016 оны эхний хагас жилд батлагдсан төсвийн санхүүжилтээ бүрэн авсан боловч 398,809.1 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь БСШУС-ын 2016 оны 1/4502 дугаар албан тоотын дагуу 8 дугаар сарын санхүүжилтээс, 6 дугаар сарын санхүүжилтийг нэмэгдүүлэн санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулж багш, ажилчдын амралтын нөхөн олговрыг бүрэн олгуулах арга хэмжээ авсан байна. Тухайлбал: Сүүлийн хагас жилд олгох хуваарьтай тэтгэвэрт гарах болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, багш, ажилчдын амралтын мөнгө зэргийг эхний хагас жилд олгож, эхний хагас жилд төлөгдөх түлш халаалтын зардлыг 3 дугаар улирлын хуваарьт оруулж зохицуулалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулдаг байх", 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Боловсрол, соёлын салбарын батлагдсан төсөв, санхүүжилт болон үйл ажиллагааны орлого, бусад төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийг үнэн зөв бүртгэж тайлагнасан уу?

Бүлэг 2.

2015 онд ЕБС болон СӨББ-уудын батлагдсан төсвийн санхүүжилтийг нийт 167,897.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

2.1 2014-2016 онд зарим Боловсрол, соёлын байгууллагуудад батлагдсан төсвийн санхүүжилтийг 233,101.8 мянган төгрөгөөр илүү, 101,125.9-108,299.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Аймгийн Боловсрол, соёлын салбарын хэмжээнд 2014 онд 5,601,790.8 мянга, 2015 онд 6,026,387.2 мянга, 2016 оны эхний хагас жилд 3,464,138.6 мянган төгрөгийн төсөв тус тус батлагдаж, гүйцэтгэлээр 2014 онд 5,832,436.0 мянга, 2015 онд 5,840,087.3 мянга, 2016 оны эхний хагас жилд 3,363,012.7 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Боловсрол, соёлын салбарын 2014-2016 оны батлагдсан төсөв, олгосон санхүүжилтийн судалгааг хүснэгтээр харуулбал:

		/мян.төг		
№	Шалтгаан	2014 он	2015 он	2016 он

		Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зөрүү	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зөрүү	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зөрүү
1	БСГ	93,019.1	90,562.5	2,456.6	80,122.3	80,122.3	-	36,393.0	36,393.0	-
2	ЕБС	3,604,078.2	3,604,078.2	-	3,555,440.1	3,471,452.2	83,987.9	2,054,511.5	2,054,511.5	-
3	СӨББ	1,110,770.5	1,343,872.3	-233,101.8	1,593,059.4	1,509,149.4	83,910.0	990,736.2	889,610.3	101,125.9
4	СУБ	793,923.0	793,923.0	-	797,765.4	779,363.4	18,402.0	382,497.9	382,497.9	-
Нийт дүн		5,601,790.8	5,832,436.0	-230,645.2	6,026,387.2	5,840,087.3	186,299.9	3,464,138.6	3,363,012.7	101,125.9

Батлагдсан төсвөөс 2014 онд 233,101.8 мянган төгрөгийг илүү, 2,456.6 мянган төгрөгийг дутуу, 2015 онд 186,299.9 мянга, 2016 оны эхний хагас жилд 101,125.9 мянган төгрөгийг тус тус дутуу санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- 2014 онд СӨББ-д 233,101.8 мянган төгрөгөөр илүү, БСГ-т 2,456.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн,
- 2015 онд ЕБС-д 83,987.9 мянга, СӨББ-д 83,910.0 мянга, СУБ-д 18,402.0 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэн,
- 2016 оны эхний хагас жилд СӨББ-д 101,125.9 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэн байна.

2.1.1 ЕБС-уудад 2015 онд батлагдсан төсвийг 83,987.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Аймгийн ЕБС-уудад 2014 онд 3,604,078.2 мянга, 2015 онд 3,555,440.1 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт олгохоор батлагдсан бөгөөд 2014 онд батлагдсан төсвийг бүрэн олгосон, 2015 онд 3,471,452.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 83,987.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

2016 оны эхний хагас жилд 2,054,511.5 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг бүрэн олгосон байна.

ЕБС-уудын 2014-2015, 2016 оны эхний хагас жилийн батлагдсан төсөв болон гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Сургуулиудын нэр	2014 он			2015 он			2016 оны эхний хагас жил		
		Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зөрүү	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зөрүү	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зөрүү
1	1-р сургууль	872,022.0	872,022.0	0	872,207.6	845,225.1	26,982.5	452,573.0	452,573.0	0
2	2-р сургууль	724,110.7	724,110.7	0	726,876.7	725,102.8	1,773.9	375,069.2	375,069.2	0
3	3-р сургууль	716,848.2	716,848.2	0	665,682.7	646,856.8	18,825.9	382,740.1	382,740.1	0
4	4-р сургууль	359,636.0	359,636.0	0	358,505.0	356,032.1	2,472.9	235,798.1	235,798.1	0
5	5-р сургууль	931,461.3	931,461.3	0	932,168.1	898,235.4	33,932.7	594,850.2	594,850.2	0
Нийт санхүүжилтийн дүн		3,604,078.2	3,604,078.2		3,555,440.1	3,471,452.2	83,987.9	2,054,511.5	2,054,511.5	

Хүснэгтээс харахад: Сургуулиудын 2014 он, 2016 оны эхний хагас жилийн батлагдсан төсвийн санхүүжилтийг бүрэн, 2015 онд 83,987.8 мянган төгрөгөөр санхүүжилтийг дутуу олгосон байна.

2015 онд аймгийн ЕБС-уудад батлагдсан төсвийн санхүүжүүлтийг дутуу олгосон нь Сангийн Яамнаас зарим зардлын санхүүжилтийн зарцуулалтын эрх нээж өгөөгүйтэй холбоотой байна.

ЕБС-уудын суралцагчдын тоо 2014 онд 3,038 байсан бол 2015 онд 3,292 болж өмнөх оныхоос 8.4 хувиар буюу 254 суралцагчаар өссөн боловч төсвийг нь батлахдаа 2014 онд 3,604,078.2 мянга, 2015 онд 3,471,452.2 мянган төгрөгөөр буюу өмнөх оныхоос 3.7 хувь буюу 132,626.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

Энэ нь улс орон төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой хэдий ч, сургуулиудын бүтэц орон тоо, суралцагчдын өсөлт, бууралтын бодит тооцоо, судалгаа, анхан шатны нэгжүүдийн төсвийн төсөлд үндэслэлгүйгээр төсвийг баталсантай холбоотой байна.

Аймгийн ЕБС-уудад 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилд олгосон төсвийн санхүүжилт, суралцагчдын тооны судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Сургуулиудын нэр	2014 он		2015 он		2016 оны эхний хагас жил	
		Хүүхдийн тоо	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Санхүүжилт	Хүүхдийн тоо	Санхүүжилт
1	1-р сургууль	941	872,022.0	1046	845,225.1	1047	452,573.0
2	2-р сургууль	643	724,110.7	640	725,102.8	642	375,069.2
3	3-р сургууль	535	716,848.2	595	646,856.8	627	382,740.1
4	4-р сургууль	108	359,636.0	110	356,032.1	127	235,798.1
5	5-р сургууль	811	931,461.3	901	898,235.4	914	594,850.2
Нийт санхүүжилтийн дүн		3,038	3,604,078.2	3,292	3,471,452.2	3,357	2,054,511.5

Хүснэгтээс харахад: Зарим сургуулиудын хүүхдийн тоо нэмэгдсэн боловч, төсөв нь буурч батлагдсан байна. Тухайлбал:

- 2015 онд 1 дүгээр сургуулийн суралцагчийн тоо өмнөх оныхоос 105-аар өссөн байтал санхүүжилтийг нь 26,796.9 мянгаар,
- дугаар сургуулийн суралцагчдын тоо 60-аар нэмэгдэж, санхүүжилт нь 69,991.4 мянгаар,
- 4 дүгээр сургуулийн суралцагч 2-оор нэмэгдэж, санхүүжилт нь 3,603.9 мянгаар,
- 5 дугаар сургуулийн суралцагчдийн тоо 90-ээр нэмэгдэж, санхүүжилт нь 33,225.9 мянган төгрөгөөр тус тус буурч батлагдсан байна.

2.1.2. 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилд олгосон төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого, төсөл хөтөлбөрийн хүрээнд олгосон нэмэлт санхүүжилтуудыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна.

2014-2015, 2016 оны эхний хагас жилд ЕБС-ууд улсын төсвөөс олгосон санхүүжилт, үйл ажиллагааны орлого болон төсөл хөтөлбөрийн хүрээнд олгосон нэмэлт санхүүжилтүүдийг бүртгэл тайланд бүрэн тусгаж, тайлагнасан ба 2014 оны төсвийн санхүүжилтээс 3,379.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

ЕБС-уудын нэмэлт санхүүжилтийн дансаар 2014 онд 55,619.6 мянга, 2016 оны эхний хагас жилд 119.0 мянга, нийт 55,738.6 мянган төгрөгийн орлого орсныг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна.

2.2.1 Аймгийн БСГ-аас СӨББ-уудын батлагдсан төсвийг 2014 онд 233,101.8 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 17,723.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2015 онд 83,910.0 мянган төгрөгөөр бууруулан хуваарилсан байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд буюу цэцэрлэгүүдийн анхны батлагдсан төсөвт тодотгол хийж, 2014 онд 233,101.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 1,343,872.3 мянган төгрөгөөр, 2015 онд 83,910.0 мянган төгрөгөөр бууруулан 1,531,541.0 мянган төгрөгөөр, 2016 онд 101,125.9 мянган төгрөгөөр бууруулан 889,610.3 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар улсын цэцэрлэгүүдийн батлагдсан төсөв, олгосон санхүүжилтийн судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	2014 оны төсөв			2015 оны төсөв			2016 оны эхний хагас жилийн төсөв		
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү
1	1 дүгээр цэцэрлэг	221 376,6	245 810,9	- 24 434,3	397 874,0	336 753,8	61 120,2	227 363,6	227 861,4	- 497,8
2	2 дугаар цэцэрлэг	248 743,3	275 866,0	- 27 122,7	299 705,7	319 070,0	-19 364,3	182 590,4	184 854,5	- 2 264,1
3	3 дугаар цэцэрлэг	326 408,1	369 408,1	- 43 000,0	399 592,0	399 592,0	-	203 627,6	207 132,5	- 3 504,9
4	4 дүгээр цэцэрлэг	94 790,1	146 112,5	- 51 322,4	142 703,0	142 703,0	-	83 051,3	90 648,7	- 7 597,4
5	5 дугаар цэцэрлэг	219 452,4	306 674,8	- 87 222,4	291 666,3	311 030,6	-19 364,3	175 250,9	179 113,2	- 3 862,3
6	Канад цэцэрлэг				61 518,4	-	61 518,4	118 852,4		118 852,4
	Нийт санхүүжилтийн дүн	1 110 770,5	1 343 872,3	- 233 101,8	1 593 059,4	1 509 149,4	83 910,0	990 736,2	889 610,3	101 125,9

Дээрх хүснэгтээс харахад 2014 онд санхүүжилт 24,434.3–87,222.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн доод жишиг шинэчлэн батлагдсантай холбоотой байна.

2015 онд 1 дүгээр цэцэрлэгийн санхүүжилт 61,120.2 мянган төгрөгөөр илүү батлагдаж ирсэн нь шинээр тус цэцэрлэгийн өргөтгөлийн барилга баригдсантай холбоотой боловч уг барилга хугацаандаа ашиглалтад ороогүйгээс санхүүжилт нь хэмнэгдэж, БСГ-аас 61,120.2 мянган төгрөгийн санхүүжилтийг ЕБС-уудад хуваарилсан байна.

Харин ашиглалтанд ороогүй Канад цэцэрлэгт 2015 онд 61,518.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 2, 5 дугаар цэцэрлэгт нийт 38,728.6 мянган төгрөгийг нь хуваарилсан байна. Тухайлбал: Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгт цалин, НДШ-ийн зардал дутуу хуваарилагдсанаас 2014-2015 онд үүссэн өр төлбөрт 19,364.2 мянга, 5 дугаар цэцэрлэгийн хувьд 1 бүлэг шинээр нээн ажиллуулж 4 орон тоо нэмэгдсэнээс шалтгаалж үүссэн өр төлбөрийг барагдуулах зорилгоор 19,634.2 мянга, нийт 38,728.6 мянган төгрөг хуваарилсан байна.

Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгт ямар нэгэн тушаал шийдвэргүйгээр зөвхөн аймгийн Засаг даргын орлогчийн цохолт бүхий аймгийн БСГ-т ирүүлсэн Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэдийн өргөдлийн дагуу шинээр 1 бүлэг нэмж ажиллуулсан байна.

Канад цэцэрлэгийн үлдэгдэл 22,789.8 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй бөгөөд БСШУЯ-наас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж жилийн эцэст олгохоор хуваарилсан боловч зарцуулах эрх нээгээгүй байна.

2016 оны эхний хагас жилийн санхүүжилтийг 17,723.5 мянган төгрөгөөр илүү олгосон нь БСШУС-ын 2016 оны 1/4502 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулж багш, ажилчдын ээлжийн амралтын цалинг олгосонтой холбоотой байна.

Хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаарх батлагдсан төсөв болон олгосон санхүүжилтийн судалгааг хүснэгтээр харуулбал:

№ Байгууллагын нэр	2014 оны төсөв			2015 оны төсөв			2016 оны эхний хагас жилийн төсөв		
	Анх батлагдсан	Олгосон	Зөрүү	Анх батлагдсан	Олгосон	Зөрүү	Анх батлагдсан	Олгосон	Зөрүү
	/мян.төг/								
1 Бүжинхэн цэцэрлэг	42 034,1	42 034,1	-	33 748,4	33 748,4	-	11 345,0	11 345,0	-
2 Буян цэцэрлэг	56 303,2	56 303,2	-	36 134,5	39 134,5	- 3 000,0	22 930,0	22 930,0	-
3 Хонгорхон цэцэрлэг	55 552,2	55 552,2	-	36 191,5	39 191,5	- 3 000,0	16 900,0	16 900,0	-
4 Олуулаа цэцэрлэг	36 280,5	36 280,5	-	35 481,9	35 481,9	-	11 344,5	11 344,5	-
5 Ануухай цэцэрлэг	-	-	-	14 945,7	-	14 945,7	-	-	-
ДҮН	190 170,0	190 170,0	-	156 502,0	147 556,3	8 945,7	62 519,5	62 519,5	-

Дээрх хүснэгтээс харахад 2014-2016 оны эхний хагас жилийн байдлаар Бүжинхэн, Олуулаа цэцэрлэгт анх батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Харин 2015 онд Ануухай цэцэрлэгт 14,945.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж ирсэн боловч тусгай зөвшөөрөл олгогдоогүйгээс үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд уг цэцэрлэгийн төсвөөс Хонгорхон, Буян цэцэрлэгүүдэд тус бүр 3,000.0 мянга, 5 дугаар сургуульд халаалт, үдийн цайны өр барагдуулахаар 8,945.7 мянган төгрөгийг нэмж хуваарилсан байна.

Хонгорхон, Буян цэцэрлэгүүдэд 2014, 2016 онд батлагдсан төсвийг хуваарийн дагуу бүрэн олгож, 2015 онд НДШ, ХХОАТ-ын өр барагдуулах зорилгоор аймгийн ИТХ-ын даргын албан тоотыг үндэслэн тус бүр 3,000.0 мянга, нийт 6,000.0 мянган төгрөгийг Ануухай цэцэрлэгийн санхүүжилтээс нэмж хуваарилсан боловч Хонгорхон цэцэрлэгт 2,570.9 мянга, Буян цэцэрлэгт 1,926.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулах эрх нээгдээгүйгээс нийт 1,502.3 мянган төгрөгийн санхүүжилт буцаан татагдсан байна.

Аймгийн БСГ нь ашиглалтанд ороогүй болон тусгай зөвшөөрлөө аваагүй цэцэрлэгүүдэд төсөв батлуулан авч, зарим цэцэрлэгүүдийн батлагдсан төсвийн санхүүжилт дээр нэмж санхүүжилт олгосон, албан ёсны тушаал шийдвэргүйгээр цэцэрлэгүүдэд шинээр бүлэг нэмж ажиллуулсан зэрэг зөрчил дутагдал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 42 дугаар зүйлийн 42.4-д “энэ хуулийн 42.2-т

заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд тухайн тайлант жилийн төсвийг бодитой тоон мэдээлэл, өмнөх оны гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж, батлуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, салбарын төсвийн хуваарилалтыг үнэн зөв хийж, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зөвлөмжийг аймгийн БСГ-т өгөхөөр шийдвэрлэв.

2.2.2 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 2014 онд 1,343,079.2 мянга, 2015 онд 1,458,786.0 мянга, 2016 оны эхний хагас жилд 854,737.1 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгосныг үнэн, зөв бүртгэж, тайлагнасан байна.

Цэцэрлэгүүд 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаарх төсвийн санхүүжилтийн орлогыг тайлан тэнцэлд үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна.

2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаарх Цэцэрлэгүүдийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Байгуул-лагын нэр	2014 оны төсөв			2015 оны төсөв			2016 оны эхний хагас жилийн төсөв		
		Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	1 дүгээр цэцэрлэг	245 810,9	245 425,3	385,6	336 753,8	308 307,5	28 446,3	227 861,4	214 144,9	13 716,5
2	2 дугаар цэцэрлэг	275 866,0	275 787,6	78,4	319 070,0	311 740,0	7 330,0	184 854,5	178 368,8	6 485,7
3	3 дугаар цэцэрлэг	369 408,1	369 079,0	329,1	399 592,0	385 318,4	14 273,6	207 132,5	201 301,1	5 831,4
4	4 дүгээр цэцэрлэг	146 112,5	146 112,5	-	142 703,0	142 694,4	8,6	90 648,7	86 802,7	3 846,0
5	5 дугаар цэцэрлэг	306 674,8	306 674,8	-	311 030,6	310 725,7	304,9	179 113,2	174 119,6	4 993,6
Нийт санхүүжилтийн дүн		1 343 872,3	1 343 079,2	793,1	1 509 149,4	1 458 786,0	50 363,4	889 610,3	854 737,1	34 873,2

Дээрх хүснэгтээс харахад 2014 онд 793.1 мянга, 2015 онд 50,363.4 мянган төгрөг тус тус төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ашиглалтад орох хугацаа хойшлогдсоноос 2015 оны тогтмол зардал хэмнэгдэж 28,446.3 мянга,
- Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэг 7,330.0 мянга,
- Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг 14,273.6 мянга,
- Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг 8.6 мянга,
- Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 304.9 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн,

Харин Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэг, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгүүдэд оны эцэст хуваарилалт хийж, зарцуулах эрх нээгдээгүйгээс үлдэгдэл санхүүжилтийг төвлөрүүлсэн байна. Энэ нь төсвийг төлөвлөж, батлуулахдаа бодит тоон мэдээлэл, тооцоо судалгааг үндэслэн үнэн зөв төлөвлөж, батлуулаагүйтэй холбоотой байна.

Цэцэрлэгүүдийн 2016 оны эхний хагас жилийн байдлаар санхүүжилтийн 34,873.2 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг зардал тус бүрээр харуулбал:

/мян.төг/

№	Байгууллагын нэр	2016 оны эхний хагас жилийн харилцахын үлдэгдэл					Нийт үлдэгдэл
		Хоол	Гэрэл цахилгаан	Халаалт	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж/ хөдөө ОН	Бусад	
1	1 дүгээр цэцэрлэг	5 238,0	1 653,1	6 404,4	-	421,0	13 716,5
2	2 дугаар цэцэрлэг	3,5	105,9	-	5 665,2	711,2	6 485,8
3	3 дугаар цэцэрлэг	4 434,2	961,9	-	-	435,2	5 831,3
4	4 дүгээр цэцэрлэг	3 078,3	420,7	-	-	347,0	3 846,0
5	5 дугаар цэцэрлэг	-	93,5	-	4 900,0	-	4 993,5
Үлдэгдэл санхүүжилтийн дүн		12 754,0	3 235,1	6 404,4	10 565,2	1 914,4	34 873,1

Дээрх хүснэгтээс харахад 2016 оны эхний хагас жилийн байдлаар хоолны зардал 12,754.0 мянга, гэрэл цахилгааны зардал 3,235.2 мянга, халаалтын зардал 6,404.4 мянга, тэтгэвэрт гарахад олгох болон хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажилласны тэтгэмжийн зардал 10,565.2 мянга, бусад зардал 1,914.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна. Тэтгэвэрт гарахад олгодог тэтгэмж авах ажиллагсдын тэтгэвэр тогтоолгох хугацаа нь болоогүй учраас уг зардал олгогдоогүй бөгөөд бусад зардлууд нь хагас жилийн байдлаар хэмнэгдсэн байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлсэн орлогыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна.

Аймгийн цэцэрлэгүүдийн хэмжээнд 2014-2016 онд нэмэлт санхүүжилтийн дансдаар нийтдээ 8,800.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.Үүнд:

БСШУЯ-наас 2014 онд “Авъяас” хөтөлбөрийн хүрээнд 1, 5 дугаар цэцэрлэгүүдэд 2,000.0 мянга, 4 дүгээр цэцэрлэгт 1,500.0 мянга, нийт 5,500.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийг дансаар олгосон бөгөөд уг санхүүжилтээр ном худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгт аймгийн БСГ-аас аймгийн хэмжээний Боловсролын сургалтын чанар, үнэлгээг индексээр үнэлж “Тэргүүн байр” эзэлсний шагнал 3,300.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар нь олгосон бөгөөд уг шагналын мөнгийг ажиллагсдын шагнал урамшуулалд зарцуулсан байна.

2.3.1 Аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын батлагдсан төсвийн санхүүжилтийг 2015 онд 18,401.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Аймгийн хэмжээнд соёл, урлагийн үйл ажиллагаагаа явуулж байгаа 5 байгууллагад 2014 онд 793,923.0 мянга, 2015 онд 797,765.3 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 382,497.0 мянган төгрөгийн төсөв тус тус батлагдсан бөгөөд 2014-2016 онуудад батлагдсан төсвийг бүрэн олгосон, 2015 онд 779,363.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 18,401.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан төсөв, олгосон санхүүжилтийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/МЯН.ТӨГ/

№	Байгууллагын нэр	2014 он			2015 он			2016 оны эхний хагас жил		
		Батлагд-сан төсөв	Олгосон санхүү-жилт	Зөрүү	Батлагд-сан төсөв	Олгосон санхүү-жилт	Зөрүү	Батлагд-сан төсөв	Олгосон санхүү-жилт	Зөрүү
1	Боржигон чуулга	520,863.4	520,863.4	-	534,505.5	520,205.1	14,300.4	260,492.9	260,492.9	-
2	Номын сан	89,725.1	89,725.1	-	90,225.1	89,935.1	290.0	44,637.8	44,637.8	-
3	Музей	78,601.5	78,601.5	-	78,979.1	76,018.5	2,960.6	37,723.3	37,723.3	-
4	Баянтал сумын Соёлын төв	54,280.7	54,280.7	-	47,604.0	47,134.4	469.6	17,608.1	17,608.1	-
5	Шивээговь сумын Соёлын төв	50,452.3	50,452.3	-	46,451.6	46,070.3	381.3	22,035.8	22,035.8	-
Нийт санхүүжилтийн дүн		793,923.0	793,923.0	-	797,765.3	779,363.4	18,401.9	382,497.9	382,497.9	-

Хүснэгтээс харахад СУБ-уудад 2014 он, 2016 оны эхний хагас жилийн батлагдсан төсвийг бүрэн санхүүжүүлсэн бол 2015 онд 18,401.9 мянган төгрөгөөр санхүүжилтийг дутуу олгосон байна.

2015 онд аймгийн СУБ-уудад батлагдсан төсвийн санхүүжүүлтийг дутуу олгосон нь Сангийн Яамнаас зарим зардлын санхүүжилтийн зарцуулалтын эрх нээж өгөөгүйтэй холбоотой байна.

2.3.2 Соёл, урлагийн зарим байгууллагууд 2015-2016 оны үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нийт 21,028.9 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Соёл, урлагийн байгууллагуудад 2014 онд 22,042.6 мянга, 2015 онд 42,644.0 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 12,044.1 мянга, нийт 76,730.7 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдсан байна.

Орлогын төлөвлөгөөг 2014 онд 658.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн бол 2015 онд 20,362.4 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 389.0 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна. Тухайлбал: Боржигон чуулга 2015 онд 20,275.2 мянга, 2016 оны эхний хагас жилд Музей 158.9 мянга, Шивээговь сумын соёлын төв 500.0 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

Боржигон чуулга нь үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөгөө тасалсан нь уран бүтээлчдийн аялан тоглолтын орлогыг байгууллагын дансанд бүрэн төвлөрүүлэлгүйгээр зарцуулсантай холбоотой байна. Тухайлбал: Дундговь аймгийн 5 сумдад хийсэн аялан тоглолтын орлогыг байгууллагын касс болон төрийн сан дахь харилцах дансанд төвлөрүүлээгүй, уг тоглолтын билетийг Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулж тамга, тэмдэг даруулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, хяналтгүйгээр зарцуулж ирсэн байна.

Соёл, урлагийн байгууллагуудын 2014-2016 оны үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/МЯН.ТӨГ/

№	Байгууллага	2014 он	2015 он	2016 он эхний хагас жилийн байдлаар
---	-------------	---------	---------	-------------------------------------

		Төлөв- лөгөө	Гүйцэт-гэл	Зөрүү	Төлөв- лөгөө	Гүйцэт-гэл	Зөрүү	Төлөв- лөгөө	Гүйцэт-гэл	Зөрүү
1	Музей	488.7	501.5	12.8	488.7	496.3	7.6	244.2	85.5	-158.7
2	Номын сан	48.9	693.9	645.0	650.3	555.5	-94.8	24.3	145.50	121.2
3	Боржигон чуулга	19,550.0	19,596.7	46.7	39,550.0	19,274.8	-20,275.2	10,775.2	10,859.2	84.0
4	Шивээговь СТөв	1,000.0	1,000.0	-	1,000.0	1,000.0	-	500.0		-500.0
5	Баянтал СТөв	955.0	1,005.0	50.0	955.0	955.0	-	500.2	564.9	64.7
	Дүн	22,042.6	22,797.1	754.5	42,644.0	22,281.6	20,362.4	12,044.1	11,655.1	389.0

Хүснэгтээс харахад: Соёлын салбарын хэмжээнд орлогын төлөвлөгөөг 2015 онд Номын сан 94.8 мянга, Боржигон чуулга 20,275.2 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар Музей 158.9 мянга, Шивээговь сумын Соёлын төв 500.0 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

2015-2016 онд орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн нь үнэт цаас буюу билетийг сумын Төрийн сангаар хянуулж, дугаарлуулаагүй, үзвэр үйлчилгээ болон номын орлогыг нэр төрлөөр нь ангилж, бүртгээгүй зэргээс шалтгаалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг зөрчсөн байна.

Иймд Соёл, урлагийн байгууллагуудад үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, батлагдсан орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх, орлогыг нэр төрлөөр нь ангилан бүртгэж, үнэт цаас буюу билетийг сумын Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулж тооцоо хийж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.3.3 Соёл, урлагийн байгууллагууд 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилд олгосон төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого, төсөл хөтөлбөрийн хүрээнд олгосон нэмэлт орлогуудыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна.

2014-2015, 2016 оны эхний хагас жилд СУБ-ууд улсын төсвөөс олгосон санхүүжилт, үйл ажиллагааны орлого болон төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгосон нэмэлт санхүүжилтүүдийг бүртгэл тайланд бүрэн тусгаж, тайлагнасан ба 2014 оны төсвийн санхүүжилтээс 4,281.6 мянга, 2015 онд 16,275.7 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Соёлын байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансаар 2014 онд 67,920.2 мянга, 2015 онд 37,507.3 мянга, 2016 оны эхний хагас жилд 31,837.0 мянга, нийт 137,264.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Боржигон чуулга 2015 онд ОНХС-гаас аймгийн Засаг даргын нэрэмжит ардын урлагийн их наадмын зардалд 6,000.0 мянга, шинэ жилийн арга хэмжээний зардалд 2,000.0 мянга, шатахууны зардалд 300.0 мянга, нийт 8,300.0 мянга, 2016 оны эхний хагас жилд дуучин Э.Мягмарсүрэнгийн тайлан тоглолт хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 500.0 мянга,
- Боловсрол соёлын газар 2014 онд “Боловсролыг дэмжих” хөтөлбөрийн санхүүжилт 63,340.2 мянга, Мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр 4,580.0 мянга нийт 67,920.2 мянга,

- 2015 онд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас “Боловсролыг дэмжих” хөтөлбөрийн санхүүжилт 6113.2 мянга, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас ЗД-ын нэрэмжит ЕБС, СӨББ-ын индекстэй холбоотой гарсан зардалд 16,000.0 мянга, 2014 оны төсвийн урамшуулалд 800.0 мянга нийт 22,913.2 мянга,
- 2016 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн ОНХС-аас “Боловсролыг дэмжих” хөтөлбөрийн санхүүжилтэд 18,000.0 мянга,
- БСШУЯ-аас 2014 оны төсвийн урамшууллын зөрүү 597.2 мянга, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт 6,000.0 мянга, Шивээговь сумын 3 дугаар сургуулийн хөгжмийн боловсролыг дэмжих хөтөлбөрт 6,739.8 мянга. нийт 13,337.0 мянга,
- Музей нь 2015 онд аймгийн ОНХС-аас “Соёл, урлагийг дэмжин хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 4,794.1 мянга,
- 2015 онд Номын сан аймгийн ОНХС-гаас “Ном эрдмийн аян”-ы хүрээнд 1,500.0 мянган төгрөгийг тус тус бүртгэж, тайлагнасан байна.

**Боловсрол, соёлын салбарын төсвийн зарцуулалт
vо дvнтэй байна vv?**

Бүлэг 3

Боловсрол, соёлын салбарын хэмжээнд батлагдсан төсвийг
2014-2016 онд 147,920.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн
зарцуулсан байна.

3.1.1 2015 оноос ЕБС-уудад хэрэгжүүлж буй “Цөм” хөтөлбөртэй холбоотой 8 багш батлагдсан орон тооноос илүү ажиллуулж 61,869.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн ЕБС-уудад 2014 онд 181 багшийн орон тоо батлагдаж, 181 багш ажилласан бол 2015 онд 177 багшийн орон тоо батлагдаж, 185 багш ажилласан байна. 2015 онд багшийн орон тоо өмнөх оны гүйцэтгэлээс буурч батлагдсан нь сургалтын хөтөлбөрт үндэслэн ажиллах багшийн орон тоог батлаагүйтэй холбоотой байна.

2015 оноос аймгийн ЕБС-уудад “Цөм” хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотой багш нарын тоог нэмэгдүүлсэн боловч, төсвийг нь нэмэгдүүлэн батлаагүйгээс өглөг үүсэх шалтгаан болсон байна. Тухайлбал: ахлах, дунд ангийн сурагчдын хичээл сонголттой холбоотой 1 дүгээр сургуульд гадаад хэлний багш 2, бага ангийн багш 1, хоёрдугаар сургуульд математикийн багш 1, тавдугаар сургуульд математик-1, гадаад хэл-2, монгол хэлний багш-1, нийт 8 багшийг нэмж ажиллуулсан байна.

Мөн тус аймгийн хил залгаа зарим нэг аймаг, сумдын малчдын хүүхдүүд аймгийн сургуулиудад шилжин ирж суралцаж байгаа нь сургуулиудын суралцагчдын тоо болон орон тоо, төсөвт нөлөөлж байна.

Тухайлбал: 2016-2017 оны хичээлийн жилд харьяаллын бус нийт 325 хүүхэд суралцаж байна. Үүнээс: Сүмбэр сумын 1 дүгээр сургуульд 45.5 хувь буюу 148, 2 дугаар сургуульд 6.1 хувь буюу 20, 5 дугаар сургуульд 32.6 хувь буюу 106, Шивээговь сумын 3 дугаар сургуульд 9.2 хувь буюу 30, Баянтал сумын 4 дүгээр сургуульд 6.5 хувь буюу 21 хүүхэд тус тус суралцаж байна.

Сүмбэр сумын 1, 2 дугаар сургууль, Шивээговь сумын 3 дугаар сургууль тус бүр нэг, нэг бага ангийн бүлэгийг шинээр нэмж хичээллэсэн байна.

Сургалтын шинэ хөтөлбөр, шинээр бүлэг нэмэгдүүлэн ажилласантай холбоотой сургуулиудын бүтэц орон тоо, төсөв санхүүжилтийг нь нэмэгдүүлэх талаар аймгийн БСГ-аас тодорхой арга хэмжээ авч, холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэснийг зөрчиж байна.

2014-2015 он, 2016 оны эхний хагас жилд ЕБС-уудад ажиллаж буй багш нарын судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Орон тооны бүтэц	2014 он			2015 он			2016 оны эхний хагас жил		
		Төл	Гүйц	зө	Төл	Гүйц	зө	Төл	Гүйц	зө
1	Бага ангийн багш	57	57	0	57	59	2	59	60	1
2	Ахлах, дунд ангийн багш	124	124	0	120	126	6	119	126	7
	Нийт орон тоо	181	181	-	177	185	8	178	186	8

Дээрх судалгаанаас үзэхэд: Ахлах, дунд ангийн багш нарын тоо 2015-2016 оны эхний хагас жилд 8 багшаар тус тус нэмэгдсэн байна. Энэ нь ЕБС-уудад шинээр хэрэгжүүлж буй “Цөм” хөтөлбөрийн хүрээнд суралцагчид хичээлээ өөрсдөө сонгодог болсонтой холбоотой байна.

3.1.2 Аймгийн ЕБС-уудын анги дүүргэлт 2014-2015 онд 76.2 хувь байсан бол 2015-2016 оны хичээлийн жилд 78.4 хувь байна.

БСШУ-ны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 тоот хамтарсан тушаалаар баталсан журмын дагуу анги дүүргэлт дунджаар 33 байх ёстой боловч аймгийн ЕБС-уудын анги дүүргэлт 2014 онд 24 буюу 75.3 хувь, 2015 онд 25 буюу 77.2 хувь, 2016 онд 26 буюу 78.4 хувьтай байгаа нь анги дүүргэлтийн тогтоосон нормативт хэмжээнээс жил бүр 8-9 хүүхдээр дутуу байна.

Энэ нь анги, бүлгийн тоог холбогдох стандарт, тогтоосон норм, нормативаас илүү ажиллуулсантай холбоотой байна. Тухайлбал: 2014-2016 онд дунджаар

- Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 31 бүлэг байхаас 34,
- Сүмбэр сумын 2 дугаар сургууль 19 бүлэг байхаас 24,
- Сүмбэр сумын 5 дугаар сургууль 27 бүлэг байхаас 30,
- Шивээговь сумын 3 дугаар сургууль 18 бүлэг байхаас 22,
- Баянтал сумын 4 дүгээр сургууль 4 бүлэг байхаас 8, нийт 19 бүлгийг илүү нээж хичээллэсэн байна.

Иймд анги дүүргэлтийг тогтоосон нормативын дагуу зохион байгуулах, анги дүүргэлт, сурагчдын тоог харгалзан бүтэц орон тоо, төсөв, санхүүжилтийг нь батлуулж, олгож байх зөвлөмжийг аймгийн БСГ-т өгөхөөр шийдвэрлэв.

3.1.3. Аймгийн ЕБС-уудын хэмжээнд тэтгэвэр тогтоолгосон боловч ажиллаж буй 9 багш, ажилтан байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар тэтгэвэрээ тогтоолгоод ажиллаж байгаа нийт 9 багш, ажилчид байгаагаас Шивээговь сумын 1 багшаас бусад багш нарыг цалингийн сүлжээний ТҮБД-4-1 буюу эхний шатлалтаар цалинжуулж байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа багш, ажилчдын судалгааг сургууль бүрээр харуулбал:

№	Сургуулийн нэр	Газар зүй	Биологи	Техниологи	Бага анги		эмч	Орос хэл	Нийт дүн
1	1-р сургууль			1			1		2
2	2-р сургууль	1	1						2
3	3-р сургууль				1				1
4	4-р сургууль						1		1
5	5-р сургууль				1			2	3
	дүн	1	1	1	2		2	2	9

Хүснэгтээс харвал: Тэтгэвэрээ тогтоолгосон боловч ажиллаж байгаа нийт 9 багш, ажилчид байгаа бөгөөд 5 дугаар сургуульд 3 багш, 1, 2 дугаар сургуульд тус бүр 2 багш, 3, 4 дүгээр сургуульд тус бүр 1 багш байна. Эдгээр багш нарыг мэргэжлээр нь авч үзвэл бага ангийн болон орос хэлний багш тус бүр 2, эмч 2, газар зүй, биологи, технологийн мэргэжлийн багш тус бүр 1, 1 байна. Иймд:

- Цаашид тухайн мэргэжлийн чиглэлийн багш нарыг бэлтгэх ажлыг бодлогын түвшинд зохион байгуулах, хөдөлмөрийн насны багш, ажилтан авч ажиллуулах,
- Сургуулиудын бүтэц, орон тооны бодит байдал, хэрэгцээ шаардлагад үндэслэж төсвийн төлөвлөлтийг бодитой үнэн зөв төлөвлөн батлуулж байх,
- Салбарын үйл ажиллагааг зүй зохистой удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжүүдийг БСГ-т өгөхөөр шийдвэрлэв.

3.1.4. ЕБС-уудын үйлчлэгч нарын ажлын хэмжээ, цалин хөлс салбарын хэмжээнд харилцан адилгүй байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар ЕБС-уудын үйлчлэгч нарын цалин, цэвэрлэх талбай, ажлын ачаалал өөр өөр байгаа бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2001 оны 48 дугаар тушаалаар баталсан “Үйлчлэгчийн ажлын үлгэрчилсэн норм”-ыг баримталж ажиллаагүй байна.

ЕБС-уудын үйлчилгээний ажилтны тоо, хариуцсан талбай, олгож буй цалингийн харьцуулалтын судалгааг хүснэгтээр харуулбал:

Д/д	Сургуулийн нэр	Сарын цалин	Талбай	Үйлчлэгчийн тоо	Нэг үйлчлэгчид ногдох талбай
1	1-р сургууль	415,496	2,200	6	367
2	2-р сургууль	383,865	4,250	5	850
3	3-р сургууль	409,263	2,586	3	862
4	4-р сургууль	393,256	2,254	2	1127

5	5-р сургууль	373,600	2,058	6	346
---	--------------	---------	-------	---	-----

Судалгаанаас үзэхэд: Сургуулиудын нэг үйлчлэгчид ногдох цэвэрлэгээний талбай харилцан адилгүй байна. Тухайлбал: нэг үйлчлэгчид ногдох цэвэрлэгээний талбай 300-350 байх нормтой боловч 2,3 дугаар сургуулийн нэг үйлчлэгчид ногдох талбай 2 дахин, 4-р сургуулийн талбай 3 дахин их байна. Тухайлбал:

- 2 дугаар сургуулийн 4,250 м² талбайг 5 үйлчилэгч,
- 3 дугаар сургуулийн 2,586 м² талбайг 3,
- 4 дүгээр сургуулийн 2,254 м² талбайг 2 үйлчлэгч тус тус цэвэрлэж байхад
- 1 дүгээр сургуулийн 2,200 м², 5 дугаар сургуулийн 2,058 м² талбайг тус тус 6, 6 үйлчлэгч цэвэрлэж байна.

Дээрх судалгаанаас харвал зарим ЕБС-уудын үйлчилгээний ажилтнуудад ногдох талбайн хэмжээ, ажлын ачаалал нь стандарт хэмжээнээс их боловч олгож буй цалин нь харилцан адилгүй байна.

Энэ нь аймгийн БСГ-аас салбарын байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалт, нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллаагүйтэй холбоотой байна.

Иймд БСГ болон тухайн сургуулийн удирдлагад салбарын болон байгууллагын хэмжээнд үйлчлэгч нарын ажлын ачааллыг стандарт, норм нормативийн дагуу тогтоож, ажлын ачааллыг тэнцвэржүүлж, хэт өндөр ачаалалтай ажиллаж байгаа үйлчлэгч нарын ажлын ачааллыг багасгах, цалин хөлсний тэнцвэртэй биш байдалд анхаарч, тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.1.5 ЕБС-ууд 2015 оны батлагдсан төсвөөс 147,920.6 мянга, олгосон санхүүжилтээс 232,007.1 мянган төгрөгийн зардлыг илүү зарцуулж, нийт 232,007.1 мянган төгрөгийн, өглөг үүсгэсэн байна.

2015 онд Сүмбэр сумын 2-р сургуулиас бусад сургуулиуд батлагдсан төсвөө бүрэн зарцуулсан боловч, батлагдсан төсвөөс илүү 147,920.6 мянган төгрөгийн зардал гаргаж, өглөг үүсгэсэн нь төсөв хэтрүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

2015 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, үүссэн өглөгийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Сургуулиудын нэр	2015 он				
		Төсөв	Олгосон	Дутуу олгосон санхүүжилт	Тайлант хугацаанд үүссэн өр	зөрүү
1	1-р сургууль	872,207.6	845,225.1	26,982.5	30,846.9	3,864.5
2	2-р сургууль	726,876.7	725,102.8	1,773.9	1,773.9	0
3	3-р сургууль	665,682.7	646,856.8	18,825.9	43,105.2	24,179.4
4	4-р сургууль	358,505.0	356,032.1	2,472.9	45,853.4	43,380.5
5	5-р сургууль	932,168.1	898,235.4	33,932.6	110,427.7	76,496.2
Нийт санхүүжилтийн дүн		3,555,440.1	3,471,452.2	83,987.9	232,007.1	147,920.6

Хүснэгтээс харахад: Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 2015 оны төсвийн санхүүжилтийг 33,932.6 мянган төгрөгөөр дутуу олгосон боловч 110,427.7 мянга, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн төсвийн санхүүжилтийг 2,472.9 мянган төгрөгөөр дутуу олгосон боловч 45,853.4 мянга, Шивээговь сумын 3 дугаар сургуулийн төсвийн санхүүжилтийг 18,825.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байтал 43,105.2 мянган, нийт

батлагдсан төсвөөс илүү 232,007.1 мянган төгрөгийн зарцуулалтыг тус тус хийж, өглөг үүсгэн, төсөв хэтрүүлсэн байна. Тухайлбал:

- Сүмбэр сумын 1-р сургуулийн 2015 онд үүссэн өглөгийн 20,057.4 мянган төгрөг нь халаалтын зардал, 4,116.4 мянган төгрөг нь хоолны зардал 6,284.2 мянган төгрөг нь цалингийн зардлын өглөгүүд байна.
- Шивээговь сумын 3-р сургуулийн 2015 онд үүссэн өглөгийн 35,986.0 мянган төгрөг нь халаалтын зардал, 7,119.2 мянган төгрөг нь цалингийн зардлын өглөг байна. Тус сургуулийн байрны халаалтын талбайн хэмжээг орон нутагт мөрдөж буй халаалтын үнэ ханшаар тооцсон дүн нь 108,662.4 мянган төгрөг байгаа боловч тайлант онд халаалтын зардалд 75,126.2 мянган төгрөгийн төсөв баталж, хуваарилсантай холбоотой байна.
- Баянтал сумын 4-р сургуулийн 2015 оны өглөгийн 39,000.0 мянган төгрөг нь халаалтын зардал, 6,853.5 мянган төгрөг нь цалингийн зардлаас үүссэн бөгөөд халаалтын зардалд 119,801.4 мянган төгрөг зарцуулах байтал, тайлант онд 77,831.0 мянган төгрөг баталж, хуваарилсантай холбоотой байна.

Сүмбэр сумын 5-р сургуулийн 2015 оны өглөгийн 20,029.6 мянган төгрөг нь түлш халаалт, 23,978.7 мянган төгрөг нь тэтгэвэр тэтгэмж, 12,935.7 мянган төгрөг нь хоол, 53,483.7 мянган төгрөг нь цалингийн зардлын өглөгүүд байна.

Тус сургуулийн халаалтын болон хоолны зардлын өглөг нь санхүүжилт дутуу ирсэнтэй, цалингийн зардлын өглөг нь 2014 оноос Олон улсын Лаборатори сургуулийн хөтөлбөрт хамрагдан “Лаборатори” сургууль болсон бөгөөд Засгийн газрын 2012 оны 179 дүгээр тогтоолд заасны дагуу ажиллагсдад олгох Лаборатори сургуулийн нэмэгдэл цалинг жил бүр төсөвтөө тусган олгож байхаар заасан боловч тус сургууль 2015 оны төсөвт нэмэгдэл цалингаа тусгаж, батлуулалгүй нийт 64,333.5 мянган төгрөгийн лабораторийн нэмэгдэл цалин олгож, цалингийн зардлын өр үүсгэсэн байна. Сүмбэр сумын 5 дугаар сургуульд 23,978.7 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн төсөв нь батлагдсан боловч санхүүжилт олгогдоогүйгээс өглөг үүсгэсэн байна.

ЕБС-ууд нь 2016 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан төсвийн санхүүжилтээ бүрэн авч зарцуулсан боловч 398,809.1 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь БСШУ-ны сайдын 2016 оны 1/4502 дугаар албан бичгээр 8 дугаар сарын санхүүжилтээс, 6 дугаар сарын санхүүжилтийг нэмэгдүүлж санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулан багш, ажилчдын ээлжийн амралтын цалинг эхний хагас жилд багтаан бүрэн олгох арга хэмжээ авах тухай чиглэл ирсэний дагуу санхүүжилтийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулсантай холбоотой байна.

2016 оны эхний хагас жилд батлагдсан төсөв, гүйцэтгэл, үүссэн өглөгийн судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Сургуулиудын нэр	2016 оны эхний хагас жил				
		Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зарцуулсан төсөв	Тайлант хугацаанд үүссэн өр	Нийт өглөгт эзлэх хувь
1	1-р сургууль	452,573.0	452,573.0	452,573.0	30,717.9	7.7
2	2-р сургууль	375,069.2	375,069.2	375,069.2	62,000.0	15.5
3	3-р сургууль	382,740.1	382,740.1	382,740.1	106,841.9	26.8

/мян.төг/

4	4-р сургууль	235,798.1	235,798.1	235,798.1	57,684.1	14.5
5	5-р сургууль	594,850.2	594,850.2	594,850.2	141,565.2	35.5
Нийт дүн		2,054,511.5	2,054,511.5	2,054,511.5	398,809.1	100

Хүснэгтээс харахад: Нийт өрийн 35.5 хувийг 5 дугаар сургууль, 26.8 хувийг Шивээговь сумын 3 дугаар сургууль, 15.5 хувийг 2 дугаар сургууль, 14.5 хувийг Баянтал сумын 4 дүгээр сургууль, 7.7 хувийг Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн өглөгүүд тус тус эзэлж байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-т “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

3.1.6 Нэмэлт санхүүжилтийн дансдад төвлөрүүлсэн 55,619.6 мянган төгрөгийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан байна

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын 72.0 хувь буюу 40,000.0 мянган төгрөгийг “Авьяас” хөтөлбөрт, 13.0 хувь буюу 7,300.0 мянган төгрөгийг шилдэг сургуулийн шагналд, 3 хувь буюу 1,500.0 мянган төгрөгийг хөшөө барихад аймгийн ОНХС-аас, 5 хувь буюу 3,000.0 мянган төгрөгийг өмнөх оны төсвийн урамшуулалд, 7 хувь буюу 3,819.6 мянган төгрөгийг дугуйлан ажиллуулсан багшийн ажлын хөлсөнд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг диаграммаар харуулбал:



2012 оноос хүүхэд бүрийн авьяасыг хөгжүүлэх зорилгоор БСШУЯ-наас “Авьяас” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой, 2014 оноос сургууль тус бүрт 10,000.0 мянган төгрөг олгосон /бүжгийн гутал, хөгжим, оньсон тоглоом/ бөгөөд ирсэн хөрөнгийг сургуулиуд бүртгэл тайландаа бүрэн тусгасан байна.

3.1.7 БСШУЯ-аас ЕБС-уудад хэрэгжүүлж буй “Цөм” хөтөлбөр, “Лаборатори” сургуулийн нэмэгдлүүдтэй холбоотой батлагдаагүй цалин, нэмэгдэл урамшууллыг олгосноос цалингийн зардал хэтэрсэн байна.

ЕБС-уудын 2014-2016 оны цалингийн сан нийт төсвийн 62.7-66.8 хувийг эзэлж байгаа бөгөөд цалингийн сангийн төсөв 2014 онд 2,258,608.1 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 2,283,258.1 мянга, 2015 онд 2,374,289.7 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 2,367,752.1 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 1,311,209.6 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 1,348,062.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Сургуулиудын 2014-2015 оны цалингийн зардлын төсөв, гүйцэтгэлийн харьцуулалтын шинжилгээг хүснэгтээр харуулбал:

Байгууллагуудын нэр	2014 он			2015 он			2016 оны эхний хагас жил			Харьцуулалт	
	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төс 2015/2014	Гүй 2015/2014
1 дүгээр сургууль	575,073.6	575,073.1	0.5	622,769.2	622,407.2	362.0	339,020.0	338,790.7	229.3	8.2%	8.2 %
2 дугаар сургууль	465,602.7	462,748.1	2,854.6	484,959.2	485,590.6	-631.4	259,431.4	296,518.4	37,087.0	4.2%	4.9%
3 дугаар сургууль	453,448.3	453,448.3	0	454,103.9	448,140.2	5,963.7	234,040.3	234,040.3	0	0	-1.2%
4 дүгээр сургууль	186,634.5	186,049.7	584.8	203,747.8	202,961.9	785.9	105,784.2	105,784.2	0	9.2%	9.0%
5 дугаар сургууль	577,849.0	605,938.9	-28,089.9	608,709.6	608,652.2	57.4	372,933.7	372,929.1	4.6	5.3%	0.4%
Дүн	2,258,608.1	2,283,258.1	-24,650.0	2,374,289.7	2,367,752.1	6,537.6	1,311,209.6	1,348,062.7	-36,853.1	5.1%	3.7%

Хүснэгтээс харахад: 2015 оны ЕБС-уудын цалингийн сангийн батлагдсан төсөв өмнөх оныхоос нийт дүнгээрээ 5.1 хувиар өссөн ба сургуулиудын төсөв 4.2-9.2 хувиар нэмэгдэж батлагдсан байна. Тухайлбал: Сүмбэр сумын 1,2,5 дугаар сургуулийн батлагдсан төсөв 4.2-8.2 хувь, гүйцэтгэл 0.4-8.2 хувиар, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн батлагдсан төсөв 9.2 хувь, гүйцэтгэл 9.0 хувиар тус тус өмнөх оноос өссөн бол Шивээговь сумын 3 дугаар сургуулийн батлагдсан төсөв өмнөх оноос өөрчлөгдөөгүй бөгөөд гүйцэтгэл 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ЕБС-уудын цалингийн сангийн батлагдсан төсөв 2015 онд 6,537.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн бол 2014 онд 24,650.0 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 36,853.1 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна. Үүнд:

- 2014 онд Сүмбэр сумын 5 дугаар сургууль 28,089.8 мянга,
- 2015 онд Сүмбэр сумын 2 дугаар сургууль 631.4 мянга, 2016 онд 37,078.0 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна.

Энэ нь батлагдсан орон тооноос хэтрүүлэн ажилласан, цалингийн сангийн зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн, зөв төлөвлөж, батлуулаагүйтэй холбоотой байна.

Мөн 2015 онд Сүмбэр сумын 5 дугаар сургууль “Лаборатори” сургууль болсонтой холбоотой багш нарт олгох нэмэгдэл цалинг тухайн тайлант оны төсөвт тусган батлуулаагүй боловч уг нэмэгдлийг олгон цалингийн сангийн батлагдсан төсвийг 28,089.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан ба энэ хэмжээгээр өглөг үүсгэсэн байна.

Сүмбэр сумын 5-р сургуулийн ажиллагсдад 2015 он, 2016 оны эхний хагас жилд олгосон лабораторийн нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг холбогдох баримт материалтай тулган баталгаажуулахад дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

1. 2014-2015 онд тус сургуулийн цалингийн зардлын төсвийг батлахдаа нэмэгдэл цалинг нэмэгдлийн нэр тус бүрээр батлаагүй, үндсэн цалин болон урамшуулалт цалин гэсэн ангиллаар баталсан,
2. 2015 онд тус сургуулийн багш ажиллагсдын лабораторийн нэмэгдэл цалингийн төсөв батлахдаа тусад нь салгаж батлалгүй нэмэгдэл цалингийн сангийн зардалд бөөн дүнгээр нь тооцож батлуулсан,
3. 2015 онд ажиллагсдад лабораторийн нэмэгдэл болон үр дүнгийн тооцсон урамшууллаас удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр, нотлох баримтыг үндэслэлгүй зөвхөн захирлын үзэмжээр хасаж, нэмж олгосон байна. Тухайлбал:
 - 2015 оны 01-12 сард нийт 176 хүнээс 1-21 хувь буюу 6,767.3 мянган төгрөгийг хасаж, 4 хүнд 70.8 мянган төгрөгийг нэмж,
 - 2016 оны эхний хагас жилд 2016 оны 01-06 сард нийт 127 хүнээс 1-29 хувь буюу 6.955.7 мянган төгрөгийг хасаж, 6 хүнд 84.3 мянган төгрөгийг нэмж,
 - Мөн 2015 онд ажиллагсдад үр дүнгийн урамшууллыг бодож олгохдоо 2015 оны 01-04 улиралд нийт 2 хүнээс 1-11 хувь буюу 3,079.7 мянган төгрөгийг хасаж, 6 хүнд 415.4 мянган төгрөгийг нэмж,
 - 2016 оны эхний хагас жилд 2016 оны 1, 2-р улиралд нийт 127 хүнээс 4-44 хувь буюу 3,474.0 мянган төгрөгийг хасаж, 1 хүнд 122.4 мянган төгрөгийг нэмж тус тус олгосон байна.

Дээрх зөрчлүүд нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т “Үр дүнгийн урамшлыг энэхүү журмын 2.4, 2.5-д заасан шийдвэрийг үндэслэн сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчийн үндсэн цалингаас дараах хувь хэмжээгээр сар бүр тооцож, улирал тутам олгоно” гэснийг зөрчсөн тул илүү олгосон 692.9 мянган төгрөгийн урамшуулалд төлбөрийн акт тогтоож, орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэхээр шийдвэрлэв.

Мөн тус сумын 2 дугаар сургууль 2015 онд 2 орон тоо илүү ажиллуулснаас цалингийн сан 631.4 мянган төгрөгөөр хэтэрсэн бол 2016 оны эхний хагас жилд төсвийн хуваарьт өөрчлөлт оруулснаас 37,087.0 мянган төгрөгөөр цалингийн сангийн батлагдсан төсвийг хэтрүүлж зарцуулсан байна. Засгийн газрын 2014 оны 75 дугаар тогтоолоор баталсан “Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” журмын 1,2,6 дугаар хавсралтуудын дагуу аймгийн ЕБС-ууд багш, ажиллагсдын үндсэн цалинг тогтоосон боловч үр дүнгийн гэрээний биелэлтээс шалтгаалан цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулсан байна.

ЕБС-уудын 2014-2016 оны тэтгэмж урамшууллын зардлын төсөв 2014 онд 322,070.9 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 321,002.9 мянга, 2015 онд 218,393.5 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 137,913.6 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 207,622.4 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 178,886.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ЕБС-уудын 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаарх тэтгэмж урамшууллын зардлын батлагдсан төсөв болон гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Сургуулиудын нэр	2014 он			2015 он			2016 оны эхний хагас жил		
	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1-р сургууль	95,047.0	94,953.7	93.3	67,419.4	23,218.1	44,201.3	43,185.0	25,000.0	18,185.0
2-р сургууль	78,631.2	78,592.2	39.0	70,805.2	70,003.7	801.5	32,392.5	30,777.4	1,615.1
3-р сургууль	59,118.6	59,115.2	3.4	20,291.4	20,291.4	0	27,497.5	27,497.5	0
4-р сургууль	28,407.5	27,479.3	928.2	21,022.7	7,451.6	13,571.1	33,876.1	24,940.4	8,935.7
5-р сургууль	60,866.6	60,862.5	4.1	38,854.8	16,948.8	21,906.0	70,671.3	70,671.3	0
дүн	322,070.9	321,002.9	1,068.0	218,393.5	137,913.6	80,479.9	207,622.4	178,886.6	28,735.8

Хүснэгтээс харахад: ЕБС-уудын тэтгэмж, урамшууллын зардал 2014 онд 1,068.0 мянга, 2015 онд 80,479.9 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 28,735.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

2015 онд тэтгэмжийн зардал их хэмжээгээр хэмнэгдсэн нь тэтгэвэрт гарах ажиллагсдын тэтгэмжийн санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой байна. Тухайлбал: Сүмбэр сумын 1-р сургуулийн 2, 5 дугаар сургуулийн 1, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн 1, нийт 4 ажилтны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн санхүүжилт дутуу ирсэн байна.

3.1.8. 2014-2016 онуудад хүчингүй болсон журмыг үндэслэн эд хариуцагч нарт 2,196.1 мянган төгрөгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг харгалзахгүй хавтгайруулан олгосон байна.

2014-2016 онуудад Сангийн сайдын 2002 оны 210 дугаар тушаалаар батлагдсан “Санхүү, бүртгэлийн ажилтнуудад тэдний үйл ажиллагааны үр дүнг үндэслэн шагнал, урамшуулал олгох тухай” хүчингүй болсон журмыг үндэслэн дор дурдсан сургуулиуд нягтлан бодогч, эд хариуцагч нарт нийт 2,196.1 мянган төгрөгийн шагнал, урамшуулал олгосон байна.

2014-2016 онуудад эд хариуцагч нарт олгосон урамшууллын судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

Урамшууллын дүн						
№	Сургуулиудын нэрс	2014 он	2015 он	2016 оны эхний хагас жил	Нийт	Нийт дүнд эзлэх хувь
1	1-р сургууль	235,0	469,1	0	704.1	32.1
2	2-р сургууль	-	447,0	0	447.0	20.3
3	3-р сургууль	0	110,3	110,3	220.6	10.0
4	4-р сургууль	407,9	416,5		824.4	37.6
	Нийт дүн	642,9	1,442,9	110,3	2,196.1	100

Хүснэгтээс харахад: 1 дүгээр сургууль нийт урамшууллын 32.1 хувь буюу 704.1 мянга, 2 дугаар сургууль 20.3 хувь буюу 447.0 мянга, 3 дугаар сургууль 10.0 хувь буюу 220.6 мянга, 4 дүгээр сургууль 37.6 хувь буюу 824.4 мянган төгрөгийн урамшууллыг тус тус олгосон байна.

Иймд Сангийн сайдын 2002 оны 210 дугаар тушаалаар батлагдсан “Санхүү, бүртгэлийн ажилтнуудад тэдний үйл ажиллагааны үр дүнг үндэслэн шагнал, урамшуулал олгох тухай” журам нь Сангийн сайдын 2006 оны 192 дугаар тушаалаар

хүчингүй болж, урамшуулал олгохгүй болсон тул эд хариуцагч нарт олгох урамшууллыг ажлын үр дүн, ур чадварыг харгалзан олгож байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2014-2016 онуудад ЕБ-ын сургуулиуд ажиллагсдад нийт 9 төрлийн цалингийн нэмэгдэл олгосон байна. Үүнд:

№	Нэмэгдлийн нэр	Үндэслэсэн хууль, эрх зүйн акт /Тогтоол шийдвэр/	Нэмэгдлийн хувь
Зэргийн нэмэгдэл			
1	Заах арга	ЗГ-ын 2007 оны 219 дүгээр тогтоолын 1,2 дугаар хавсралт	10
	Тэргүүлэх		15
2	Кабинет хариуцсан		5
3	Анги даалт		10
4	ЗАН		5
5	Говийн нэмэгдэл	ЗГ-ын 2001 оны 90 дүгээр тогтоолын 2-р хавсралт	8-10
6	Унаа	Дотоод журмын дагуу	200-1200 төгрөг
7	Ур чадварын нэмэгдэл		30
8	Үр дүнгийн урамшуулал	ЗГ-ын 2013 оны 393 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн сургуулийн болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшил олгох журам”	45
9	Лабораторийн нэмэгдэл	Олон улсын Лаборатори сургуулийн хөтөлбөрт хамрагдсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 179 дүгээр тогтоолд заасны дагуу ажиллагчдад олгох нэмэгдлийг жил бүр төсөвтөө тусган олгож байх	30 хүртэл


Дээрх нэмэгдлүүдээс унааны зардлыг аймгийн төвийн 3 сургууль харилцан адилгүй олгож байна. Тухайлбал: Сүмбэр сумын 1-р сургууль өдөрт 200 төгрөгөөр, 2, 3 дугаар сургуулиуд өдөрт 300 төгрөгөөр тус тус тооцож олгож байна. Энэ нь орон нутагт мөрдөгдөж байгаа тээврийн үнэ тарифтай нийцэхгүй байгааг эргэж харах шаардлагатай байна.

Ур чадварын нэмэгдлийг Шивээговь сумын 3 дугаар сургуулиас бусад сургуулиуд бүх багш, ажилчдад хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2-т “эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэд арга барилаар ажиллаж, өндөр амжилт гаргасан эсвэл гоц авьяастай ажилтанд ур чадварын нэмэгдлийг олгоно”, БСШУС, НХХС, Сангийн сайдын 2010 оны 362/112/183 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан ЕБС, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийн 5-т “Энэ журмын 1-т заасан төрийн үйлчилгээний албан хаагчдад тухайн сургууль, цэцэрлэгийн суралцагчдын сурлагын амжилтыг хагас жил тутамд үнэлсэн үнэлгээний үзүүлэлт нь тухайн аймаг, дүүргийн үнэлгээний үзүүлэлтийн дунджаас доошгүй байх нийтлэг шаардлагыг заавал хангасан тохиолдолд ур чадварын нэмэгдэл олгоно” гэснийг тус тус зөрчсөн байна.

2014, 2015 онд аймгийн төвийн 3 сургуулийн олгосон нэмэгдэл цалингийн бүтцийг диаграмаар харуулбал:


ЕБС-уудын нэмэгдэл 2014 он



Диаграмаас харахад нийт нэмэгдлийн 7.0 хувийг ур чадварын, 32.0 хувийг үр дүнгийн урамшуулал тус тус эзэлж байна. Тухайлбал:

- Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн нийт нэмэгдэл цалингийн 6.8 хувийг ур чадвар, 36.8 хувийг үр дүнгийн,
- 2 дугаар сургуулийн 11.5 хувийг ур чадвар, 31.9 хувийг үр дүнгийн,
- 5 дугаар сургуулийн 3.6 хувийг ур чадвар, 28.1 хувийг үр дүнгийн урамшуулал тус тус байна.

ЕБС-уудын нэмэгдэл 2015 он



Дээрх диаграмаас харахад нийт нэмэгдлийн 7.0 хувийг ур чадварын, 25.0 хувийг үр дүнгийн урамшуулал тус тус эзэлж байна. Тухайлбал:

- Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн нийт нэмэгдэл цалингийн 6.5 хувийг ур чадвар, 29.6 хувийг үр дүнгийн,
- 2 дугаар сургуулийн 13,6 хувийг ур чадвар, 25.8 хувийг үр дүнгийн,
- 5 дугаар сургуулийн 3.9 хувийг ур чадвар, 21.9 хувийг үр дүнгийн урамшуулал тус тус байна.

3.1.9. ЕБС-ийн хувьсах зардал тооцдог норм, норматив нь бодит хэрэгцээ шаардлагад нийцээгүй, мөн хүүхдийн үдийн цай хөтөлбөр болон дотуур байрны хоолны материалыг бэлтгэхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

2014-2016 онд ЕБС-ууд үдийн цай хөтөлбөрт 342,162.8 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 189,483.1 мянга, нийт 531,645.9 мянган төгрөгийг зарцуулсан боловч үдийн цай хөтөлбөр, хоолны материалын бэлтгэн нийлүүлэгчийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д “төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

ЕБС-уудын дотуур байрны хүүхдийн хоногийн хоолны зарцуулалтад тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй, холбогдох норм, нормативыг мөрдөж ажиллаагүйгээс дараах зөрчил, дутагдал гарсан байна. Үүнд:

- ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоолны өдөрлөгийг тухайн сургуулийн нягтлан бодогчоор хянуулалгүй зөвхөн сургуулиудын захирал хянан баталж байгаа нь хоолны орц, норм нь стандартын шаардлага хангаж буй эсэх, зарцуулалтыг үнэн зөв тооцсон эсэхэд бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан,
- Хоолны өдөрлөгийн анхан шатны маягт нь сургууль бүрт өөр өөр, зарим сургууль хянах хүснэгтгүй байхад зарим нь хүснэгттэй боловч тавих хяналтаа хэрэгжүүлээгүй, зарим нь стандартын дагуу бөглөөгүй,
Тухайлбал: 3-р сургуулийн хоолны өдөрлөгийн маягт хянах, олгох хүснэгтгүй, 5-р сургууль хянах хүснэгтгүй, 4-р сургууль бүрэн хүснэгттэй боловч хянах хүснэгтээр хяналтаа тавьдаггүй, мөн 5-р сургууль хоолны өдөрлөгийн маягтыг балын харандаагаар бөглөдөг, сургуулиудын хоолны өдөрлөгийн олгосон хэсгийн тоо хэмжээг засварласан,
- Эрүүл мэнд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 225/296 тоот хамтарсан тушаалаар баталсан байрны хүүхдийн хоногийн хоолны нормыг 3-5 дугаар сургуулиуд мөрдөөгүй, байрны хүүхдийн тоо засвартай,
- Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалаар баталсан “Хүнсний бүтээгдэхүүнийг хоолонд зориулан боловсруулахад гарах хорогдлын хэмжээ”-г мөрдөөгүй,
- ЕБС-уудын дотуур байрны хоолны зардлыг ЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан нормативт зардлыг үндэслэн гүйцэтгэлээр олгосон хоолны зардалтай тулган баталгаажуулахад 5-р сургууль дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 2014 онд 301.6 мянга, 2015 онд 1,120.9 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 939.7 мянга, нийт 2.362,2 мянган төгрөгийг илүү зарцуулсан зөрчил илэрсэн тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2014-2016 онуудад дотуур байрны хүүхдийн өдрийн хоолны нормативт зардлыг дунджаар 20.00-384.00 төгрөгөөр илүү, дутуу олгосны зэрэгцээ зарим дотуур байртай сургуулиуд хоолны материалыг их хэмжээгээр бэлтгэн, жил бүр их хэмжээний үлдэгдэлтэй гарсан байна. Тухайлбал: Сүмбэр сумын 5 дугаар сургууль 2014-2016 онд 20.00-106.00 төгрөгөөр илүү, Шивээговь сумын 3 дугаар сургууль 52.00-77.00 төгрөгөөр, Баянталын 4 дүгээр сургууль 10.00-384.00 төгрөгөөр тус тус дутуу олгосон байна.

2014-2015 онд ЕБС-ууд хоолны батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй бөгөөд 2015 онд Сүмбэр сумын 5 дугаар сургууль батлагдсан төсвийг бүрэн зарцуулсан хэдий ч 11,411.4 мянган төгрөгийн хүнсний материалыг илүү бэлтгэж, өглөг үүсгэсэн байна.

Мөн 2014-2016 онуудад хүнсний материалын үлдэгдлийг Баянтал сумын 4 дүгээр сургууль 16,167.0-19,787.2 мянга, Шивээговь сумын 3 дугаар сургууль 3,726.1-5,588.0 мянга, Сүмбэр сумын 5 дугаар сургууль 2,118.2-6,677.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Гэтэл Баянтал сумын 4 дүгээр сургуулийн хоолны материалын үлдэгдэл буруу тайлагнагдсан байна. Тухайлбал: 2014 онд хоолны зардлаас 3 аж ахуйн нэгж, байгууллага, 1 иргэнтэй шууд гэрээ байгуулан нийт 12,293.2 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч авлага үүсгэн бүртгэж тайлагнаагүй, мөн уг хоолны материалыг хүлээн аваагүй мөртлөө хүнсний материалын тайланд хий орлого авч, бараа материалын үлдэгдлийг дээрх дүнгээр өсгөж, мөн нярвуудын тайлан тооцоог тухай бүр хянаж, тооцоо бодож баталгаажуулаагүйгээс 2 няравтай холбоотой 5,084.5 мянган төгрөгийн дутагдал гарсаныг тус тус үлдэгдлээр бүртгэж, тайлан балансыг буруу илэрхийлсэн байна.

Иймд БСГ болон ЕБС-уудад хоолны өдөрлөгийн анхан шатны маягтыг салбарын хэмжээнд холбогдох журам зааврын дагуу нэг хэвийн маягтаар бүрэн хөтөлж, хэвших, хоолны зарцуулалтад шат шатны хяналтыг тавьж, нэгдсэн бодлого, арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

Сургуулиудын 2014-2016 оны хүнсний материалын үлдэгдлийн судалгаа

/мян.төг/

№	Сургуулиудын нэр	2014 он		2015 он		2016 он	
		Хүүхдийн тоо дунжаар	Үлдэгдлийн дүн	Хүүхдийн тоо дунжаар	Үлдэгдлийн дүн	Хүүхдийн тоо дунжаар	Үлдэгдлийн дүн
1	3-р сургууль	35	5,588.0	35	5,827.5	35	3,726.1
2	4-р сургууль	45	16,167.0	45	18,958.2	45	19,787.2
3	5-р сургууль	70	6,677.3	70	5,846.6	70	2,118.2

Судалгаанаас харахад: Баянтал сумын 4 дүгээр сургуулийн хүнсний бараа материалын үлдэгдэл нь жил бүр, дунджаар жилийн хоолны төсвийн 90.0 хувьтай тэнцэх хэмжээний үлдэгдэлтэй байна. Энэ нь дотуур байранд амьдардаг хүүхдийн тоог өндөр төлөвлөсөнтэй холбоотой байна. Тухайлбал: Баянтал сумын 4 дүгээр сургууль 2015 онд дотуур байранд нийт 10,523 хүүхэд/өдөр хооллоно гэж тооцож 24,362.1 мянган төгрөг төсөвлөсөн боловч, гүйцэтгэлээр 9,228 хүүхэд/өдөр хооллож, 21,274.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Аудитын явцад дотуур байртай 3, 4, 5 дугаар сургуулийн хүнсний бараа материалын үлдэгдлийг 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөр тасалбар болгон тооллого хийхэд дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

1. Баянтал сумын 4 дүгээр сургуулийн хүнсний материалын үлдэгдэлд 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдөр тооллого хийхэд 1,144,879 төгрөгийн үлдэгдэлтэй байсан

ба эд хариуцагчийн 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөр гаргаж ирүүлсэн тайлангаарх үлдэгдэл 2,509,656 төгрөг, зөрүү 1,364,777 төгрөгийн материал дутагдсан байна.

Мөн 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн байдлын тайлан дахь хүнсний материалын эхний болон эцсийн үлдэгдлийг тайлант оны орлого, зарлагын холбогдох бусад АШБ, материалтай тулган баталгаажуулж, эцсийн үлдэгдлийг тооцож үзэхэд санхүүгийн байдлын тайлангаарх хүнсний материалын 2016 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл 18,820,306 төгрөг, 2016 оны 10 сарын 17-ны байдлаарх хүнсний материалын санхүүгийн байдлын тайлангаарх эцсийн үлдэгдэл 18,522,498 төгрөг байна. Гэтэл аудитын явцад хийсэн тооллогоор 1,144,879 мянган төгрөгийн хүнсний материал тоологдсон ба нийт 17,377,619 төгрөгийн хүнсний материал дутагдаж байна.

Энэ нь тус сургууль 2014 онд 3 ААНБ, 2 иргэнд хүнсний материалын мөнгө шилжүүлсэн боловч хүнсний материалаа хүлээж авалгүй шууд хий орлого авснаар бүртгэж, одоог хүртэл хүнсний материалаа хүлээн авалгүй хий үлдэгдлээр бүртгэж, тайлагнаж байгаатай холбоотой байна. Мөн уг 3 ААНБ, 2 иргэнээс уг хүнсний материалыг авахаар авлагын дансанд авлага үүсгэн бүртгээгүй, хий орлого авч эдгээр байгууллага, иргэдээс авах авлагыг хаасан байна.

Иймд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хий орлого авсан 17,377,6 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдлийг залруулж, санхүүгийн тайлан балансыг үнэн зөв гаргах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2. Шивээговь сумын 3 дугаар сургуулийн хүнсний материалын 2016 оны 10 дугаар сарын 17-ны байдлаарх эд хариуцагчийн тайлангаар байвал зохих үлдэгдэл 3,789,360 төгрөг байгаа бөгөөд аудитын явцад тооллого хийж тулган баталгаажуулахад 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 1,872,800 төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байсан ба 1,916,560 төгрөгийн хүнсний бараа материал дутагдсан байна.
3. Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн хүнсний бараа материалын хадгалалт хамгаалалт хангалтгүй, тооллогоор 262.6 мянган төгрөгийн бараа материал дутагдаж болно. Үүнд:
 - Материалуудыг төрөл тус бүрээр эмхэлж, цэгцлээгүй,
 - Ижил төрлийн нэг ижил үнэтэй хөрөнгүүдийг ялгаж кодлоогүй,
 - Зарим хүнсний материал хэрэглээний шаардлага, стандарт хангахгүй болсон. Үүнд: 7,2 кг цагаан будааны хугацаа дууссан, 9 ширхэг хүнсний хивэг байна. Эдгээр шаардлага хангахгүй болсон хүнсний материалыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй,
 - Хүнсний бараа материалын үлдэгдлийг аудитын явцад тоолоход 3,501.682 төгрөгийн үлдэгдэл байсан ба эд хариуцагчийн 2016 оны 10 дугаар сарын 20-ний өдрөөр гаргаж ирүүлсэн тайлангаар 3,764.307 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хүнсний материалын байвал зохих үлдэгдэл 3,764.307 төгрөг, зөрүү /дутагдал/ 262,625 төгрөг байна.

Аймгийн хэмжээнд төрийн өмчит 5 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас үдийн цай хөтөлбөрт 2014 онд 1,527 хүүхэд хамруулахаар төлөвлөж, 1,459 хүүхэд хамруулж, 136,283.4 мянган төгрөг, 2015 онд 1,588 хүүхэд хамруулахаар төлөвлөж, 1,527 хүүхэд хамруулж, 137,500.7 мянган төгрөг, 2016 оны эхний хагас жилд 1,702 хүүхэд хамруулахаар төлөвлөж, 1,727 хүүхэд хамруулж, 70,033.5 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

2014-2016 ондуудад аймгийн ЕБС-ууд сурагчдын үдийн цай хөтөлбөр, байрны сурагчдын хоолны материалыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулалгүй, ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчиж шууд гэрээ байгуулан бэлтгэсэн байна. Тухайлбал: “Мишээгч Очир” ХХК нь Сүмбэр сумын 1,2 дугаар сургуулийн үдийн цайг сүүлийн 2-3 жилд шууд гэрээ байгуулан нийлүүлсэн байна.

ЕБС-уудын Үдийн цай хөтөлбөрийн 2014-2016 онуудын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Сургуулийн нэр	Төлөвлөсөн хүүхдийн тоо	Хамрагдсан хүүхдийн тоо	Зөрүү	Санхүүжилт					Тайлбар
					Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төвлөрүүлсэн	Зөрүү	
1	1-р сургууль	452	390	62	43,647.0	41,638.3	2,008.7	2,208.7	29.1	Авлага үүсгэсэн
2	2-р сургууль	305	307	-2	27,721.2	27,721.2	-		10.8	Авлагатай
3	3-р сургууль	293	293	0	24,293.4	24,538.2	(244.8)		-	Бүлэг нэмэгдсэн
4	4-р сургууль	75	67	8	7,307.1	6,729.2	577.9		-	Төвлөрүүлэлгүй зарцуулсан
5	5-р сургууль	402	402	0	36,089.7	35,656.5	433.2	1,170.9	(46.3)	Өглөг үүсгэсэн
Жилийн нийт дүн		1,527	1,459	68	139,058.4	136,283.4	2,775.0	3,379.7	(6.4)	
2015 он										
1	1-р сургууль	470	403	67	39,454.4	39,454.4	-		(4,175.5)	Өглөг үүсгэсэн
2	2-р сургууль	309	312	-3	28,510.7	27,621.6	889.1		(15.0)	Өглөг үүсгэсэн
3	3-р сургууль	322	332	-10	26,928.0	26,928.0	-		(237.8)	Бүлэг нэмэгдсэн тул өглөг үүсгэсэн
4	4-р сургууль	75	71	4	7,188.1	7,133.4	(54.7)		0	Төвлөрүүлээгүй
5	5-р сургууль	402	419	-17	36,308.6	36,308.6	-		(1,744.0)	Бүлэг нэмэгдсэн тул өглөг үүсгэсэн
Жилийн нийт дүн		1,588	1,527	61	138,335.1	137,500.7	834.4	-	(6,117.6)	
2016 оны эхний хагас жил										
1	1-р сургууль	560	560	0	17,719.5	17,719.5	-			
2	2-р сургууль	302	315	-13	11,746.5	13,346.5	(1,600.0)			Төсвийн хуваарьт өөрчлөлт орсонтой холбоотой
3	3-р сургууль	363	355	8	15,097.0	14,738.6	358.4			
4	4-р сургууль	75	75	0	7,532.0	3,659.4	3,872.6			
5	5-р сургууль	402	422	-20	22,336.0	20,569.5	1,766.5			
Хагас жилийн нийт дүн		1,702	1,727	-25	74,431.0	70,033.5	4,397.5			

Судалгаанаас харахад: 2014-2016 онд зарим сургуулийн үдийн цай хөтөлбөрт хамрагдвал зохих хүүхэд бүрэн хамрагдаагүйгээс төсвөө хэмнэсэн бол зарим нь хүүхэд нь бүрэн хамрагдсан хэдийч төсвөө хэмнэсэн байна. Харин зарим сургууль үдийн цай хөтөлбөрийн батлагдсан төсвийг 244.8-577.9 мянган төгрөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал:

- 2014 онд Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн үдийн цай хөтөлбөрт төлөвлөснөөс 67 хүүхэд дутуу хамрагдаж, батлагдсан төсөв 2,008.7 мянган төгрөг хэмнэгдсэнийг бүрэн төвлөрүүлсэн, 2015 онд төлөвлөсөн хүүхэд бүрэн хамрагдсан боловч батлагдсан төсвөө 1,175.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, өглөг үүсгэсэн нь бага ангийн 1 бүлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн үдийн цай хөтөлбөрт 2014 онд төлөвлөснөөс 2 хүүхэд илүү хамрагдаж, батлагдсан төсвөө бүрэн зарцуулсан, 2015 онд 3 хүүхэд

дутуу хамрагдаж, батлагдсан төсвөө 889.1 мянган төгрөгөөр хэмнэсэн нь санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой байна.

- Шивээговь сумын 3 дугаар сургуулийн үдийн цай хөтөлбөрт төлөвлөсөн хүүхэд бүрэн хамрагдсан боловч батлагдсан төсвөө 244.8 мянган төгрөгөөр, 2015 онд 10 хүүхэд дутуу хамрагдсан боловч батлагдсан төсвөө 237.8 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь шинээр бага ангийн 1 бүлэг нэмсэнтэй холбоотой байна.
- Баянтал сумын 4 дүгээр сургуулийн үдийн цай хөтөлбөрт 2014 онд төлөвлөснөөс 8 хүүхэд дутуу хамрагдаж, батлагдсан төсвөө 577.9 мянган төгрөгөөр, 2015 онд 4 хүүхэд дутуу хамрагдаж, батлагдсан төсвөө 54.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн боловч төвлөрүүлэлгүй зарцуулсан,
- Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн үдийн цай хөтөлбөрт 2014 онд төлөвлөсөн хүүхэд бүрэн хамрагдсан боловч батлагдсан төсвөө 433.2 мянган төгрөгөөр хэмнэж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн, 2015 онд 17 хүүхэд илүү хамрагдаж, батлагдсан төсвөө 1,477.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, өглөг үүсгэсэн байна. Энэ нь бага ангийн 1 бүлэг шинээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үдийн цайны чанар, хүртээмж үнэ ханшид хяналт тавих хяналтын зөвлөлийг сургууль бүр байгуулсан боловч сургуулиудын зөвлөлийн ажил харилцан адилгүй байна. Тухайлбал: Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн хяналтын зөвлөл 2014-2015 онуудад үдийн цай болон дотуур байрны хоолны чанар байдалд нэг ч хяналт хийгээгүй байхад Шивээговь сумын 3 дугаар сургуулийн хяналтын зөвлөлийн ажил тогтмолжсон байна.

Хоолны материалыг иргэн, ААНБ-тай гэрээ хийж бэлтгэж байгаа боловч гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний бичиг зэрэг баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй байна. Харин Сүмбэр сумын 5 дугаар сургууль аймгийн төвийн махны ченжээс мах авах гэрээтэй боловч, уг гэрээндээ худалдан авах махны үнийг тодорхой тусгалгүй тухайн үеийн зах зээлийн ханшаар худалдан авах гэрээ байгуулсан нь алдагдалд орох эрсдэлтэй байна.

Дээрх зөрчлүүд нь Монгол Улсын НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд тооллогоор дутагдсан хүнсний материалын нийт 19,556.8 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, БСГ болон ЕБС-уудад дараах зөвлөмжүүдийг өгөхөөр шийдвэрлэв.

- Сургуулиудын хяналтын зөвлөлийн ажлыг тогтмолжуулан, үдийн цай хөтөлбөрийн чанар хүртээмжийг сайжруулах,
- Дотуур байрны хоолны материал, болон үдийн цай хөтөлбөрийн бэлтгэн нийлүүлэгчийг сургууль бүр дээр нь ТБОНӨХБАҮХАТ хууль болон холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах.
- худалдан авалт хийхдээ холбогдох хууль, журмын дагуу бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудыг сонгон шалгаруулж, чанар стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэж байх

3.1.10 2014-2016 онд ЕБС-уудын суралцагчдын тоо 58-256-аар нэмэгдсэн боловч хувьсах зардлын зарцуулалт 5,925.7-19,729.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Аймгийн хэмжээнд ЕБС-ууд нэг хичээлийн жилд нийт 2,200 хүүхэд хүлээж авах нормативт хүчин чадалтай боловч жилдээ дунджаар 3,232 хүүхэд хүлээн авч, тогтоосон нормативт хүчин чадлаас 46.9 хувь буюу 1,032 сурагч илүү суралцаж байна. Энэ нь тус аймагт ЕБС-ийн хүртээмж хангалтгүй, цаашид ЕБ-ын 1-2 сургууль нэмж барих шаардлагатай байгааг харуулж байна.

2014 онд сургуулиудын хувьсах зардал салбарын хэмжээнд хэтрээгүй ч Шивээговь сумын 3 дугаар сургууль 465.3 мянган төгрөгөөр, Баянтал сумын 4 дүгээр сургууль 236.9 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

2015 оны хувьсах зардлын төсвийг өмнөх оноос 14,818.0 мянган төгрөг буюу 27.0 хувиар бууруулан баталж, гүйцэтгэлээр 5,166.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

2015 оны хичээлийн жилд ЕБС-д суралцагч хүүхдийн тоо 2014 оныхоос 256-аар, 2016 онд 314 сурагчаар тус тус нэмэгдсэн боловч, сургуулиудын хувьсах зардлын төсөв жил бүр буурч батлагдсан. Гэтэл гүйцэтгэлээр ихэнх сургуулиуд хувьсах зардлын төсвөө хэмнэсэн бөгөөд үүгээр сургуулиудын хувьсах зардлын төсөв хүрэлцээтэй байгааг харуулж байна. Энэ нь сургуулиудын хувьсах зардлын төсвийг бодит тоон мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж батлуулаагүйтэй холбоотой байна.

Мөн Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т “Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэсний дагуу хувьсах зардлын нормативыг 2014-2015 онуудад шинэчлэн тогтоогоогүйтэй холбоотой байна.

ЕБС-уудын хувьсах зардлын төсөв, гүйцэтгэлийн харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

Сургуулиудын нэр	Хүчин чадал	2014 он	2015 он	2016 оны эхний хагас жил
------------------	-------------	---------	---------	--------------------------

	Норматив	Хүлээн авсан хүүхэд	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хүлээн авсан хүүхэд	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хүлээн авсан хүүхэд	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1-р сургууль	640	941	18205.7	18100.9	104.8	1046	12294.2	11606.7	687.5	1047	15437.0	14694.8	742.2
2-р сургууль	320	645	11363.0	10621.7	741.3	629	5508.9	4752.6	756.3	629	3353.0	3259.2	93.8
3-р сургууль	360	535	9222.7	9688.0	-465.3	595	9688.0	6228.6	3459.4	627	3668.0	3740.1	-72.1
4-р сургууль	240	110	5486.9	5723.8	-236.9	127	3876.7	3555.1	321.6	139	3442.0	3101.8	340.2
5-р сургууль	640	811	10,500.0	10,388.9	111.1	901	8,592.4	8,650.8	-58.4	914	4072.2	4072.2	0
Нийт дүн	2200	3042	54778.2	54523.3	254.9	3298	39960.2	34793.8	5166.4	3356	29972.2	28868.1	1104.1

Судалгаанаас үзэхэд: ЕБС-уудын суралцагчдын тоо 2015 онд өмнөх оноос 256-аар нэмэгдсэн боловч гүйцэтгэлээр хувьсах зардал 19,729.5 мянга, 2016 онд суралцагчдын тоо өмнөх оноос 58-аар нэмэгдсэн боловч, гүйцэтгэлээр хувьсах зардал 5,925.7 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

3.1.11. ЕБС-ийн тогтмол зардлын төсвийг бодит тоон мэдээлэл, өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэн батлуулж, хуваарилахгүй байгаа нь төсөв хэтрэх гол шалтгаан болжээ.

ЕБС-ууд ашиглалтын буюу тогтмол зардлыг байрны халаалтын нийт талбайн хэмжээ, орон нутагт мөрдөгдөж байгаа үнэ ханшийг үндэслэн төсвийн төслийн санал боловсруулан хүргүүлдэг боловч зарим анхан шатны нэгж байгууллагын саналыг харгалзалгүйгээр үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүрэлцэхгүй хэмжээний төсөв баталж, хуваарилсан байна. Энэ нь аймгийн БСГ-ын төсвийн төлөвлөлт хангалтгүй, бодит тоо мэдээлэл, тооцоо судалгаа, гүйцэтгэлд үндэслэлгүй төлөвлөн батлуулж, хуваарилж буйтай холбоотой байна.

2014-2015 онд ЕБС-аас хүргүүлсэн тогтмол зардлын төсвийн төсөл, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал.

/мян.төг/

Д/д	Сургуулийн нэр	Төсвийн санхүүжилт /мян.төг/			Хэм/+/, хэт/-/
		Байгууллагын санал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	
1-р сургууль					
1	2014	86,752.7	78,361.8	78,361.8	
2	2015	85,232.8	101,024.7	79,602.9	21,421.8
2-р сургууль					
3	2014	122,000.0	117,968.1	117,961.2	6.9
4	2015	133,906.8	110,387.2	111,842.8	(1,455.6)
3-р сургууль					
5	2014	79,800.0	79,793.3	79,793.3	-
6	2015	76163.4	81,140.5	81,140.5	
4-р сургууль					
7	2014	83,000.0	82,819.6	82,818.9	0.7
8	2015	86,695.6	85,497.6	82,467.4	3,030.2
5-р сургууль					
9	2014	101,301.6	135,517.0	110,661.5	24,855.5
10	2015	143,064.1	139,804.1	128,637.6	11,166.5

Судалгаанаас үзэхэд: 2014 онд Сүмбэр сумын 5 дугаар сургууль, 2015 онд Сүмбэр сумын 1 дүгээр, Шивээговь сумын 3 дугаар сургуулиудад хүргүүлсэн саналаас нь өндөр, бусад сургуулийн тогтмол зардлын төсвийн саналыг 180.4-23,519.6 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Мөн 2015 оноос зарим сургуулийн тогтмол зардал хэтэрч, өглөг үүссэн бол зарим сургуулийн тогтмол зардал их хэмжээгээр хэмнэгдсэн байна. Үүнд: Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн тогтмол зардал 21,421.8 мянга, 4 дүгээр сургуулийн тогтмол зардал 3,030.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн бол 2 дугаар сургууль 1,455.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Батлагдсан төсвөө хэтрүүлэн зарцуулсан Сүмбэр сумын 1 дүгээр сургууль, Баянтал сумын 4 дүгээр сургуулиуд гадны байгууллагад түрээслэж байсан талбайг өөрсдөө ашиглах болсон, мөн 2015 онд аймгийн дулаан нийлүүлдэг байгууллагуудын 1 м² талбайн халаалтын үнэ нэмэгдсэн боловч, халаалтын зардлыг нэмэгдсэн үнэ ханшаар тооцож батлуулаагүйтэй холбоотой байна.

Эдгээрээс үзвэл аймгийн БСГ нь ЕБС-уудын төсвийг тухайн сургуулийн хэрэгцээ шаардлага, мөн өмнөх оны гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийг тооцож салбар дотроо зохицуулалт хийж хуваарилаагүйгээс өглөг үүсгэсэн байна. Тухайлбал: 2015 онд Сүмбэр сумын 1-р сургуулийн тогтмол зардалд 85,232.8 мянган төгрөгийн төсвийн санал хүргүүлсэн боловч 101,024.7 мянган төгрөгийг баталж, хуваарилсан ба тус сургууль гүйцэтгэлээр 79,602.9 мянган төгрөг зарцуулж, 21,421.8 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Гэтэл Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн тогтмол зардлын төсөв 2015 онд 23,519.6 мянган төгрөг дутуу батлагдаж, хуваарилагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд БС-ын салбарын хэмжээнд төсвийн төлөвлөлтийг үнэн бодит тоон мэдээлэл, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөн, батлуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд салбар дотроо зохицуулалт хийж, өглөг авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.1.12. ЕБС-ууд 2014-2016 оны эхний хагас жилийн байдлаарх өглөгийг үнэн зөв бүртгэж, тайлагнасан, Баянтал сумын 4 дүгээр сургууль 16,012.8 мянган төгрөгийн авлагыг бүртгэл тайланд тусгаагүй байна.

ЕБС-уудын хэмжээнд 2014 онд 9,902.1 мянга, 2015 онд 4,886.2 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 2,573.1 мянган төгрөгийн тус тус авлагатай тайлагнагдсан байна. Үүнд: Сүмбэр сумын 2 дугаар сургууль нийт авлагын 1,3 хувь буюу 34.3 мянга, Баянтал сумын 4 дүгээр сургууль 98.7 хувь буюу 2,538.8 мянган төгрөгийн тус тус авлагатай байна.

Авлагыг насжилтаар нь авч үзвэл 31-60 хоногтой авлага нийт авлагын 68.6 хувийг, 61-120 хоногтой авлага 31.4 хувийг тус тус эзлэж байна.

Баянтал сумын 4 дүгээр сургууль нь хоолны зардлаас 2014 онд 7,793.2 мянга, 2015 онд 4,500.0 мянга, нийт 12,293.2 мянган төгрөгийг ААНБ, иргэнд шилжүүлсэн

боловч бараа материалыг одоо хүртэл хүлээн аваагүй, мөн ажлаас чөлөөлөгдсөн няравтай тооцоо бодож, актаар баталгаажуулаагүй 3,719.6 мянга нийт 16,012.8 мянган төгрөгийн авлагыг бүртгэж, тайлагнаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэснийг тус тус зөрчсөн байна.

Мөн Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 2016 оны эхний хагас жилд тэтгэвэрт гарсан 2 багшийн 7,450.0 мянган төгрөгийн тэтгэмжийн өглөгийг дутуу, 100.0 мянган төгрөгийн авлагыг илүү тусгасан байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар ЕБС-иуд 398,809.1 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

ЕБС-уудын 2016 оны эхний хагас жилийн байдлаарх өглөг, өглөгийн насжилтийн судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Нийт өглөг	31-60 хоног	61-120 хоног	121-дээш	Нийт өглөгт эзлэх хувь
1	1-р сургууль	30,717.9			30,717.9	7.7
2	2-р сургууль	62,000.0	62,000.0			15.5
3	3-р сургууль	106,841.9	72,355.1		34,486.8	26.8
4	4-р сургууль	57,684.1	12,532.6	44,934.6	216.9	14.5
5	5-р сургууль	141,565.2		1,564.5	140,000.7	35.5
Нийт өглөг		398,809.1	146,887.7	46,499.1	205,422.3	
Нийт өглөгт эзлэх хувь			36.8	11.6	51.6	100.0

Судалгаанаас үзэхэд нийт өглөгийн 35.5 хувийг 5 дугаар сургууль, 26.8 хувийг 3 дугаар сургууль, 15.5 хувийг 2 дугаар сургууль, 14.5 хувийг 4 дүгээр сургууль, 7.7 хувийг 1 дүгээр сургуулийн өглөгүүд тус тус эзэлж байна.

Нийт өглөгийн 51.6 хувь нь 121 хоногоос дээш, 11.6 хувь нь 61-120 хоногийн, 36.8 хувь нь 31-60 хоногийн хугацаатай байна. 121-ээс дээш хоногийн хугацаатай өглөг нь өмнөх оны цалин, шимтгэл, тогтмол зардлын өглөг байна.

Сүмбэр сумын 5-р сургууль нь 2015 онд 1,524.2 мянган төгрөгийн хоолны өглөгийг, 2016 оны эхний хагас жилд 300.0 мянган төгрөг халаалтын өглөгийг тус тус илүү тусгасан байна.


Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн өр /НДШ, түлш халаалт, үдийн цай/, 2 дугаар сургуулийн өр /НДШ, түлш халаалт/, 5 дугаар сургуулийн өр /цалин, НДШ, түлш халаалт, цэвэр бохир ус, хоол/, Шивээговь сумын 3 дугаар сургуулийн өр /цалин, НДШ, түлш халаалт, цэвэр бохир ус/, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн өр /НДШ, түлш халаалт/ гэх мэт зардлуудтай холбоотой байна.

3.2.1. 2015-2016 оны хичээлийн жилд аймгийн СӨБ-ын байгууллагуудын батлагдсан орон тооноос 6 багш илүү ажиллуулж, 44,885.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар улсын цэцэрлэгүүдэд нийт 120 багш, ажиллагсад ажиллаж байгаагаас удирдах ажилтан 5, гүйцэтгэх ажилтан 68, үйлчлэх ажилтан 47 байна.

2016 онд СӨБ-ын байгууллагуудын батлагдсан орон тооноос 6 багш илүү ажиллаж байна. Үүнд: Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгт 2, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгт 4 багш ажиллаж байгаа бол Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгт 1 орон тоо дутуу байна.

Цэцэрлэгүүдийн 2014-2016 оны батлагдсан орон тоо, гүйцэтгэлийн судалгааг графикаар харуулбал:



Графикаас харахад аймгийн хэмжээний улсын цэцэрлэгүүдийн ажиллагсдын хувьд удирдах ажилтан 4.2 хувь, гүйцэтгэх ажилтан 56.3 хувь, үйлчлэх ажилтан 39.5 хувийг эзэлж байна.

СӨББ-уудын 2014-2016 оны орон тооны судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	2014		2015		2016	
		Батлагдсан орон тоо	Орон тоо гүйцэтгэлээр	Батлагдсан орон тоо	Орон тоо гүйцэтгэлээр	Батлагдсан орон тоо	Орон тоо гүйцэтгэлээр
1	1 дүгээр цэцэрлэг	20	20	31	31	31	31
2	2 дугаар цэцэрлэг	23	22	23	22	23	22
3	3 дугаар цэцэрлэг	32	32	30	30	30	30
4	4 дүгээр цэцэрлэг	10	10	10	12	10	12
5	5 дугаар цэцэрлэг	20	20	20	24	24	24
Дүн		105	104	114	119	118	119

Дээрх хүснэгтээс харахад Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэг 1 орон тоо дутуу ажиллаж ирсэн ба энэ нь цалингийн сан хүрэлцэхгүйгээс шалтгаалсан байна. Харин Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг 2015 оны 11 сараас 2 орон тоо илүү ажиллуулсан нь 2015 оны төсөв батлагдсаны дараа шинэ барилгад нүүж орсноос хүүхдийн тоо буюу хүүхэд хүлээн авах хүчин чадал нэмэгдэж 1 бүлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Мөн 5 дугаар цэцэрлэгт иргэдийн хүсэлтээр 2015 оны 09 дүгээр сараас гэр цэцэрлэгийн 2 бүлэг нэмж ажиллуулснаас шалтгаалан 4 орон тоо нэмэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд цэцэрлэгүүдийн төсөв жил бүр СӨББ гэсэн ганц багцаар батлагдаж ирдэг ба уг төсвийг аймгийн БСГ-аас цэцэрлэгүүдэд хуваарилахдаа нэмэгдсэн орон тооны цалингийн зохицуулалтыг хийж хуваарилсан байна.

3.2.2 Зарим цэцэрлэгүүд 2014-2015 оны үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосноос нийт 14,720.7 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Цэцэрлэгүүдийн 2014-2016 оны цалингийн сан нийт төсвийн 55.0-60.0 хувийг эзэлж байгаа бөгөөд цалингийн сангийн төсөв 2014 онд 816,788.2 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 820,656.5 мянга, 2015 онд 873,036.8 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 875,578.7 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 526,291.0 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 526,291.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Цэцэрлэгүүдийн 2014-2015 оны цалингийн зардлын төсөв, гүйцэтгэлийн харьцуулалтын шинжилгээг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	2014			2015			2016			/мян.төг/ Харцуулалт	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв 2015/2014	Гүйцэтгэл 2015/2014
1	1 дүгээр цэцэрлэг	159,429.0	159,421.9	7,1	194,802.5	182,356.3	2 446,2	137 814,7	137 814,7	-	22%	14%
2	2 дугаар цэцэрлэг	164,525.1	164,525.1	-	186,578.8	182,590.3	3 988,5	108 329,8	108 329,8	-	13%	11%
3	3 дугаар цэцэрлэг	239,472.8	239,217.5	255,3	245,094.4	238,776.6	6 317,8	131 748,5	131 748,5	-	2%	0%
4	4 дүгээр цэцэрлэг	86,773.9	86,205.6	568,3	76,172.6	76,165.3	7,3	51 104,0	51 104,0	-	-12%	-12%
5	5 дугаар цэцэрлэг	166 587,4	171 286,4	-4 699,0	170 388,5	173 690,2	- 3 301,7	97 294,0	97 294,0	-	2%	1%
6	Канад цэцэрлэг				61,518.4					-		
Дүн		816 788,2	820 656,5	-3 868,3	873 036,8	853 578,7	19 458,1	526 291,0	526 291,0	-		

Хүснэгтээс харахад: 2015 оны СӨББ-уудын цалингийн сангийн батлагдсан төсөв өмнөх оныхоос нийт дүнгээрээ 6.9 хувиар өссөн ба Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн төсөв 12.0 хувиар буурч, бусад цэцэрлэгийн төсөв 2.0-22.0 хувиар нэмэгдэж батлагдсан байна.

Тухайлбал: Сүмбэр сумын 1, 2 дугаар цэцэрлэгүүдийн цалингийн сангийн батлагдсан төсөв 13.0-22.0 хувь, гүйцэтгэл нь 11.0-14.0 хувиар, Шивээговь сумын 3 дугаар, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгүүдийн цалингийн сангийн төсөв 1.0-2.0 хувиар өмнөх өнөөс тус тус өссөн бол Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн цалингийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл 12.0 хувиар буурсан байна.

Сүмбэр сумын 1, 2 дугаар цэцэрлэгүүдийн төсөв 22,053.7-35,373.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан нь багш ажиллагсдын ажилласан жил болон орон тоо нэмэгдсэнээс шалтгаалсан бол Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн орон тоо

2-оор нэмэгдсэн боловч цалингийн зардал нь 10,601.3 мянган төгрөгөөр тус тус буурч батлагдсан байна.

Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн 2015 оны төсөв өмнөх оноос 2 хувь, гүйцэтгэл нь 1 хувиар тус тус өссөн боловч 2014 оны цалингийн зардал 2,8 хувь буюу 4,699.0 мянган төгрөгөөр, 2015 оны цалингийн зардал 1,9 хувь буюу 3,301.7 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

2014 онд Сүмбэр сумын 1, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгүүд ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг үнэн зөв, батлагдсан төсвийн хүрээнд тооцож олголгүйгээр нийт багш, ажиллагсдад хавтгайруулан олгож НДШ, татварын өрийг үүсгэсэн байна. Жилийн эцэст дээрх 2 цэцэрлэгийн өрийг барагдуулах зорилгоор 14,720.7 мянган төгрөгийн санхүүжилт нэмж олгосон нь төсөв хэтрүүлэн зарцуулах гол шалтгаан болсон байна.

Аудитын явцад СӨБ байгууллагуудын 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт багш, ажиллагсдад олгосон цалинг холбогдох баримт материалтай тулган баталгаажуулахад дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг:

- Эд хариуцагч няравт 484.1 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон,
- 2014 онд 4,115.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон,
- Ажиллагсдын цалингийн хүснэгт дэх илүү цагийн дүн цагийн балансын дүнгээс зөрүүтэй тусгагдсан

Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэг:

- Илүү цаг ажиллуулсны цалинг буруу тооцож 1,329.7 мянган төгрөгийг илүү олгосон,
- Зэрэг дэвийн нэмэгдлийн ерөнхий болон тусгай шаардлагыг бүрэн хангасан эсэхийг тодорхойлоогүй, ажил дүгнэсэн шалгуур үзүүлэлт, нотлох баримтгүйгээр зөвхөн эрхлэгчийн тушаал гаргаж, 3 ажилтанд зэргийн нэмэгдэлд 888.3 мянган төгрөгийг олгосон,
- Эд хариуцагч, няравт балансын урамшуулал 469.1 мянган төгрөг олгосон,
- Тухайн жилийн төсөвт батлагдаагүй байхад дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулан унааны мөнгийг 923.6 мянган төгрөгөөр нэмж олгосон,
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьсан гэж холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний 445.8 мянга төгрөгөөр шагнасан,

Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг:

- Зарим ажиллагсдын илүү цаг ажиллуулсны цалинг буруу тооцож 154.8 мянган төгрөгөөр илүү, 709.1 мянган төгрөг дутуу олгосон,
- Мөн цалингийн хүснэгтэд оруулсан боловч суутгалын дүнд нэмэгдээгүй, ажиллагсдаас актын төлбөрийг суутган авч шилжүүлэлгүйгээр байгууллагын данснаас 1,139.3 мянган төгрөгийг шилжүүлж байгууллагыг хохироосон,

Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг:

- Зарим ажиллагсдын илүү цаг ажиллуулсны цалинг буруу тооцож 56.2 мянган төгрөгөөр илүү, 435.7 мянган төгрөг дутуу олгосон,
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр эрхлэгчид ур чадварын нэмэгдэл 409.6 мянган төгрөг олгосон,

- 2014 онд 10,214.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон

Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг:

- Ажилчдын илүү цагийн нэмэгдлийг буруу тооцоолсоноос 2014 онд 229.0 мянга илүү, 17.3 мянга дутуу, 2015 онд 1,021.1 мянга илүү, 25.2 мянга дутуу, 2016 онд 1,345.6 мянга илүү, 6.3 мянга дутуу нийт 2,595.7 мянган төгрөгийг илүү, 48.8 мянган төгрөгийг дутуу бодож олгосон,
- Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар тогтоосон цалинг зөрүүтэй тооцож 2014 онд 269.7 мянга, 2015 онд 307.5 мянга илүү, 99.1 мянга дутуу нийт 577.2 мянган төгрөгийг илүү, 99.1 мянган төгрөгийг дутуу олгосон,
- Зарим ажилтны ур чадварын нэмэгдлийг эрхлэгчийн тушаал, шийдвэргүй олгосон, тооцооллын алдаа гаргаснаас 2014-2015 онд 1,090.7 мянган төгрөгийг илүү, 110.3 мянган төгрөгийг дутуу олгосон,
- Багш нарын заах аргын нэмэгдлийг 2014 онд 123.3 мянга, 2015 онд 66.2 мянга нийт 189.6 мянган төгрөгөөр тус тус дутуу бодож олгосон,
- 2014 оны 02-р сард ажилчдын цалингаас НДШ-ийг 382.9 мянган төгрөгөөр дутуу, ХХОАТ-ын нэмэгдлийг 154.0 мянган төгрөгөөр илүү, 3.7 мянган төгрөгөөр дутуу суутгасан,
- Ажиллагсдын үр дүнгийн урамшууллыг 2014 онд 586.3 мянган төгрөгөөр илүү, 2015 онд 114.0 мянган төгрөгөөр дутуу, 2016 онд 34.3 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон,
- Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар ажилтны цалингаас суутгавал зохих арга хэмжээний суутгалыг 2016 онд 148.4 мянган төгрөгөөр илүү суутгасан
- 2015 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 2 багшид 5,728.8 мянган төгрөг олгох байтал 6,667.8 мянган төгрөгөөр тооцож, 1 багшид 90.0 мянган төгрөгийн тэтгэмжийг илүү олгож, илүү батлагдсан 849.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, 2 ажилтанд буцалтгүй тусламж олгосон,
- 2016 онд нярав Ж.Оюунцэцэгт нь хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 2,814.6 мянган төгрөг олгосон, мөн тус цэцэрлэгт 2009 оноос хойш нярваар ажилласан байтал 2016 оны төсвийн төсөлд туслах багшаар ажилласнаар тооцож, тэтгэмжийг батлуулан авч зориулалт бусаар зарцуулсан,
- 2016 онд хөдөө орон нутагт тогтвортой ажилласны тэтгэмжийн зардлаас 4 ажилтанд 968.0 мянган төгрөгийг зориулалтын бусаар зарцуулж буцалтгүй тусламж олгосон,
- 2014-2015 онд байгууллагын цалингийн зардлаас зориулалт бусаар доорх тэтгэмж, шагнал урамшууллыг олгосон байна. Үүнд:
 - ✓ Эрхлэгчийн 2014 оны Б/34 тоот тушаалаар 9 ажилтанд тус бүр 250.0 мянга, нийт 2,250.0 мянган төгрөгийг өрхийн орлого буурч, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой гэр бүлийг дэмжих нэрээр олгосон,
 - ✓ Эрхлэгчийн 2014 оны Б/33 тоот тушаалаар 2 ажилтны шинэ байрны ёслолд 240.0 мянга,
 - ✓ Б/36 тоот тушаалаар байгууллагын хөдөлмөрийн аваргаар шалгарсан ажилтны шагналд 185.0 мянга,
 - ✓ Б/35 тоот тушаалаар байгууллагын санхүүгийн тайлан гараагүй байхад байгууллагын нягтлан бодогчид 586.3 мянга, няравт 469.1 мянга, нийт 1,055.4 мянга,

- ✓ Эрхлэгчийн 2015 оны Б/17 тушаалаар байгууллагын нягтлан бодогчид 1,172.6 мянга, няравт 469.1 мянга нийт 1,641.7 мянга,
- ✓ 2015 оны 12-р сард 3 ажилтанд МЗХ-ын шагналаар шагнагдсан гэж 1,449.5 мянга, 2 ажилтанд байгууллагын аварга ажилтан гэж 200,0 мянган нийт 2,490.0 мянган төгрөгийн тэтгэмж, 4,531.6 мянган төгрөгийн шагналыг тус тус холбогдох зардлын төсөв нь батлагдаагүй байхад зориулалт бусаар бусад зардлаас шилжүүлэн олгосон байна.

Ажиллагсдад буцалтгүй тусламж олгохдоо байгууллагын дотоод журмыг үндэслэж байгаа боловч тухайн зардлын төсөв батлагдаж ирээгүй байхад гэр бүлийн гишүүн нь нас барсан ажилтанд цалингийн зардлаас нэг удаагийн буцалтгүй тусламж олгож, нийт 2,738.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нийтлэг зөрчил дутагдал гарсан байна. Тухайлбал: 2014 онд Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг 3 ажилтанд 672.0 мянга, 2015 онд Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг 5 ажилтанд 2,066.5 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Дээрх зөрчил, дутагдлууд нь дараах хууль эрхийн актуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”,
- Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”
- Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д “дараах этгээдэд 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох”, 43.1.7.а-д “сум тосгон багийн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, сургууль цэцэрлэгийн эмч”, 43.1.7.б-д “сум, тосгон багийн сургууль, цэцэрлэгийн энэ хуулийн 43.1.7.а-д зааснаас бусад багш, туслах багш байна”,
- Сангийн сайдын 2013.03.29-ний өдрийн 73-р тушаалын 1-р хавсралтын 5 дугаар зүйлийн 5.1-д “Төсвийн байгууллага энэ журмын 3.1.4-т заасан үндэслэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шитгэлийн зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс бусад зардлын бүлэг хооронд жилийн батлагдсан төсвийн тухайн зардлын бүлгийн дүнг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэх зохицуулалтын хүсэлт гаргаж болно”, 2-р хавсралтын 8 дугаар зүйлийн 8.1-д “Төсвийн байгууллага нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаас өөр бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”,
- Засгийн газрын 2004.05.05-ны өдрийн 112 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 8-д “энэхүү журамд заасан тусламжид шаардагдах хөрөнгийг урьдчилан тухайн жилийн төсөвт тусгана” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд илүү тооцож олгосон цалин, илүү цагийн хөлс, шийдвэргүй олгосон ур чадварын нэмэгдэл, үндэслэлгүй олгосон шагнал, унааны хөнгөлөлт, цалингийн зардлаас зориулалт бусаар олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж, шагнал урамшуулал зэрэг нийт 17,042.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх, дутуу тооцож олгосон 1,475.0 мянган төгрөгийг цалинг холбогдох ажилтнуудад нөхөн олгуулахаар тус тус төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Мөн Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгт 2015 оны актын төлбөрийн 1,139.3 мянган төгрөгийг авлага үүсгэн, ажиллагсдаас суутган авч байгууллагыг хохиролгүй болгох тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Цаашид үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж урамшууллыг үнэн зөв тооцож, холбогдох зардлын данснаас гарган, бүртгэж тайлагнах, ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах, нярав, эд хариуцагч нарт балансын урамшуулал олгохгүй, харин ажлынх нь үр дүнгээр ур чадварын нэмэгдэл олгодог байх, байгууллагын дотоод журамд нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн зардлын төсөв батлагдсан, хүрэлцээтэй тохиолдолд олгож байх тухай заалтыг тусгаж өгөх, анхан шатны баримтын бүрдэл дутуу, холбогдох албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр ажил гүйлгээ хийхгүй байх тухай зөвлөмжүүдийг өгөхөөр шийдвэрлэв.

3.2.3. БСГ-аас цэцэрлэгүүдийг нэгдсэн удирдамжаар хангаж ажиллаагүйгээс багш, ажиллагсдад олгож буй илүү цагийн хөлсийг цэцэрлэг бүр өөр өөрийн үзэмжээр олгож байна.

СӨБ байгууллагуудын багш нарт олгох өглөө, орой болон цайны цагаар ажилласны илүү цагийн цалинг аймгийн БСГ-аас салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, арга зүйгээр хангаж ажиллаагүйгээс илүү цагийн цалин олгох асуудал аймгийн хэмжээнд нэгдсэн нэг ойлголтгүй байгаа тул цэцэрлэгүүд өөр өөрөөр тооцож олгосон байна. Тухайлбал, Сүмбэр сумын 1, 2, 5 дугаар цэцэрлэгүүд үндсэн багшид 1, туслах багшид 1 цагийн илүү цагийн цалин олгож байгаа бол Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг, Шивээговь сумын 5 дугаар цэцэрлэгүүд зөвхөн үндсэн багшид 2 цагийн илүү цагийн цалин олгож байна.

Мөн аймгийн хэмжээнд цэцэрлэгийн багш нарт зэрэг дэвийн нэмэгдэл болон “заах аргач” мэргэжлийн зэргийг олгохдоо баримтлах нэгдсэн бодлого, арга зүй бахгүйгээс зарим цэцэрлэг БШУС-ын 2014 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах, арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох, хасахад баримтлах шалгуур үзүүлэлт”-ийн хүрээнд шууд эрхлэгчийн тушаалаар олгож байгаа бол зарим цэцэрлэгүүд аймгийн БСГ-т санал хүргүүлж шийдвэрийг үндэслэн эрхлэгчийн тушаалаар тус тус олгосон байна.

Тухайлбал, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг аймгийн БСГ-ын шийдвэрийг үндэслэн багш нарт мэргэжлийн зэргийг олгосон бол Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн 3 багшид эрхлэгчийн тушаалаар “Заах аргач” мэргэжлийн зэрэг олгосон бөгөөд уг багш нарын ажлын үзүүлэлтийг дээрх шалгуур үзүүлэлтийн хүрээнд нийтлэг болон тусгай шалгуурыг бүрэн хангасан эсэхийг үнэлж дүгнэсэн тухай баримт материал, хурлын тэмдэглэл байхгүй байна.

Дээрх зөрчлүүд нь аймгийн БСГ-аас СӨББ-ыг нэгдсэн нэг бодлого, удирдлага арга зүйгээр хангаж, ажиллаагүйгээс байгууллага бүр өөр өөрийн үзэмжээр шийдвэрлэж буйтай холбоотой байна.

Иймд дээрх тодорхойгүй болон зөрүүтэй олгогдож байгаа илүү цагийн хөлс болон багшлах эрх, мэргэжлийн зэрэг, заах арга зүйчийн мэргэжлийн зэрэг олгох, тэтгэмж, тусламж олгох зэрэг бодлогын шинж чанартай асуудлуудыг холбогдох хууль эрх зүйн

акт, журам, зааврын дагуу дотоод журам, НББББ зэрэг салбарын хэмжээний бодлогын баримт бичигт тусган нэгдсэн нэг бодлого, арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн БСГ-т өгөхөөр шийдвэрлэв.

3.2.4. СӨББ-ууд 2014-2015, 2016 оны эхний хагас жилийн байдлаарх хувьсах зардлын батлагдсан төсвийг хэмнэж ажилласан байна.

Улсын цэцэрлэгүүдийн хувьсах зардалд 2014 онд 295,982.0 мянга, 2015 онд 330,415.6 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 150,055.5 мянган төгрөг тус тус батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 2014 онд 292,226.8 мянга, 2015 онд 320,011.7 мянган төгрөг, 2016 оны эхний хагас жилд 135,704.3 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

2014-2016 оны эхний хагас жилийн СӨББ-уудын хувьсах зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Хувьсах зардал 2014			Хувьсах зардал 2015			Хувьсах зардал 2016 оны эхний хагас жилийн байдлаар		
		Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	1 дүгээр цэцэрлэг	42 546,8	42 168,3	0,99	66 306,1	65 820,5	0,99	34 596,2	28 941,4	0,84
2	2 дугаар цэцэрлэг	68 567,3	68 492,0	1,00	70 304,4	70 268,0	1,00	36 693,8	35 981,1	0,98
3	3 дугаар цэцэрлэг	82 422,2	82 367,5	1,00	87 340,1	87 340,1	1,00	34 890,3	30 320,9	0,87
4	4 дүгээр цэцэрлэг	27 768,7	28 399,5	1,02	33 452,7	33 451,4	1,00	11 534,5	8 120,2	0,70
5	5 дугаар цэцэрлэг	74 677,0	70 799,5	0,95	63 160,4	63 131,7	1,00	32 340,7	32 340,7	1,00
6	Канад цэцэрлэг	-	-	-	9,851.9					
Дүн		295 982,0	292 226,8	0,99	330 415,6	320 011,7	1,00	150 055,5	135 704,3	0,90

Хүснэгтээс харахад 2015 оны хувьсах зардлын төлөвлөгөө өмнөх оноос 11.6 хувь, гүйцэтгэл 9.5 хувиар тус тус өссөн байна. 2014 оны хувьсах зардлын гүйцэтгэл 1.0 хувиар хэтэрсэн бол 2016 оны эхний хагас жилд 10.0 хувиар хэмнэсэн үзүүлэлттэй байна.

2014-2016 онд СӨББ-ууд хоолны зардалд 2014 онд 255,511.2 мянга, 2015 онд 278,507.5 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 114,961.1 мянга, нийт 648,979.8 мянган төгрөгийг зарцуулсан боловч хоолны материалын бэлтгэн нийлүүлэгчийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.

Аудитын явцад цэцэрлэгүүдийн хүнсний материалд тооллого хийхэд зарим цэцэрлэгүүдийн хүнсний материал их хэмжээгээр илүүдсэн бол зарим цэцэрлэгийн хүнсний материал дутагдсан зөрчил илэрлээ.

Тооллогоор илэрсэн зөрчлийн дүнг цэцэрлэг тус бүрээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Тооллогоор	
		Илүүдсэн	Дутагдсан
1	1 дүгээр цэцэрлэг	153,192.50	
2	2 дугаар цэцэрлэг		41,310.00
3	3 дугаар цэцэрлэг		0

4	4 дүгээр цэцэрлэг	3,765,917.05
5	5 дугаар цэцэрлэг	795,545.00
153,192.50		4,602,772.05

Хүснэгтээс харахад тооллогоор нийт 4,602.8 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан бөгөөд Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн дутагдуулсан дүн нийт дутагдсан хөрөнгийн 81.8 хувийг эзэлж байна. Уг зөрчил нь хүнсний материалын үнийг шилжүүлсэн боловч бараа материалын татан авалтыг бүрэн хийгээгүй, данс бүртгэлд хий орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Энэ нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд тооллогоор дутагдсан хүнсний материалын 4,602.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичиж, илүүдсэн 153.2 мянган төгрөгийн хүнсний материалыг орлогоор бүртгэж тайлагнах тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Мөн Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2015 оны жилийн эцсийн тооллогын комиссын гишүүд нь бараа материалыг нүдээр үзэж тоолоогүй, ор нэр төдий хийж гүйцэтгэсэн хуурамч баримт бүрдүүлсэн тул хариуцлага тооцуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

Цаашид хүнсний материалыг 1 сарын нөөцтэй байлгах, мөн холбогдох эд хариуцагчийг ажлаас чөлөөлөгдөхөд ажил хүлээлцэх комисс томилон ажлыг нь хүлээлцүүлж байх, хариуцсан эд хөрөнгийн тооллого хийн, тооцоог нь бодож, зөрүү гарсан тохиолдолд төлбөр тооцоог нь барагдуулж байж ажлаас чөлөөлж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

3.2.5. СӨББ-ууд 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар тогтмол зардлын батлагдсан төсвийг хэмнэж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд СӨББ-ын тогтмол зардлын төсөв 2014 онд 93,433.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 93,358.3 мянга, 2015 онд 179,748.1 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 152,695.9, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 107,437.1 мянган төгрөг батлагдсанаас 97,893.4 мянган төгрөг тус тус зарцуулж, батлагдсан төсвийг хэмнэсэн бөгөөд 2015 оны тогтмол зардлын батлагдсан төсөв өмнөх оноос 92.4 хувь, гүйцэтгэл 63.6 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн Цэцэрлэгүүдийн 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн тогтмол зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Тогтмол зардал 2014			Тогтмол зардал 2015			Тогтмол зардал 2016 оны эхний хагас жилийн байдлаар		
		Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь

/мян.төг/


1	1 дүгээр цэцэрлэг	18 504,8	18 504,8	1,0	46 631,7	30 193,8	0,6	35 345,2	27 383,7	0,8
2	2 дугаар цэцэрлэг	21 656,0	21 654,1	1,0	33 505,2	30 251,7	0,9	15 286,1	15 180,1	1,0
3	3 дугаар цэцэрлэг	16 955,1	16 936,1	1,0	29 736,5	22 465,8	0,8	13 025,7	12 063,7	0,9
4	4 дүгээр цэцэрлэг	11 448,5	11 394,7	1,0	21 306,9	21 306,9	1,0	19 705,1	19 284,4	1,0
5	5 дугаар цэцэрлэг	24 868,6	24 868,6	1,0	48 567,8	48 477,7	1,0	24 075,0	23 981,4	1,0
Дүн		93 433,0	93 358,3	1,0	179 748,1	152 695,9	0,81	107 437,1	97 893,4	0,9

Хүснэгтээс харахад: 2014 онд цэцэрлэгүүд 0.1-0.5 хувь буюу 1.9-53.8 мянга, 2015 онд 0.2-35.3 хувь буюу 30.1-16,4379 мянга, 2016 онд 0.4-22.5 хувь буюу 93.3-7,961.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн үзүүлэлттэй байна.

Мөн Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг 2014 онд батлагдсан төсвийн зөвхөн 64.7 хувийг, 2015 онд 77.5 хувийг зарцуулсан байна. Энэ нь аймгийн БСГ-аас цэцэрлэгүүдийн төсвийг бодит тоон мэдээлэл, өмнөх оны гүйцэтгэл, тооцоо судалгаа, хэрэгцээнд тулгуурлан үнэн зөв бодитой төлөвлөж, батлуулаагүй, мөн зөв хуваарилаж, санхүүжилтийг олгоогүйтэй холбоотой байна.

Аймгийн Цэцэрлэгүүдийн 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн тогтмол зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгааг графикаар харуулбал:

ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙН ТОГТМОЛ ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ /2014-2015 ОН, 2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ/



Графикаас харахад 2015 онд тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл нийт дүнгээрээ өмнөх оноос 63.6-92.4 хувиар тус тус өссөн байна. Энэ нь 1 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтад орохоор төлөвлөсөн, мөн гэрэл цахилгаан, цэвэр, бохир усны зардал илүү батлагдаж ирсэнтэй холбоотой байна. Харин Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилга хугацаандаа ашиглалтад ороогүй боловч гүйцэтгэл 64.7 хувиар өссөн байна.

3.2.6. СӨББ-уудын халаалтын зардлыг 2015 онд 12,363.7 мянга, 2016 оны эхний хагас жилд 6,322.6 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

СӨББ-уудын халаалтын зардлыг 2014 онд 2.7 хувь буюу 1,690.3 мянга, 2015 онд 12.8 хувь буюу 12,363.7 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 9.5 хувь буюу 6,418.6 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

СӨББ-ын 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаарх халаалтын зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№ Байгууллагын нэр	2014			2015			2016		
	Талбай	Төсөв	Гүйцэтгэл	Талбай	Төсөв	Гүйцэтгэл	Талбай	Төсөв	Гүйцэтгэл
1 1 дүгээр цэцэрлэг	1 047	10 127	10 432,8	3 084	47 658,6	32 202,7	3 084	26 712,0	19 919,4
2 2 дугаар цэцэрлэг	2 332	15 715	17 361,3	2 332	18 315,3	21 973,4	2 332	8 602,4	11 933,7
3 3 дугаар цэцэрлэг	1 330	11 090,9	10 590,4	1 330	10 606,9	16 005,9	1 330	5 966,6	8 332,4
4 4 дүгээр цэцэрлэг	1 256	7 737,9	7 737,9	1 898	9 216,9	17 724,4	1 898	11 122,0	16 120,7
5 5 дугаар цэцэрлэг	2 104	18 287,5	18 526,7	2 104	26 950,0	30 435,1	2 104	15 159,6	17 675,0
Дүн	8 069	62 958,5	64 649,1	10 748	96 016,2	108 379,9	10 748	67 562,6	73 981,2

Хүснэгтээс харахад цэцэрлэгүүдийн халаалтын зардал:

- ✓ 2014 онд 62,958.5 мянган төгрөг батлагдаж, 64,649.1 мянган төгрөг зарцуулсан ба батлагдсан төсөв 2.7 хувь буюу 1,690.3 мянга,
- ✓ 2015 онд 96,016.2 мянган төгрөг батлагдсанаас 108,379.9 мянган төгрөг зарцуулж батлагдсан төсөв 12.8 хувь буюу 12,363.7 мянга,
- ✓ 2016 онд 67,562.6 мянган төгрөг батлагдаж, 73,981.2 мянган төгрөг зарцуулж 6,418.6 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

2015 онд халаалтын зардал хэтэрсэн нь тухайн тайлант оны төсөв батлагдсаны дараа орон нутгийн дулааны компаниудын халаалтын үнэ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Халаалтын зардлыг хэтрүүлэн зарцуулсан цэцэрлэгүүдийн дурьдвал:

2015 онд Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг халаалтын зардлыг 15,554.3 мянган төгрөгөөр хэмнэсэн бол Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэг 4,933.7 мянга, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг 5,399.0 мянга, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг 8,507.5 мянга, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 9,077.8 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Харин Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг нь 2015 оны 9-12 сар хүртэл бохир соруулсны хөлсөнд 3,322.3 мянган төгрөгийг халаалтын зардлаас олгосон боловч нэхэмжлэхээс өөр анхан шатны баримтгүй, хэдэн удаа соруулсан нь тодорхойгүй, 2015 оны 12 дугаар сард халаалтын зардалд 2,104.2 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлж, зарцуулсан байна.

3.2.7. СӨББ-ууд 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар гэрэл, цахилгаан, цэвэр бохир усны зардлыг тус тус хэмнэж ажилласан байна.

2014 онд СӨББ-ууд гэрэл, цахилгааны зардлыг 14.5 хувь буюу 1,986.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байтал 2015 онд уг зардлыг өмнөх оныхоос 294,2 хувь буюу 40,285.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, гүйцэтгэлээр батлагдсан төсвийг 59.5 хувь буюу 32,107.7 мянга, 2016 оны эхний хагас жилд 46.6 хувь буюу 12,892.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Цэцэрлэгүүдийн гэрэл, цахилгааны зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв тооцож, батлуулаагүйгээс их хэмжээгээр хэмнэгдсэн ба 2015 онд уг хэмнэлтээс

халаалтын зардалд 17,393.9 мянган төгрөгийг, үлдэгдэл 10,297.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь төсвийг үнэн зөв, бодитой батлуулаагүй, мөн зардлыг бодит тоон мэдээнд үндэслэн хуваарилаагүйтэй холбоотой байна.

2014 онд СӨББ-уудын цэвэр, бохир усны зардлыг 1.3 хувь буюу 221.6 мянган төгрөгөөр хэтэрсэн бөгөөд 2015 онд уг зардлыг өмнөх оныхоос 77.3 хувь буюу 12,972.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, гүйцэтгэлээр батлагдсан төсвийг 24.6 хувь буюу 7,308.2 мянга, 2016 оны эхний хагас жилд 3,070.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

2015 онд цэвэр, бохир усны зардлын төлөвлөгөө өмнөх оноос 77.3 хувь, гүйцэтгэл 32.0 хувиар тус тус өссөн боловч 2015 онд гүйцэтгэл 75.4 хувьтай байгаа бөгөөд төсвийг илүү батлуулсан байна. 2015 оны төсвийн хэмнэлтийн 10,524.2 мянган төгрөгийг халаалтын зардалд зарцуулсан бөгөөд Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн хэтэрсэн зардлыг халаалтын зардлын хэмнэлтээс гүйлгэн зарцуулсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 42 дугаар зүйлийн 42.-т “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно”, 42.2.2-т “төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд СӨББ-уудын тогтмол зардлыг өмнөх оны гүйцэтгэл, харилцагч байгууллагын төлбөр тооцооны нэхэмжлэл, гэрээ зэрэг бодит тоон мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв, бодитой төлөвлөж, батлуулж, зарцуулж байх, БСГ-аас тус байгууллагуудын хуваарилалтыг зөв хийж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, үргүй зардал гаргахгүй байх, төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг СӨББ болон БСГ-т өгөхөөр шийдвэрлэв.

3.2.8 СӨББ-ууд авлага, өглөгийг баталгаажуулан үнэн зөв бүртгэж, тайлагнасан боловч санхүүжилтийг нь бодитой хуваарилаагүйгээс их хэмжээний өртэй гарсан байна.

Аймгийн СӨББ-ууд 2014 онд 10,685.2 мянга, 2015 онд 5,763.0 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 30,280.1 мянган төгрөгийн тус тус өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

СӨББ-уудын 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаарх өглөгийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

					/мян.төг/
№	Байгууллагын нэр	2014	2015	2016	Харьцуулалт 2015/2014
1	1 дүгээр цэцэрлэг	2 072,9	1 969,5	3 263,6	0.95
2	2 дугаар цэцэрлэг	8 483,2	694,4	2 084,5	0.08
3	3 дугаар цэцэрлэг	-	550,0	8 023,1	
4	4 дүгээр цэцэрлэг	129,1	1 999,1	4 930,1	15.48
5	5 дугаар цэцэрлэг	-	550,0	11 978,8	
Нийт санхүүжилтийн дүн		10 685,2	5 763,0	30 280,1	0.54

Дээрх хүснэгтээс үзэхэд 2015 оны өглөгийн үлдэгдэл өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Он тус бүрээр нь авч үзвэл:

- 2014 онд Сүмбэр сумын 1-р цэцэрлэг 385.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн боловч 2,072.9 мянга, НДШ-ийн өглөг, Сүмбэр сумын 2-р цэцэрлэг 78.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 8,483.2 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг тус тус үүсгэсэн байна. Энэ нь 1-д: дээрх 2 сургууль цалин, тэтгэмж, урамшууллын батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж, НДШ-ээс шилжүүлэн зарцуулсан, 2-т: аймгийн СТХС, БСГ-аас санхүүжилт дутуу хуваарилсан зэргээс шалтгаалсан байна.
- 2015 онд Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг 28,446.3 мянган төгрөг төвлөрүүлсэн боловч 1,969.5 мянга, Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэг 7,330.0 мянган төгрөг төвлөрүүлж 694.4 мянга, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг 14,273.6 мянган төгрөг төвлөрүүлж, 550.0 мянга, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг 8.6 мянган төгрөг төвлөрүүлж 1,999.1 мянга, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 304.9 мянган төгрөг төвлөрүүлж 550.0 мянган төгрөгийн өглөг нийт 5,703.0 мянган төгрөгийн өртэй гарсан байна. Сүмбэр сумын 5-р цэцэрлэгийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийн хоолны зардлаас цалинд зарцуулсан 2,085.6 мянган төгрөгийг авлагаар, аудитын үйлчилгээний төлбөрийн 550.0 мянган төгрөгийг өглөгөөр тус тус тусгуулсан байна.
- Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 2015 оны санхүүгийн тайланд тусгуулсан 550.0 мянган төгрөгийн өглөгийг эхний үлдэгдлээр тусгаагүй, мөн халаалтын өглөгийн 350.4 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- 2016 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн БСГ-аас цалин, тэтгэмж, хоолны төсвийн санхүүжилтийн хуваарийг өөрчилснөөр нийт 34,843.2 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгож, 30,280.1 мянган төгрөгийн хоолны зардлын өртэй гарсан байна.

Дээрх өглөг үүссэн шалтгаан нь байгууллагуудын төсвийг бодитой, үнэн зөв батлуулж, хуваарилаагүй, мөн бүлэг дотор шилжүүлэн зарцуулах боломжгүй зардлуудыг илүү, дутуу хуваарилсантай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулдаг байх”, 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг тус тус мөрдлөг болгоогүй байна.

Иймд аймгийн БСГ-т СӨББ-уудын өмнөх оны төсвийн гүйцэтгэл, нэхэмжлэл, гэрээ зэргийг үндэслэн төсвийг бодитой үнэн зөв боловсруулан батлуулах, батлагдаж ирсэн төсвийг хэрэгцээ шаардлагад үндэслэн зөв хуваарилаж өглөг, авлага үүсгэхгүй ажиллах, санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч иргэн, аж ахуй нэгж байгууллагатай тооцоо нийлж батлгаажсан авлага, өглөгийг санхүүгийн тайланд тусгаж байх тухай зөвлөмжүүдийг тус тус өгөхөөр шийдвэрлэв.

3.3.1 2014-2016 онуудад зарим сумдын Соёлын төв батлагдсан орон тооноос илүү ажилтан ажиллуулсан, мөн батлагдсан ажлын байранд мэргэжлийн хүн авч ажиллуулаагүй байна.

Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар Соёл, урлагийн байгууллагуудад нийт 84 ажиллагсад ажиллаж байгаагаас удирдах ажилтан 5, гүйцэтгэх ажилтан 21, үйлчлэх ажилтан 58 байна.

2014-2016 онд Соёл, урлагийн байгууллагуудын батлагдсан орон тооноос нийт 2 ажилтан илүү ажиллаж байна. Үүнд: Баянтал болон Шивээговь сумдын Соёлын төв нэг, нэг орон тоо илүү ажиллуулсан байна.Тухайлбал:

Баянтал сумын Соёлын төв нь 2014-2015 онд дуу хөгжмийн багшийн батлагдсан 1 орон тоотой боловч дуучин, хөгжимчин гэсэн 2 ажилтан ажиллуулж, батлагдсан орон тоог 1-ээр хэтрүүлсэн, мөн бүжгийн багш, орон нутаг сурталчлах танхимын ажилтны батлагдсан орон тоонд хөгжимчин, нярав-үйлчлэгч авч ажиллуулсан, 2016 онд бүжгийн багшийн орон тоо дутуу ажиллаж, үйлчлэгч гэсэн батлагдаагүй орон тоонд ажилчин авч ажиллуулсан, мөн Шивээговь сумын Соёлын төв нь 2014 онд орон нутаг сурталчлах танхимын ажилтны батлагдсан орон тоонд ня-бо, бичиг хэргийн ажилтан авч ажиллуулсан байна.

СУБ-ууд батлагдсан орон тооноос илүү ажилтан авч ажиллуулснаар 2014-2016 онуудад нийт 7,922.4 мянган төгрөгийн цалингийн болон НДШ-ийн зардал илүү зарцуулж, төсвийн үргүй зардал гаргасан байна.

Мөн Шивээговь, Баянтал сумдын Соёлын төвүүд нь 2014-2016 онуудад батлагдсан мэргэжлийн ажилтны орон тоонд мэргэжлийн бус ажилтан авч ажиллуулсан байна.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгээрт багтаан төсвийн байгууллагын орон тоо, цалин хөлсийг тогтоох”, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд СУБ-ын удирдлагуудад батлагдсан орон тооноос илүү ажилтан авч ажиллуулахгүй байх, батлагдсан орон тоонд мэргэжлийн ажилтан авч ажиллуулах, төсвийн үргүй зардал гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.3.2 2014-2015 онд СУБ-ууд батлагдсан төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны болон нэмэлт орлогоо бүрэн бүртгэж, тайлагнасан байна.

СУБ-уудад 2014 онд нийт 793,923.0 мянга, 2015 онд 797,765.3 мянга, 2016 оны эхний хагас жилд 382,497.9 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт, 56,733.8 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого, мөн 137,284.5 мянган төгрөгийн нэмэлт орлогууд орсныг бүрэн бүртгэж тайлагнасан байна.

2014-2015 онд дээрх орлогуудаас 16,275.7 мянган төгрөгийн орлогыг буцаан төвлөрүүлсэн байна. Харин Боржигин чуулга 2014 онд үйл ажиллагааны орлого 19,550.0 мянга, 2015 онд 39,550.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй ажилласан ба орлогын төлөвлөгөөг 2014 онд бүрэн биелүүлж, 2015 онд 20,275.2 мянган төгрөгөөр тасалсан бөгөөд 2015 онд 20,275.2 мянган төгрөгийн өөрийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг зөрчсөн байна.

3.3.3. 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилд батлагдсан төсвөө 4,281.6-43,595.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

СУБ-уудад 2014 онд нийт 815,428.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 811,146.7 мянган төгрөгийг зарцуулж, 4,281.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, 2015 онд 879,857.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 836,262.7 мянган төгрөгийг зарцуулж, 16,275.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Байгууллагын нэр	2014 он			2015 он			2016 оны эхний хагас жил		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Боржигин чуулга	540,413.4	540,413.4	-	604,606.0	577,286.7	27,319.3	289,420.1	286,353.0	3,067.1
2	Номын сан	89,725.1	88,389.9	1,335.2	92,754.8	89,106.9	3,647.9	45,554.9	45,700.4	145.5
3	Музей	78,601.5	75,655.3	2,946.4	82,073.9	70,759.5	11,314.4	39,717.3	35,807.8	3,909.5
4	Баянтал сумын Соёлын төв	55,235.7	55,235.7	-	50,768.2	50,768.2	-	24,610.9	24,261.2	349.7
5	Шивээговь сумын Соёлын төв	51,452.4	51,452.4	-	49,654.8	48,341.4	1,313.4	24,986.8	21,989.8	2,997.0
Нийт санхүүжилтийн дүн		815,428.1	811,146.7	4,281.6	879,857.7	836,262.7	43,595.0	424,290.0	413,966.7	10,323.3

Хүснэгтээс харахад: Музей 2014 онд 2,946.4 мянга, 2015 онд 11,314.4 мянга, 2016 оны эхний хагас жилд 3,909.5 мянга, Номын сан 2014 онд 1,335.2 мянга, 2015 онд 3,647.9 мянга, Шивээговь сумын Соёлын төв 2015 онд 1,313.4 мянга, 2016 оны эхний хагас жилд 2,99.0 мянга, Боржигон чуулга 2015 онд 27,319.3 мянга, 2016 оны эхний хагас жилд 3,067.1 мянган төгрөгийг тус тус хэмнэж ажилласан байна.

Соёл, урлагийн байгууллагууд 2016 оны эхний хагас жилийн байдлаар 424,290.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 413,966.7 мянган төгрөгийг зарцуулж, 10,323.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар хэмнэгдсэн төсвийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Зардлын зүйл	Байгууллагын нэр					Нийт дүн
		Боржигин чуулга	Баянтал сумын СТ	Шивээговь сумын СТ	Музей	Номын сан	
1	Үндсэн цалин	1.0	92.6	2,733.5	892.6	-	3,719.7
2	Тогтмол зардал	2,337.1		113.8	2,000.7		4,451.6
3	Бараа үйлчилгээний зардал	729.0	257.1	149.7	1,016.2	-	2,152.0
Дүн		3,067.1	349.7	2,997.0	3,909.5	-	10,323.3

Хүснэгтээс харахад: Цалингийн зардал 3,719.7 мянга, тогтмол зардал 4,451.6 мянга, бараа үйлчилгээний зардал 2,152.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тухайлбал: Боржигин чуулга нь халаалтын өглөгийн тооцоог цаг хугацаанд нь харилцагч байгууллагад шилжүүлээгүй, шинээр уран бүтээлийн ажил хийгдээгүйгээс уран бүтээлийн зардал хэмнэгдсэн, бол Шивээговь сум Соёлын төв дуу, хөгжмийн багшийн орон тоонд мэргэжлийн ажилтан авч ажиллуулаагүй, сургуулийн хөгжмийн багшид 40 хувиар хавсруулан ажиллуулсанаас цалингийн сан хэмнэгдсэн, Баянтал сумын Соёлын төв нь уран бүтээлийн зардлыг 12 сард тэнцүү хувааж бага хэмжээгээр хуваарилснаас шалтгаалан хэмнэлттэй мэт харагдаж байна.

3.3.3. Соёл, урлагийн зарим байгууллагын санхүүгийн сахилга бат сул байгаагаас цалин, шагнал урамшуулалтай холбоотой 86 108.1 мянган төгрөгийн зөрчил гаргасан байна.

Соёл, урлагийн байгууллагуудын 2014-2016 оны цалингийн сан нийт төсвийн 72.8 хувийг эзэлж байгаа бөгөөд цалингийн сангийн төсөв 2014 онд 592,361.9 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 592,361.9 мянга, 2015 онд 643,223.1 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 625,733.5 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 312,339.6 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 308,619.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Соёл, урлагийн байгууллагуудын 2014-2015 оны цалингийн сангийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийн харьцуулалтын шинжилгээг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	2014		2015		Харьцуулалт	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Төсөв 2015/2014	Гүйцэтгэл 2015/2014
1	Боржигин чуулга	411,798.3	411,798.3	447,240.7	433,127.9	8.6%	5.2%
2	Номын сан	62,940.9	62,940.8	66,572.5	66,551.9	5.8%	5.7%
3	Музей	49,892.3	49,892.2	55,665.1	52,308.9	11.6%	4.8%
4	Баянтал сумын Соёлын төв	33,865.2	33,865.2	36,872.4	36,872.4	8.9%	8.9%
5	Шивээговь сумын Соёлын төв	33,865.2	33,865.2	36,872.4	36,872.4	8.9%	8.9%
Дүн		592,361.9	592,361.9	643,223.1	625,733.5	43.8%	33.5%

Хүснэгтээс харахад: 2015 онд Соёл, урлагийн байгууллагуудын цалингийн сангийн батлагдсан төсөв өмнөх оныхоос нийт дүнгээрээ 43.8 хувиар өссөн ба байгууллага тус бүрийн хувьд авч үзвэл Боржигин чуулгад 8.6 хувиар, Номын санд 5.8 хувиар, Музейд 11.6 хувиар, Баянтал сумын Соёлын төв болон Шивээговь сумын Соёлын төвүүдэд тус бүр 8.9 хувиар тус тус нэмэгдэж батлагдсан байна.

Цалингийн сангийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн хувьд өмнөх оныхоос Боржигин чуулгын, гүйцэтгэл 5.2 хувиар, Номын сангийн гүйцэтгэл 5.7 хувиар, Музейн гүйцэтгэл 4.8 хувиар, Баянтал сумын Соёлын төвийн гүйцэтгэл 8.9 хувиар, Шивээговь сумын Соёлын төвийн гүйцэтгэл 8.9 хувиар тус тус өссөн байна.

Аудитын явцад Соёл, урлагийн байгууллагуудын 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар ажиллагсдад олгосон цалинг холбогдох баримт материалтай тулган баталгаажуулахад дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Боржигин чуулга:

- Боржигин чуулга нь цалингийн сангийн төсвөө илүү батлуулан авч нийт 58,373.9 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал: хоол унааны зардалд 2014 онд 4,716.4 мянга, 2015 онд 48,434.0 мянган төгрөгийг тус тус илүү, 2015 онд цалингийн зардлаас ажлын хөлсөнд 2,423.5 мянга, тэтгэмжийн зардалд 1,050.0 мянга, 2016 онд тэтгэмжийн зардалд 1,750.0 мянган төгрөгийг шилжүүлэн тус тус олгосон,
- 2014 онд ажиллагсдын ээлжийн амралтын мөнгө болон ажилласан хугацааны цалинг давхардуулан тооцож, нийт 797.5 мянган төгрөгийг олгосон, 2014 онд ажиллагсдын цалингийн урьдчилгаа 1,260.0 мянга, 2016 оны эхний хагас жилд олгосон цалингийн урьдчилгаа 1,630.0 мянган төгрөгийг тус тус тайлан тэнцэлд авлагаар тусгалгүй, шууд зардалд хааж бичсэн,
- 2014-2016 онд нягтлан бодогч болон няравт балансын урамшуулал нийт 2,488.4 мянган төгрөгийг хүчингүй болсон сайдын тушаалыг үндэслэн олгосон,
- Маркетингийн менежерт балансын урамшуулал 388.5 мянган төгрөгийг олгосон байна.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж тайлагнах” 6 дугаар зүйлийн 6.4.2-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулдаг байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ыг зөрчиж илүү бодож олгосон 797.5 мянга, Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.1.3-д “дараа тайлан гаргахаар итгэмжлэл буюу бусад баримт бичгээр хүлээн авсан эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг эргүүлж төлөөгүй”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчиж ажиллагсдад олгосон урьдчилгааг суутган тооцоогүй 1,260.0 мянга, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2006 оны 192 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, тэдгээрийн эрх үүрэг, ажилд томилох, чөлөөлөх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 “Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж, улирлын болон жилийн санхүүгийн тайлан, тэнцэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь чанартай, бүрэн гаргаж, өр авлагагүй ажилласан төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам”-ын дагуу шагнаж урамшуулна” гэснийг зөрчин 388.5 мянга, нийт 2,446.0 мянган төгрөгийг холбогдох эздээр нь төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, дээрх зөрчил, дутагдлыг жил

бүр давтан гаргасан нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Баянтал сумын Соёлын төв:

- Баянтал сумын Соёлын төвийн эрхлэгчийг “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдсан тул ССАЖГ-ын даргын тушаалаар дагалдах мөнгөн шагналд 100.0 мянган төгрөг олгосон боловч Баянтал сумын Засаг даргын 2014 оны Б/13 дугаар тушаалаар дахин нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал буюу 469.1 мянган төгрөгийг давхардуулан олгосон,
- 2014-2015 онуудад ажиллагсад ур чадварын нэмэгдлийг олгохдоо Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4-р хавсралтын 2, 8 дугаар заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс ажилтнуудын жилийн ажлын гүйцэтгэлийг бодитой дүгнэлгүйгээр нийт 3,272.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон,
- Баянтал сумын Соёлын төв нь батлагдаагүй орон тоонд ажилтан авч ажиллуулан 2014 онд 11,883.9 мянга, 2015 онд 5,478.1 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 2,444.3 мянга, нийт 19,806.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Мөн цалингийн зардлаас 2014 онд 754.0 мянга, 2015 онд 1,459.6 мянга нийт 2,213.6 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.

Шивээговь сумын Соёлын төв:

- Шивээговь сумын Соёлын төв нь батлагдаагүй орон тоонд 2 ажилтан авч ажиллуулан 2014 онд 5,037.8 мянга, 2015 онд цалин зардлаас ажлын хөлсөнд 2,700.0 мянган төгрөгийг тус тус олгож, төсвийн үргүй зардал гаргасан байна.

Эдгээр нь Монгол Улсын ЗГ-ын 1997 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2-д “дагалдан мөнгөн шагналын хэмжээ нь ЗГ-ын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгээр шагнахад 100.000 төгрөгийн мөнгөн шагналыг нэг удаа олгоно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, гэснийг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

3.3.3 Соёлын байгууллагууд авлага, өглөгийг баталгаажуулан үнэн зөв бүртгэж тайлагнасан байна.

Аймгийн Боловсрол, соёлын салбарын хэмжээнд 2014 онд авлага 11,610.4 мянга, өглөг 12,403.4 мянга, 2015 онд авлага 11,605.8 мянга, өглөг 261,084.6 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар авлага 6,370.3 мянга, өглөг 467,624.4 мянган төгрөгөөр тус тус бүртгэгдэж тайлагнагдсан байна.

Боловсрол, соёлын салбаруудын авлага, өглөгийг ЕБС, СӨБ, соёлын байгууллага тус бүрээр нь задлан харуулбал:

№	Байгууллагын нэр	2014 он		2015 он		2016 оны эхний хагас жилийн байдлаар	
		авлага	өглөг	авлага	өглөг	авлага	өглөг
1	ЕБС	9,902.1	991.2	4,886.2	226,160.2	2,573.1	398,809.1
2	СӨБ	1,515.7	10,685.2	3,077.0	5,763.0	3,183.9	30,280.1
3	Соёлын байгууллага	2.4	-	-	22,259.7	-	36,402.8

4	Боловсрол соёлын газар	190.2	727.0	4,642.6	6,901.7	613.3	2,132.4
Нийт дүн		11,610.4	12,403.4	11,605.8	261,084.6	6,370.3	467,624.4

Боловсрол соёлын газар нь 2014 онд авлага, 190.2 мянга, өглөг 727.0 мянга, 2015 онд авлага 4,642.6 мянга, өглөг 6,901.7 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар авлага 613.3 мянга, өглөг 2,132.4 мянган төгрөг байна.

Авлага 2015 онд өмнөх оныхоос 4,452.4 мянган төгрөгөөр өссөн нь зарцуулалтын эрх нээгдээгүйгээс санхүүжилтийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Харин өглөг өмнөх оныхоос 6,174.7 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь түлш халаалтын зардал дутуу батлагдсантай холбоотой байна.

Аймгийн Соёл, урлагийн байгууллагууд 2014 онд 2.4 мянган төгрөгийн авлагатай, өглөггүй байсан бол 2015 онд 23,846.8 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 36,402.8 мянган төгрөгийн тус тус өглөгтэй гарсан байна.

2014 онд 2.4 мянган төгрөгийн авлагатай, өглөггүй, 2015 онд 22,259.7 мянга, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 36,402.8 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Соёл, урлагийн байгууллагуудын 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаарх өглөгийн судалгааг хүснэгтээр харуулбал:

				/мян.төг/
№	Байгууллагын нэр	2014	2015	2016
1	Боржигин чуулга	-	1,920.1	4,187.9
2	Баянтал сумын Соёлын төв		12,154.6	19,614.7
3	Шивээговь сумын Соёлын төв		8,185.0	12,579.0
4	Музей		-	21.2
5	Номын сан		-	
Нийт өглөгийн дүн			22,259.7	36,402.8

Хүснэгтээс харахад: 2015 онд нийт өглөгийн 54.6 хувийг Баянтал сумын Соёлын төв, 36.8 хувийг Шивээговь сумын Соёлын төв, 8.6 хувийг Боржигин чуулга тус тус эзэлж байна. Нийт өглөгийн 91.4 хувь буюу 20,339.6 мянга төгрөгийг сумдын Соёлын төвийн халаалтын өглөг эзэлж байна.

2016 онд нийт өглөгийн 53.9 хувийг Баянтал сумын Соёлын төв, 34.6 хувийг Шивээговь сумын Соёлын төв, 11.5 хувийг Боржигин чуулга, 0.06 хувийг Музей тус тус эзэлж байгаа бөгөөд өглөгийн 88.4 хувь буюу 32,193.7 мянга төгрөгийг сумдын Соёлын төвийн халаалтын өглөг эзэлж байна.

2015-2016 онд өглөгийг жил бүр нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулдаг байх", 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх сумдын халаалтын зардлын төсвийг бодит тоо мэдээлэл, харилцагч байгууллагын нэхэмжлэл инкасс, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн үнэн зөв бодитой төлөвлөж, батлуулан өглөг үүсгэхгүй ажиллах тухай зөвлөмжийг аймгийн БСГ, сумдын ЗДТГ-дад өгөхөөр шийдвэрлэв.

Боловсрол,соёлын салбарын үйл ажиллагаа холбогдох хууль эрх зүйн хүрээнд хэрэгжиж байна үү?

Бүлэг 4

Зарим цэцэрлэгийн эрхлэгч солигдсоноос 2015 он жилийн эцэст үр дүнгийн гэрээгээ дүгнүүлээгүй байна.

4.1.1 ЕБС-уудын удирдлага үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулсан байна.

Аймгийн Ерөнхий боловсролын 5 сургуульд 2014 онд нийт 271 багш, ажиллагсад ажилласны 33.2 хувь буюу 90 нь захиргаа аж ахуйн ажилтан, 66.8 хувь буюу 181 нь багш нар, 2015 онд нийт 279 багш, ажиллагсад ажилласнаас 32.9 хувь буюу 92 нь захиргаа аж ахуйн ажилтан, 67.1 хувь буюу 187 нь багш нар, 2016 онд 279.5 багш, ажиллагсад ажилласны 92 нь захиргаа аж ахуй, 187.5 нь багш нар тус тус байна.

Сургуулиудын захирлаас бусад ажилчдын хөдөлмөрийн харилцаа хөдөлмөрийн гэрээгээр зохицуулагддаг бөгөөд бүх багш, ажиллагсадтай хууль тогтоомжийн дагуу үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Жил бүр хагас, бүтэн жилээр гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж ажилласан байна.

Аудитын явцад Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу ЕБС-уудын хувийн хэргийн бүрдүүлэлтийн баримт материалд шалгалт хийхэд дараах нийтлэг зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан буюу удирдлага солигдсон байхад гэрээний өөрчлөлтүүд хийгдээгүй байна. Тухайлбал: Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн захирал өөрчлөгдөөд 11 сар болж байгаа боловч бүх ажилчдын гэрээ, ажлын байрны тодорхойлолт хуучин захирлын гарын үсэгтэй байна.
- Ажилчдын ажилд орсон, ажлаас чөлөөлөгдсөн шийдвэр байхгүй /бүх сургууль/
- Мэргэжлийн гэрчилгээ буюу дипломны хуулбар нотариатаар баталгаажаагүй /тухайлбал Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн бүх ажилчид/
- Багшлах эрхийн үнэмлэх хугацаа сунгаагүй /Сүмбэр сумын 1-р сургуульд 9/
- Багшлах эрхийн үнэмлэх хувийн хэрэгт байхгүй /Сүмбэр сумын 1-р сургууль 20/
- Эрүүл мэндийн хуудас бөглүүлээгүй /бүх сургууль/
- Хувийн хэргийн зураг дутуу /Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 40/
- Төрийн албан хаагчийн анкетын нэмэлт өөрчлөлтийг өөр өнгийн балаар хийх буюу шинэчлэлт хийгдээгүй зэрэг зөрчил дутагдлууд илэрлээ.

4.1.2 ЕБС-уудад зарим мэргэжлийн багш дутагдалтай байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 8 мэргэжлээр 19 багш дутагдалтай байна. Үүнд: Гадаад хэлний багш 6, бага ангийн багш 4, математикийн багш 4, хими биологи, физик, мэдээлэл зүй, технологи, дуу хөгжмийн багш тус бүр нэг нэг дутагдалтай байна.

ЕБС-уудад дутагдалтай багш нарын судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Сургуулиудын нэр	Математик	Гадаад хэл	Монгол хэл	Бага анги	технолог	Хими биологи	Физик, мэдээлэл зүй	Дуу хөгжим	Нийт тоо
1	1-р сургууль		3		1	1				5
2	2-р сургууль	2			1					3
3	3-р сургууль	1	1		1				1	4
4	4-р сургууль						1	1		2
5	5-р сургууль	1	2	1	1					5
Нийт дүн		4	6	1	4	1	1	1	1	19

Дээрх судалгаанаас үзэхэд 8 мэргэжлийн 19 багш дутагдалтай байгаагийн 42.1 хувь нь гадаад хэлний багш, 21.1 хувь нь математикийн багш, 21.1 хувь нь бага ангийн багш бол 15.7 хувь нь бусад мэргэжлийн багш байна.

Аудитын явцын тулган баталгаажуулалтаар Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн технологийн багш СУИС-ийн ДУДС төгссөн “зураач” мэргэжилтэй, Шивээговь сумын 3 дугаар сургуулийн “дуу хөгжим”-ийн багш нар багшлах эрхийн үнэмлэхгүй ажиллаж байна.

Сүмбэр сумын 1 дүгээр сургуульд зэрэг дэвийн хугацаа дууссан багш 1, зэрэг дэвийн үнэмлэхийн хуулбар 32 багшийн хувийн хэрэгт хавсаргаагүй байна.

Мөн ЕБС-уудад 2016 оны байдлаар нийт 187 багш ажиллаж байгаагаас зөвлөх зэрэгтэй багш байхгүй бөгөөд 64.7 хувь буюу 121 багш нь мэргэжлийн ямар нэгэн зэрэг дэвтэй байна.

Аймгийн ЕБС-уудын багш нарын зэрэг дэвийг судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Сургуулиудын нэр	Тэргүүлэх	Арга зүйч	Магистар	Бусад	Бүгд	Зэрэгтэй багшийн эзлэх хувь
1	1-р сургууль	13	20	4	17	54	68.5
2	2-р сургууль	8	13	1	13	35	62.8
3	3-р сургууль	7	15	2	10	34	58.8
4	4-р сургууль	2	6		5	13	61.5
5	5-р сургууль	10	16	4	21	51	70.6
Нийт дүн		40	70	11	66	187	64.7


Судалгаанаас үзэхэд нийт багш нарын 21.4 хувь буюу 40 багш тэргүүлэх, 37.4 хувь буюу 69 багш арга зүйч, 7.6 хувь нь буюу 14 багш магистар зэрэгтэй байна.

Иймд багш нарын мэргэжлийн түвшин, ур чадварыг дээшлүүлэх, дутагдалтай байгаа нарийн мэргэжлийн багш нарыг бэлтгэх, олж ажиллуулах асуудлыг зохион байгуулж ажиллах зөвлөмжийг аймгийн БСГ-т өгөхөөр шийдвэрлэв.

4.2.1 Сүмбэр сумын 2, 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч солигдсоноос шалтгаалан 2015 оны үр дүнгийн гэрээг жилийн эцэст дүгнүүлээгүй байна.

Аймгийн цэцэрлэгүүдийн эрхлэгч хуулийн дагуу аймаг, сумдын Засаг дарга болон БСГ-ын даргатай жил бүрийн эхэнд үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан ба гэрээг хагас бүтэн жилээр дүгнүүлж ажилласан байна. Харин Сүмбэр сумын 2, 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч солигдсоноос 2015 оны үр дүнгийн гэрээгээ жилийн эцэст дүгнүүлээгүй байна.

2014-2015 онд Цэцэрлэгүүдийн эрхлэгч нарын үр дүнгийн гэрээг дүгнэсэн байдлыг графикаар харуулбал:




Графикаас харахад: Сүмбэр сумын 1, 2 дугаар цэцэрлэг 89,0-93,0 хувьтай дүгнэгдсэн бол Шивээговь сумын 3, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг 81,0-89,0 хувьтай дүгнүүлсэн байна. Сүмбэр сумын 2, 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч 2015 онд солигдсон бөгөөд шинээр ажил авсан эрхлэгч оны эцэст үр дүнгийн гэрээгээ дүгнүүлж ажиллаагүй байна.

4.2.2 2014-2016 онд аймгийн СӨББ-ууд мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан байна.

2014-2016 онд аймгийн хэмжээний Улсын цэцэрлэгүүдийн хувьд мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан байна. СӨББ-уудад 2014-2016 онуудад нийт 119 багш, ажиллагсад ажилласнаас 31.0 хувь нь үндсэн багш, 29.0 хувь нь туслах багш, 36.0 хувь нь нягтлан бодогч, нярав, тогооч, жижүүр, үйлчлэгч гэх мэт үйлчилгээний ажилтан байна.

Аймгийн Цэцэрлэгийн нийт ажиллагсдыг боловсролын түвшин, мэргэжлээр нь ангилан диаграммаар харуулбал:

**Улсын цэцэрлэгүүдийн боловсон хүчний судалгаа,
боловсролын түвшин /2016 он/**



Диаграмаас харахад нийт ажиллагсдын 4.0 хувийг удирдлага, 60.0 хувийг багш, 36.0 хувийг үйлчилгээний ажилтан ажиллаж байгаа бол боловсролын түвшингээр нь авч үзвэл: 46.0 хувь нь дээд, 10.0 хувь нь бүрэн дунд, 14.0 хувь нь тусгай дунд, 3.0 хувь нь бүрэн бус дунд, 27.0 хувь нь курс, дамжаа буюу сургалтын төвд мэргэжил эзэмшсэн ажилтнууд байна.

4.2.3. СӨББ-ууд ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж 1 хувийг ажилтны хувийн хэрэгт хадгалсан байна.

СӨББ-уудын багш, ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтууд холбогдох хууль, журам, зааврын дагуу боловсруулагдсан байна. Тухайлбал: Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг 2014 онд, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг 2015 онд, Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэг, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгүүд 2016 онд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг тус тус шинэчлэн боловсруулж, холбогдох ажилтанд танилцуулан гарын үсэг зуруулж 1 хувийг тухайн ажилтанд, үлдэх хувийг уг ажилтны хувийн хэрэгт хадгалсан байна.

Аудитын явцад Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу цэцэрлэгүүдийн хувийн хэргийн бүрдүүлэлтийн баримт материалд шалгалт хийхэд дараах нийтлэг зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Хөдөлмөрийн гэрээг хавсаргаагүй, гэрээний сунгалт бүрэн хийгдээгүй /Сүмбэр сумын 1, 2, 5 дугаар цэцэрлэг/
- Ажиллагсдын ажилд томилогдсон, цалингийн өөрчлөлт орсон болон ажлаас чөлөөлөгдсөн шийдвэр байхгүй /бүх цэцэрлэг/
- Мэргэжлийн гэрчилгээ буюу дипломын хуулбар нотариатаар баталгаажуагүй /Сүмбэр сумын 1, 2, 5 дугаар цэцэрлэг/
- гурван үеийн намтарт гарын үсэг зуруулаагүй
- иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргаагүй,
- Багшлах эрхийн үнэмлэх хувийн хэрэгт байхгүй / Сүмбэр сумын 1-р сургууль 20/
- Эрүүл мэндийн хуудас бөглүүлээгүй /бүх сургууль/
- Хувийн хэргийн цээж зураг дутуу /Цэцэрлэгүүд/
- Төрийн албан хаагчийн анкетын нэмэлт өөрчлөлтийг өөр өнгийн балаар хийх буюу шинэчлэлт хийгдээгүй байна.
- Ажиллагсдын дипломын хуулбарыг нотариотоор баталгаажуулаагүй,

Сүмбэр сумын 1,2,5 дугаар цэцэрлэгүүдийн ажиллагсдын хувийн хэрэгт дипломын хуулбарыг нотариатаар батлуулалгүй хийсэн, хөдөлмөрийн гэрээг хавсаргаагүй, сунгалт дутуу хийсэн, төрийн албан хаагчийн анкетийг шинэчлээгүй, 5 дугаар цэцэрлэгийн хувийн хэрэгт анкетыг өнгийн бал хольж бөглөсөн зэрэг хувийн хэргийн иж бүрдэл дутуу байна.

Мөн багшлах эрхийн үнэмлэхгүй багшийг үндсэн багшаар, туслах багшийн үнэмлэхгүй хүнийг туслах багшаар ажиллуулсан бөгөөд жирэмсний амралтай болон чөлөө авсан багшийн оронд түр ажиллуулсан байна.

Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч зарим ажилтанд 1-2 сарын цалингүй чөлөө олгохдоо өргөдөлд цохолт хийж, тушаал гаргалгүй олгосон боловч оронд нь хүн авч ажиллуулахдаа түр ажиллуулах тушаал гаргасан байна.

Эдгээр нь Төрийн албан зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг зөрчсөн байна.

Цаашид дээрх журмын дагуу ажиллагсдын хувийн хэргийг бүрэн бүрдүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

4.2.4. СӨББ-уудын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дотоод журам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг зэрэг бодлогын баримт бичгүүд нь НББОУС болон түүнд нийцүүлэн гаргасан үндэсний стандарт, холбогдох хууль журамд нийцэхгүй байна.

Цэцэрлэгүүд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй боловч уг НББББ нь НББОУС болон түүнд нийцүүлэн гаргасан үндэсний стандарт, холбогдох хууль журамд нийцэхгүй байна.

НББББ-ийг стандартад нийцэхгүй байгаа тул салбарын хэмжээнд шинэчлэн боловсруулж, мөрдүүлж ажиллах тухай жил бүрийн аймгийн Аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмжүүдийг өгсөн бөгөөд аймгийн БСГ-аас нэгдсэн журмаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахаар шийдвэрлэсэн гэх боловч одоогоор шинэчлэн боловсруулсан журам гараагүй байна.

Цэцэрлэгүүд тус бүртээ дотоод журам боловсруулан эрхлэгчийн тушаалаар баталгаажуулан үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч уг дотоод журмуудад тусгагдсан зарим нэг тэтгэмж, буцалтгүй тусламж олгохтой холбоотой заалтууд нь цэцэрлэгүүдийн тухайн тайлант жилийн батлагдсан төсөв, санхүүжилтээс давсан өндөр дүнтэй байгаа тул төсөв хэтрэх, авлага, өглөг үүсэх шалтгаан болж байна.

Иймд салбарын хэмжээнд НББОУС болон түүнд нийцүүлэн гаргасан үндэсний стандарт, холбогдох хууль журам, салбарын болон байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн НББББ-ийг боловсруулан, батлуулж мөрдөх, мөн байгууллагуудын дотоод журамд салбарын хэмжээнд мөрдөж буй нэгдсэн бодлогуудыг тусгаж, тэтгэмж, буцалтгүй тусламжуудыг тухайн тайлант оны батлагдсан төсөв, санхүүжилттэйгээ уялдуулах, эсвэл төсөв нь батлагдсан тохиолдолд гэсэн заалтыг оруулах мэтээр шинэчлэн боловсруулж, мөрдүүлэн ажиллах тухай зөвлөмжийг аймгийн БСГ болон цэцэрлэгүүдийн удирдлагад өгөхөөр шийдвэрлэв.

4.3.1 БСГ-ын удирдлага нь 2014 онд ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулаагүй байна.

Соёлын байгууллагуудын эрхлэгч нараас бусад ажилчдын хөдөлмөрийн харилцаа хөдөлмөрийн гэрээгээр зохицуулагддаг бөгөөд ажиллагсадтай хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Боловсрол, соёлын газрын дарга нь 2014 онд аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан боловч үр дүнгийн гэрээний биелэлтээ дүгнүүлж, үнэлүүлээгүй байна. Мөн Боловсрол, соёлын газрын дарга тус онд ажиллагсадтай 2014 оны үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж ажиллаагүй байна.

2015 онд Боловсрол соёлын газрын дарга аймгийн Засаг даргатай үйл ажиллагааны үр дүнгийн гэрээг байгуулж, гэрээний биелэлтийг дүгнүүлж ажилласан ба үр дүнгийн гэрээний хэрэгжилтээр 86 % буюу “В” үнэлгээ авч, цалингийн 80.0 хувиар үр дүнгийн урамшуулал авсан байна.

Мөн 2015-2016 онд Боловсрол, соёлын газрын дарга нь ажиллагсадтай үр дүнгийн гэрээ байгуулж, 2015 оны жилийн эцэст гэрээний биелэлтийг дүгнэж, ажиллагсад үр дүнгийн урамшуулал олгосон байна.

4.3.2 Аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын нийт ажилтны 25.6 хувь нь бүрэн дунд буюу курс төгссөн, ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг хангаагүй мэргэжлийн бус ажилчид байна.

Аймгийн Соёл, урлагийн байгууллагуудад нийт 84 ажилтан ажиллаж байгаагаас 30 ажилтан буюу 35.7 хувь нь бүрэн дунд буюу курс төгссөн, ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг хангаагүй мэргэжлийн бус ажилчид байна. Тухайлбал:

- Аймгийн Боловсрол, соёлын газарт 2015-2016 онд орон тоо дутуу ажилласан, Боловсрол, соёлын газар нь мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаж ажиллаагүй байна. 2015, 2016 оны эхний хагас жилийн байдлаар хүмүүнлэгийн ухааны мэргэжилтний орон тоо дутуу байгаа тул мэргэжлийн бус ажилтан уг ажлыг хавсран гүйцэтгэж байна.
- Боржигин чуулгад 28 ажилтан бүрэн дунд, мэргэжлийн дипломгүй, мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байгаа, ихэнх ажиллагсад дипломын хуулбарыг нотариотоор баталгаажуулаагүй, төрийн албан хаагчийн анкетийг дутуу бөглөсөн, шинэчлээгүй, 2 өнгийн бол хольж бичсэн, 2 хувь цээж зураг байхгүй, намтар бичихдээ хөл толгой байхгүй, гарын үсэг зураагүй, нэмэлт хуудас дутуу бөглөсөн,
- Музей нь эрдэм шинжилгээний ажилтан, музейн тайлбарлагч, боловсролын ажилтны орон тоонд ажлын байрны шаардлага хангаагүй, мэргэжлийн бус хүнийг ажиллуулсан,
- Номын сан нь 2014-2016 онуудад ном сэлбэн засагчийн орон тоонд ажлын байрны шаардлага хангаагүй, мэргэжлийн бус хүн ажиллуулсан,

5.1 2014-2016 онуудад аймгийн БСГ-аас Боловсрол, соёлын салбарын байгууллагуудад хэрэгжүүлж байгаа дотоод хяналт, шалгалт хангалтгүй байна.

2014-2015 онуудад Боловсрол, соёлын газраас ЕБС, СӨБ-ын байгууллагуудад дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн гэх боловч хяналт шалгалтын ажлын тайлан болон түүнийг нотлох анхан шатны баримт байхгүй, ямар шалгалт хийсэн эсэх нь тодорхойгүй байна.

Аймгийн Боловсрол соёлын газрын даргын 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн В/04 дүгээр тушаалаар дотоод хяналтын ажилтнаар Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн С.Энх-Амгаланг томилсон бөгөөд дотоод хяналт шалгалтыг улирал тутамд хийж ажлын тайланг танилцуулж байхаар үүрэг болгосон боловч 2012 оноос хойш хийсэн ажлын тайлан байхгүй, төлөвлөгөө хөтөлбөр боловсруулж ажиллаагүй, тус газарт дотоод хяналт байхгүй байна.

Боловсрол соёлын салбарын дотоод хяналт байхгүйгээс хүүхдийн тоо болон хувьсах, тогтмол зардлуудыг өсгөж төлөвлөж, батлуулсан, хоолны орц, норм, нормативыг ЗГ-ын тогтоосон норм, нормативаас илүү зарцуулж, өртгийг нь өсгөсөн, батлагдсан төсвийн санхүүжилтийг үр ашиггүй зарцуулсан, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, төсөв хэтрүүлсэн мэргэжлийн ажилтны заагдсан орон тоонд мэргэжлийн бус ажилтан авч ажиллуулсан, эсвэл уг орон тооны ажлаас өөр ажил хийж гүйцэтгүүлсэн, зарим байгууллагууд холбогдох хууль эрх зүйн актуудыг зөрчсөн зэрэг нилээдгүй эрсдэлүүд гарсан байна.

Мөн аймаг, сумдын төрийн сангаас анхан шатны баримтын бүрдүүлэлт болон зардлын зүйл ангийг хяналгүйгээр ажил гүйлгээг хийсэнээс шалтгаалан зөрчил гаргах, зардлыг зориулалт бусаар зарцуулах нөхцөл бололцоог бий болгосон байна.

Боловсрол, соёлын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 26-13 ГСА маркийн УАЗ Фургон машин нь хадгалалт, хамгаалалтын шаардлага хангаагүй дээвэргүй гражид байрлуулснаас шалтгаалан шатсан байна.

Энэ нь тус байгууллагын удирдлага болон санхүү бүртгэлийн ажилтнуудын ажлын хариуцлага сул, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалтад бүртгэлээр хяналт тавьж ажиллаагүй зэргээс шалтгаалсан байна. Иймд тус байгууллагын удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнууд болон эд хариуцагч нарт хариуцлага тооцуулахаар шийдвэрлэв.

БСГ болон Боловсролын салбарын байгууллагуудын архивын баримтууд эмх цэгцгүй, зарим баримт материалыг архивлаагүй, зарим баримт материал алга болсон зэргээр аудитын явцад баримт материал үзэхэд хүндрэлтэй байлаа.

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.-д “.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна

Иймд Боловсрол, соёлын газраас салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг тогтмол хийж, дотоод хяналтын ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил дутагдал болон хөндлөнгийн хяналтын байгууллагуудын

шалгалтаар илэрсэн алдаа зөрчил, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмжийг аймгийн БСГ-ын удирдлагад өгөхөөр шийдвэрлэв.

Мөн аймгийн ЕБС, СӨББ, Соёл, урлагийн байгууллагуудын удирдлагын зүгээс байгууллагынхаа санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж, байгууллагын өмч, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, төсөв санхүүгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд бүртгэлээр тавих хяналтыг шат шатандаа сайжруулж, төсвийн үр өгөөж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж ажиллах зөвлөмжийг өгөхөөр шийдвэрлэв.

5.2 Соёл, урлагийн байгууллагууд аймгийн Аудитын газраас болон Санхүүгийн хяналт, аудитын албаны хийсэн шалгалтын мөрөөр хийх ажил, илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аймгийн Аудитын газраас болон Санхүүгийн хяналт, аудитын алба болон бусад хяналтын байгууллагаас хийсэн шалгалтын мөрөөр хийх ажлын болон илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой төлөвлөгөө гаргаж, уг төлөвлөгөөний дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулж ажиллаагүй байна. Тухайлбал:

Аймгийн Боржигон чуулгын 2014-2015 оны санхүүгийн баримтанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийхэд гарсан зөрчил дутагдлыг засаагүй ба аудитаар уг зөрчил дахин давтан гарсан байна.

Мөн Шивээговь сумын Соёлын төвийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хийсэн хяналт, шалгалтаар нийт 460.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн төлбөрийн акт тогтоож 5 зөвлөмж өгсөн бөгөөд зөрчлийг арилгах талаар ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 925,015.2 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэнээс 48,569.6 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 472,679.1 мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, 403,766.4 мянган төгрөгийн зөрчил, дутагдалд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Нийт зөрчил, дутагдлыг салбараар нь харуулбал:

- ЕБС-уудад нийт 701,326.8 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрснээс 20,249.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 416,186.7 мянган төгрөгийн албан шаардлага, 264,890.4 мянган төгрөгийн зөвлөмж,
- СӨББ-уудад нийт 52,609.6 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрснээс 22,850.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,292.5 мянган төгрөгийн албан шаардлага, 28,466.4 мянган төгрөгийн зөвлөмж,
- Соёл, урлагийн байгууллагуудад нийт 171,078.7 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрснээс 5,469.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 55,199.9 мянган төгрөгийн албан шаардлага, 110,409.6 мянган төгрөгийн зөвлөмж өгөхөөр тус тус шийдвэрлэв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

- Боловсрол, соёлын салбарын төсвийг, өмнөх оны гүйцэтгэл, бодит тоон мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэн үнэн, зөв төлөвлөж, батлуулдаггүй, салбарын төсвийн хуваарилалтад ил тод, тэгш хуваарилалтын зарчмыг баримтлаагүйгээс салбарын байгууллагуудын төсөвт 7-8 удаа өөрчлөлт орсон боловч эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй байна,
- ЕБС–ууд стандартын дагуу ашиглавал зохих хүчин чадлаа дунджаар 144.2 хувь буюу 595 хүүхдээр хэтрүүлэн ажиллаж байгаа нь тус аймагт шинээр 1 ЕБС-ийг барьж, байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

- Ашиглалтад ороогүй цэцэрлэгүүдэд хамрагдах хүүхдийн тоог ажиллаж байгаагаар тооцож, орон тоо, төсвийг нь батлуулан авсанаас 250 хүүхдээр илүү тооцож, төсвөө батлуулсан байна.
- Бараа үйлчилгээний бусад зардлын батлагдсан төсөв ЕБС болон СӨББ-уудын хэвийн үйл ажиллагааг хангахад хүрэлцэхгүй байна.
- Аймгийн Боловсрол, соёлын салбарын хэмжээнд тогтмол зардлыг илүү, дутуу төлөвлөж, батлуулсан, тогтмол зардлын төсвийг бодит тоон мэдээлэл, өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэн батлуулж, хуваарилахгүй байгаа нь төсөв хэтрэх гол шалтгаан болжээ.
- БСУШЯ-ны Төсвийн ерөнхийлөн захирагчийн хасаж тодотгосон төсвийг аймгийн ИТХ-ын төсвийн тодотголоор нэмэгдүүлэн баталж, хуваарилсан байна.
- Ашиглалтанд ороогүй Канад цэцэрлэгт жил бүр төсөв батлуулан авч, ЕБС болон СӨББ-уудын батлагдсан төсөв дээр нэмж хуваарилаж байгаа нь батлагдсан төсвийг хэтрүүлэх, зориулалт бусаар зарцуулах, төсвийн үр өгөөжийг бууруулах зэрэг сөрөг үр дагаварыг бий болгож байна.
- 2015 онд ЕБС болон СӨББ-уудын батлагдсан төсвийн санхүүжилтийг нийт 167,897.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.
- ЕБС-уудад хэрэгжүүлж буй “Цөм” хөтөлбөртэй холбоотойгоор батлагдсан орон тооноос 8 багш, СӨББ-ууд 6 багш тус тус илүү ажиллуулсан, “Цөм” хөтөлбөр, “Лаборатори” сургуулийн нэмэгдлүүдтэй холбоотой батлагдаагүй цалин, нэмэгдэл урамшууллыг олгосноос цалингийн зардал хэтэрсэн байна
- ЕБС-уудын анги дүүргэлт 2014-2016 онд 76.2-78.4 хувьтай байгаа нь БСШУ-ны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 тоот хамтарсан тушаалаар баталсан журмаар тогтоосон норм, нормативыг хангахгүй байна.
- ЕБС-уудын үйлчлэгч нарын цалин, цэвэрлэх талбай, ажлын ачаалал өөр өөр байгаа бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2001 оны 48 дугаар тушаалаар баталсан “Үйлчлэгчийн ажлын үлгэрчилсэн норм”-ыг баримталж ажиллаагүйгээс үйлчлэгч нарын ажлын хэмжээ, цалин хөлс салбарын хэмжээнд харилцан адилгүй байна.
- ЕБС-ууд батлагдсан төсвөө бүрэн зарцуулсан боловч, батлагдсан төсвөөс илүү 147,920.6 мянган төгрөгийн зардал гаргаж, өглөг үүсгэж төсөв хэтрүүлсэн, авлага, өглөгийг баталгаажуулан үнэн зөв бүртгэж, тайлагнасан боловч санхүүжилтийг нь бодитой хуваарилаагүйгээс их хэмжээний өглөг үүссэн, авлага, өглөгийг барагдуулж ажиллаагүй байна.
- Боловсрол, соёлын байгууллагууд хүчингүй болсон журмыг үндэслэн эд хариуцагч нарт урамшуулал олгосон, үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг харгалзахгүй хавтгайруулан олгосон байна.
- БСГ-аас цэцэрлэгүүдийг нэгдсэн удирдамжаар хангаж ажиллаагүйгээс багш, ажиллагсдад олгож буй илүү цагийн хөлсийг цэцэрлэг бүр өөр өөрийн үзэмжээр олгосон байна.
- Боловсрол, соёлын байгууллагууд ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа боловч хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсөв батлагдаагүй байхад зардал гаргаж, холбогдох заавар, журмыг зөрчин цалингийн сангийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан байна.
- ЕБС-ийн хувьсах зардал тооцдог норм, норматив нь бодит хэрэгцээ шаардлагад нийцээгүй, мөн хүүхдийн үдийн цай хөтөлбөр болон дотуур байрны хоолны материалыг бэлтгэхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөж ажиллаагүйгээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй шууд гэрээ байгуулан материалын үнийг шилжүүлсэн боловч авлага үүсгэн бүртгэж тайлагнаагүй, мөн уг хоолны

материалыг хүлээн аваагүй мөртлөө хүнсний материалын тайланд хий орлого авч, бараа материалын үлдэгдлийн дүнг бодит бусаар өсгөж, тайлан тэнцлийг буруу илэрхийлсэн, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж гүйцэтгэсэн байна.

- Соёл, урлагийн зарим байгууллагууд үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн байна.
- Сумдын Соёлын төв батлагдсан орон тооноос илүү ажилтан ажиллуулсан, мөн батлагдсан ажлын байранд мэргэжлийн хүн авч ажиллуулаагүй байна.
- Соёл, урлагийн зарим байгууллагын санхүүгийн сахилга бат сул байгаагаас цалин, шагнал урамшуулалтай холбоотой зөрчлийг давтан гаргасан байна.
- ЕБС, СӨББ-уудын удирдлага үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулсан боловч зарим цэцэрлэгийн эрхлэгч солигдсоноос шалтгаалан 2015 оны үр дүнгийн гэрээг жилийн эцэст дүгнүүлээгүй байна.
- ЕБС-уудын хэмжээнд зарим мэргэжлийн багш дутагдалтай байгаагаас тэтгэвэр тогтоолгосон 9 багш, ажилтан ажиллаж байгаа бол СӨББ-ууд мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан байна.
- Аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын нийт ажилтны 25.6 хувь нь бүрэн дунд буюу курс төгссөн, ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг хангаагүй, батлагдсан орон тоонд мэргэжлийн бус ажилчид ажиллуулсан байна.
- Боловсрол, соёлын салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дотоод журам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг зэрэг бодлогын баримт бичгүүд нь НББОУС болон түүнд нийцүүлэн гаргасан үндэсний стандарт, холбогдох хууль журамд нийцээгүй, ажиллагсдын хувийн хэргийн бүрдүүлэлт хангалтгүй байна.
- 2014-2016 онуудад аймгийн БСГ-аас Боловсрол, соёлын салбарын байгууллагуудад хэрэгжүүлж байгаа дотоод хяналт, шалгалт хангалтгүй байна
- Канад цэцэрлэгт “Боловсролыг дэмжих олон улсын түншлэлийн Сургуулийн өмнөх боловсрол төсөл”-өөс 2014 онд өгсөн нийт 53,569.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө болон бараа материалыг орлого авч бүртгэж, тайлагнаагүй, мөн тус цэцэрлэгийн нэр дээр хүүхдийн оюун ухааны тоглоомууд ирсэн боловч уг тоглоомуудыг БСГ-аас хэн хүлээн авсан, хичнээн тоглоом байгаа талаар холбогдох баримт материал нь олдохгүй байгаагаас гадна уг тоглоомуудыг аль нэг байгууллагын дансанд бүртгэж, эзэнжүүлээгүй, мөн хүлээлцсэн тухай холбогдох акт баримт байхгүй байна.
- Боловсрол, соёлын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 26-13 ГСА маркийн УАЗ Фургон автомашин нь хадгалалт, хамгаалалтын шаардлага хангаагүй дээвэргүй гражид байрлуулснаас шалтгаалан шатсан бөгөөд тус байгууллагын удирдлага болон санхүү, бүртгэлийн ажилтнуудын ажлын хариуцлага сул, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалтад бүртгэлээр хяналт тавьж ажиллаагүй байна.
- БСГ-ын удирдлага, санхүү бүртгэлийн ажилтнууд болон бусад холбогдох ажил хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлага сул, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт байхгүй, мөн салбарын дотоод хяналт ажиллахгүй байна.
- Аймгийн БСГ-аас салбарын байгууллагуудыг нэгдсэн бодлого, удирдлага, арга зүйгээр бүрэн хангаж ажиллаагүйгээс төсөв, санхүү, бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчил дутагдал гарч, санхүүгийн сахилга бат суларсан байна.
- Аймаг, сумдын төрийн сангаас анхан шатны баримт болон зардлын зүйл ангийг хянахгүй гүйлгээг хийсэнээс зөрчил гаргах, зардлыг зориулалт бусаар зарцуулах нөхцлийг бүрдүүлсэн байна.

- Соёл, урлагийн байгууллагууд аймгийн Аудитын газраас болон Санхүүгийн хяналт, аудитын албаны хийсэн шалгалтын мөрөөр хийх ажил, илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Боловсрол, соёлын салбарын төсвийг, өмнөх оны гүйцэтгэл, бодит тоон мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэн үнэн, зөв төлөвлөж, батлуулах, салбарын төсвийн хуваарилалтад ил тод, тэгш хуваарилалтын зарчмыг баримтлах, өглөг, авлага үүсгэхгүй байх, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд салбар дотроо зохицуулалт хийж ажиллах,

2. ЕБС–ууд стандартын дагуу ашиглавал зохих хүчин чадлаа дунджаар 144.2 хувь буюу 595 хүүхдээр хэтрүүлэн ажиллаж байгаа тул шинээр 1 ЕБС-ийг барьж, байгуулах шаардлага байгаад анхаарч холбогдох саналыг дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, мөн Канад цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллах,
3. БСГ-аас салбарын байгууллагуудыг нэгдсэн бодлого, удирдлага, арга зүйгээр бүрэн хангаж ажиллаагүйгээс төсөв, санхүү, бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчил дутагдал гарч, санхүүгийн сахилга бат суларсан тул холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох,
4. Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй ЕБС болон СӨББ-уудын удирдлагуудад хариуцлага тооцох, сэлгэн ажиллуулах,
5. Аймаг, сумдын төрийн сангаас анхан шатны баримтын бүрдүүлэлт болон зардлын зүйл ангийг хянахгүй гүйлгээг хийснээс зөрчил гаргах, зардлыг зориулалт бусаар зарцуулах нөхцлийг бүрдүүлсэн тул холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох

АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГАД:

1. Боловсролын салбарын төсвийн төлөвлөлтийг хийхдээ зөвхөн цалин, НДШ-ийг хувьсах зардлаар тооцож, бусад зардлыг газар, нутгийн байршил, онцлог нөхцлийг харгалзан төлөвлөн, батлуулж, хуваарилдаг байх тухай хүсэлтийг дээд шатны буюу ТЕЗ болон ТТЗ-дад хүргүүлж, шийдвэрлүүлэх,
2. Боловсрол, соёлын салбарын төсвийг бодитой тоон мэдээлэл, өмнөх оны гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж, батлуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, салбарын төсвийн хуваарилалтад ил тод, тэгш хуваарилалтын зарчмыг баримтлах, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, үргүй зардал гаргахгүй байх, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, өглөг, авлага үүсгэхгүй ажиллах,
3. ЕБС-уудын анги дүүргэлтийг тогтоосон нормативын дагуу зохион байгуулах, анги дүүргэлт, сурагчдын тоог харгалзан бүтэц орон тоо, төсөв, санхүүжилтийг нь батлуулж, олгож байх
4. Багш нарын мэргэжлийн түвшин, ур чадварыг дээшлүүлэх, нарийн мэргэжлийн багш дутагдалтай байгаа нь суралцагчдын сурлагын чанарт сөрөг нөлөөтэй тул дутагдалтай байгаа мэргэжлийн багш нарыг бэлтгэх ажлыг бодлогын түвшинд зохион байгуулах, хөдөлмөрийн насны багш, ажилтан авч ажиллуулах,
5. Салбарын болон байгууллагын хэмжээнд үйлчлэгч нарын ажлын ачааллыг стандарт, норм нормативийн дагуу тогтоож, ажлын ачааллыг тэнцвэржүүлж, хэт өндөр ачаалалтай ажиллаж байгаа үйлчлэгч нарын ажлын ачааллыг багасгах, цалин хөлсний тэнцвэртэй биш байдалд анхаарч, тодорхой арга хэмжээ авч ажиллах,
6. ЕБС-уудад хоолны өдөрлөгийн анхан шатны маягтыг салбарын хэмжээнд холбогдох журам зааврын дагуу нэг хэвийн маягтаар бүрэн хөтөлж, хэвших, хоолны зарцуулалтад шат шатны хяналтыг тавьж, нэгдсэн бодлого, арга зүйгээр хангаж ажиллах,
7. Сургуулиудын хяналтын зөвлөлийн ажлыг тогтмолжуулан, үдийн цай хөтөлбөрийн чанар хүртээмжийг сайжруулах,
8. Дотуур байрны хоолны материал, болон үдийн цай хөтөлбөрийн бэлтгэн нийлүүлэгчийг сургууль бүр дээр нь ТБОНӨХБАҮХАТ хууль болон холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах.

9. Худалдан авалт хийхдээ холбогдох хууль, журмын дагуу бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудыг сонгон шалгаруулж, чанар стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэж байх,
10. Канад цэцэрлэгийг ашиглалтад ортол нэр дээр нь ирсэн хөрөнгүүдийн анхан шатны баримтуудыг тухайн үед ажил хариуцаж байсан, хүлээн авсан холбогдох албан тушаалтан, ажилтануудаас авч, БСГ-ын хөрөнгөнд түр бүртгэж, эзэнжүүлэн, хяналт тавьж ажиллах, хэрэв холбогдох баримт бичиг олдохгүй тохиолдолд БСШУЯ-ны төсөл хариуцсан холбогдох мэргэжилтнээс баримтыг нөхөн авах, мөн 2016 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор уг хөрөнгүүдийг тооллогод бүрэн хамруулж, бүрэн бүтэн байдлын тооцоог бодож, бүртгэл, тайланд тусгах,
11. Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, батлагдсан орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд анхаарч ажиллах
12. СӨББ-уудын илүү цагийн цалинг системийн хэмжээнд нэг ижил болгож, хариуцлагын тогтолцоог сайжруулах, зөрүүтэй олгогдож байгаа илүү цагийн хөлс болон багшлах эрх, мэргэжлийн зэрэг, заах арга зүйчийн мэргэжлийн зэрэг олгох, тэтгэмж, тусламж олгох зэрэг бодлогын шинж чанартай асуудлуудыг холбогдох хууль эрх зүйн акт, журам, зааврын дагуу дотоод журам, НББББ зэрэг салбарын хэмжээний бодлогын баримт бичигт тусган нэгдсэн нэг бодлого, арга зүйгээр хангаж ажиллах,
13. ЕБС болон СӨББ-уудад хүнсний материалыг 1 сараас хэтрэхгүй нөөцтэй байлгах,
14. Соёл, урлагийн байгууллагын удирдлагуудад батлагдсан орон тооноос илүү ажилтан авч ажиллуулахгүй байх, батлагдсан орон тоонд мэргэжлийн ажилтан авч ажиллуулах, төсвийн үргүй зардал гаргахгүй байхад бодлогын түвшинд анхаарч нэгдсэн арга, зүйгээр хангаж ажиллах
15. Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу ажиллагсдын хувийн хэргийг бүрэн бүрдүүлж ажиллах,
16. Боловсрол, соёлын газраас салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг тогтмол хийж, дотоод хяналтын ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил дутагдал болон хөндлөнгийн хяналтын байгууллагуудын шалгалтаар илэрсэн алдаа зөрчил, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах,

ЕБС, СӨББ болон СУБ-уудын удирдлагад:

1. Төсвийг бодитой тоон мэдээлэл, өмнөх оны гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж, батлуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, үргүй зардал гаргахгүй байх, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, өглөг авлага үүсгэхгүй ажиллах,
2. Ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомж зөрчиж, төсөв нь батлагдаагүй, цалингийн сангийн зардлаас зориулалт бусаар зарцуулахгүй байх,
3. Сангийн сайдын 2002 оны 210 дугаар тушаалаар батлагдсан “Санхүү, бүртгэлийн ажилтнуудад тэдний үйл ажиллагааны үр дүнг үндэслэн шагнал, урамшуулал олгох тухай” журам нь Сангийн сайдын 2006 оны 192 дугаар

- тушаалаар хүчингүй болж, урамшуулал олгохгүй болсон тул эд хариуцагч нарт олгох урамшууллыг ажлын үр дүн, ур чадварыг харгалзан олгож байх,
4. Соёл, урлагийн байгууллагууд үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, батлагдсан орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх, орлогыг нэр төрлөөр нь ангилан бүртгэж, үнэт цаас буюу билетийг сумын Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулж тооцоо хийж ажиллах,
 5. Байгууллагын хэмжээнд үйлчлэгч нарын ажлын ачааллыг стандарт, норм нормативийн дагуу тогтоож, ажлын ачаалалыг тэнцвэржүүлж, хэт өндөр ачаалалтай ажиллаж байгаа үйлчлэгч нарын ажлын ачааллыг багасгах, цалин хөлсний тэнцвэртэй биш байдалд анхаарч, тодорхой арга хэмжээ авч ажиллах,
 6. БСГ болон ЕБС-уудад хоолны өдөрлөгийн анхан шатны маягтыг салбарын хэмжээнд холбогдох журам зааврын дагуу нэг хэвийн маягтаар бүрэн хөтөлж, хэвших, хоолны зарцуулалтад шат шатны хяналтыг тавьж, нэгдсэн бодлого, арга зүйгээр хангаж ажиллах,
 7. Дотуур байрны болон хүүхдийн хоолны материал, үдийн цай хөтөлбөрийн бэлтгэн нийлүүлэгчийг ТБОНӨХБАҮХАТ хууль болон холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах,
 8. Хүнсний материалыг 1 сараас хэтрэхгүй нөөцтэй байлгах, мөн холбогдох эд хариуцагчыг ажлаас чөлөөлөгдөхөд ажил хүлээлцэх комисс томилон ажлыг нь хүлээлцүүлж байх, мөн хариуцсан эд хөрөнгийн тооллого хийн, тооцоог нь бодож, зөрүү гарсан тохиолдолд төлбөр тооцоог нь барагдуулж байж ажлаас чөлөөлж байх,
 9. Соёл, урлагийн байгууллагууд батлагдсан орон тооноос илүү ажилтан авч ажиллуулахгүй байх, батлагдсан орон тоонд ажлын байрны шаардлага хангасан, мэргэжлийн ажилтан авч ажиллуулах, төсвийн үргүй зардал гаргахгүй байх,
 10. Сургуулиудын хяналтын зөвлөлийн ажлыг тогтмолжуулан, үдийн цай хөтөлбөрийн чанар хүртээмжийг сайжруулах,
 11. Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу ажиллагсдын хувийн хэргийг бүрэн бүрдүүлж ажиллах,
 12. Удирдлагын зүгээс байгууллагынхаа санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж, байгууллагын өмч, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, төсөв санхүүгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд бүртгэлээр тавих хяналтыг шат шатандаа сайжруулж, төсвийн үр өгөөж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж ажиллах,

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

42211 Чойр, Говьсүмбэр аймаг, утас 7054 3160

E-mail: govsumber@mecs.gov.mn

2016.12.01 № 231

төний - нм № - 3

Санал, тайлбар хүргүүлэх тухай

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН

АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн тайланд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, Аймгийн засаг даргын 2011 оны А/274 дугаар захирамжийн дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгохтой холбоотой зардлыг жил бүрийн төсвийн төсөлд санал өгдөг боловч санхүүжилт ирдэггүйн улмаас албан хаагчдад тусламжийг олгох боломжгүй нөхцөл үүсдэг болно.

2. Сургууль, цэцэрлэг, Соёлын төв, Нийтийн номын сан, орон нутгийн музей зэрэг байгууллагууд нь санал, тайлбаргүй бөгөөд Боржигин чуулгын нягтлан бодогч Д.Мөнхцэцэгийн тайлбарыг хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.МӨНХЗУЛ

Д.Дикунбат

А.Отгонпүрэв нэгд

1. Бүхэлтэй танилцуулга
саналын тухай
танилцуулга

2. Боржигон чуулганы
нэгдлийн танилбарыг
сүүлийн танилбар
танилцуулга

МЧ

Аудитын дүгнэлтийн тайлбар

Боржигин чуулга нь 2009 оноос хойш жил бүрийн аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авч байсан ч цагийн баланс , тооцоо худал гарснаас болж ээлжийн амралтын зөрүүнд акт тавигдсан байна. Энэхүү цагийн баланс , тооцооны зөрүүг арилгахаар байгууллагын удирдлага болон хүний нөөцийн менежерт анхааруулж зөвлөсөн боловч нягтлан бодогч миний зөвлөмжийг үл хэрэгжүүлснээс болж цагийн тооцооны зөрүүг залруулж арилгаж чадахгүй байна.....

Тус чуулгын хувьд цагийн тооцоог хүний нөөцийн менежер хянах журамтай байсан. Үүнийг 2016 оноос эхлэн байгууллагын дотоод журамд хүний нөөцийн менежерээр цагийн тооцоог хийлгэхгүй гэж заасан ч ХНМ дур мэдэн ажилчдад чөлөө олгож , цагийн тооцоог үндэслэлгүй бүрүү хянах гэх мэтчилэн нягтлан бодогчийн болон санхүүгийн ажлыг хийлгэхгүй алдаа зөрчилд удаа дараа оруулж байгаад Аудитын байгууллагын зүгээс анхаарч үзэхийг хүсч байна.

Миний бие нь Хүний Нөөцийн Менежерийн бүрүүтай үйлдлээс болж аудитын дүгнэлтээр хариуцлага тооцуулах нь үндэслэлгүй харин Хүний нөөцийн ажилтанд хариуцлага тооцох нь зөв гэж үзэж байна.

Иймд Боржигин чуулгын бодит байдлыг харгалзан аудитын дүгнэлтийг гаргана үү.

Тайлбар бичсэн

Нягтлан бодогч:

Д.Мөнхцэцэг

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР:

Танай байгууллагаас ирүүлсэн албан бичиг, актын тайлбартай танилцаад дараахь тайлбарыг хийж байна. Үүнд:

1. Нэг удаагийн тэтгэмж, тусламжийг төсөв нь батлагдаагүй тохиолдолд олгохгүй байх, холбогдох хууль тогтоомж, заавар журмыг баримтлан ажиллах нь зүйтэй.
2. Аймгийн Боржигин чуулга нь жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар алдааг давтан гаргаж, төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул хариуцлага тооцох асуудлаар аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна.